- 몽골 정부 공식 법령·정책 정보 포털, Засгийн газрын тогтоол, “ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207743> (인출일: 2025. 6. 8).
- 몽골 정부 공식 법령·정책 정보 포털, Сайдын тушаал, ЭХИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=204563> (인출일: 2025. 6. 8).
- 몽골 보건부 산하 Ömnögov.gov 주 보건국 사이트, “ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ. <https://om.mohs.gov.mn/images/resource/d9aa58519b48ac9bc9196f5291451e28.pdf> (인출일: 2025. 6. 8).



## **Development and Implementation Strategies of an International Knowledge Sharing Program Model for Maternal and Child Health**

Jaehee Lee, Ahreum Kim, Ja Yeun Koo, Jiwon Eom,  
Hee Sun Kim, Jeong Rim Lee , In Sook Sohn, Yun Noo Lee, Hye Ri Jung

This study explores the international knowledge-sharing collaboration between Korea and Mongolia in the field of maternal and child health, with a focus on strengthening Mongolia's maternal and child health capacity and establishing a sustainable ecosystem for knowledge sharing. Leveraging Korea's advanced experiences and policies in supporting mothers and infants, the project aims to contribute to improving the health and well-being of women and children in Mongolia, while concurrently creating export opportunities for Korean childcare-related products and services.

Mongolia was selected as a partner country due to its significant challenges in healthcare and socio-economic disparities. The nation faces a public health infrastructure deficit characterized by lower nurse-to-population ratios compared to OECD countries and limited access to quality maternal and child healthcare services. These factors are compounded by income inequality and uneven distribution of healthcare resources. The Mongolian government has adopted the "Maternal and Reproductive Health National Program," which outlines key goals in improving healthcare access, quality, health education, and

monitoring systems specific to mothers and young children.

The study employed a multidisciplinary approach encompassing policy analysis, field surveys including in-depth interviews with Mongolian mothers, and cooperation with local institutions such as the Mongolian National University of Medical Sciences and district offices. The needs assessment revealed critical demands for postpartum care support, maternal psychological support, newborn care education, public postpartum care infrastructure, enhanced cash support policies for mothers and infants, and systems targeting high-risk pregnancies and children with rare diseases.

In response, a comprehensive knowledge-sharing model was developed. It considers not only the transfer of technical know-how but also aligns strategies with Mongolia's institutional framework, cultural context, and infrastructure capabilities, ensuring high applicability and sustainability. Key components of the model include:

- Development of manuals and educational materials for training maternal and newborn health managers, adapted from Korean standards and localized Mongolian health documents.
- Capacity building through three rounds of postpartum care policy consulting sessions involving Mongolian obstetricians, policymakers, and health personnel. These sessions introduced Korea's legal systems, operational frameworks for postpartum care, voucher-based service delivery, quality assurance mechanisms, and educational curricula for health managers.
- Establishment of cooperative networks among Korean and Mongolian stakeholders to facilitate ongoing knowledge exchange and program evaluation.

- Organization of international seminars and business expos aimed at linking Korean childcare product manufacturers with the Mongolian market, fostering export opportunities. The two-day expo attracted approximately 1,520 visitors and generated sales valued around 20 USD (approximately 280 million KRW), showing promising market interest.
- Formulation of future plans to develop public postpartum care center support, postpartum depression support systems, infant care support policies, and integration of data and AI technologies into knowledge-sharing programs.

The implementation underscored the importance of contextualizing knowledge-sharing initiatives within local health systems and culture, as well as securing human resources and institutional support for sustainable development. The case further demonstrated that knowledge-sharing could extend beyond technical assistance to include economic cooperation through product and service export integration.

Although the collaboration achieved notable strides in policy exchange and market linkage, challenges remain, including expanding linkages to domestic companies for developing childcare products and ensuring long-term operational sustainability of postnatal care workforce training. Policymakers are encouraged to continue fostering multi-sector partnerships, enhance data-driven program development, and devise frameworks that support continuous monitoring, evaluation, and policy feedback loops.

In conclusion, this international knowledge-sharing project serves as a valuable model for development cooperation in maternal and child health. It highlights how tailored, culturally sensitive knowledge transfer combined with economic collaboration can improve health outcomes in partner countries while creating export avenues for home-country industries. Future directions will focus on refining program components

based on monitoring results and exploring innovative technologies such as AI to further enhance maternal and infant care services in Mongolia.


Keyword: Maternal and Child Health, Knowledge Sharing Program (KSP), Postpartum Care, International Development Cooperation, Mongolia

## 부록 1. 몽골 산모·신생아 건강관리사 양성 교육 매뉴얼(몽골어)

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны  
мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

# Эх болон нярайн эрүүл мэндийн асаргаа ЭХНЭЭС НЬ ДУУСТАЛ

Ким Хисон · И Жонgrim · Сон Ин Сок · Жон Хери · И Юнжу



## Contents

### I. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

<b>1. Нярайн онцлог</b>	<b>2</b>
1) Гадаад төрхийн онцлог ба дасан зохицол	2
2) Физиологийн болон мэдрэхүйн онцлог ба дасан зохицол	6
3) Рефлекс	7
<b>2. Нярай болон бага насны хүүхдийг арчлах</b>	<b>9</b>
1) Биеийн халууныг халгалах	9
2) Хүйг арчлах	10
3) Хүүхдийг усанд оруулах	11
4) Шээх ба өтгөн гадагшлуулах	14
5) Арьс арчилгаа	14
6) Хүүхдийн нойр	16
7) Хүүхдийн хувцас угаах	18
8) Хүүхдийн хумс арчилгаа	19
<b>3. Нярай болон бага насны хүүхдийн хэвийн бус шинж тэмдгүүд</b>	<b>19</b>
1) Халуурах	20
2) Амьсгалын хүндрэл	22
3) Бөөлжих	22
4) Шингэн алдалт	23
5) Өтгөний байдал	23
6) Улаан шээс	24
7) Нүдэнд нулимсны ялгасас үүсэх	24
8) Шарлалт	24
9) Ивэрхий	26
10) Атопийн дерматит	27
11) Мөгөөрсөн хоолойн төрөлхийн нарийсал	28
12) Амны салстны мөөгөнцөр	28
13) Нярайн гэдэс базлалт	29
14) Нярайн аюулгүй байдлын менежмент	30



Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргаа — эхнээс нь дуустал

## I. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

<b>4. Нярай болон нэг хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн менежмент</b>	<b>34</b>
1) Энерги	34
2) Уураг, нүүрс ус, өөх тосны зөвлөмж хэмжээ	35
3) Шингэн	35
4) Эрдэс	35
5) Витамин	36
<b>5. Хөхүүдэх</b>	<b>37</b>
1) Эхийн сүүгээр хооллох	37
2) Эхийн сүүгээр хооллох арга	39
3) Нэмэлт тэжээл	42
4) Холимог хооллолт	46
5) Хөхний сүү болон нэмэлт тэжээлийн зохицуулалт	47
6) Хоолдох хэрэгслийг ариутгах	49
<b>6. Хүүхэдтэй харилцаа холбоо тогтоох</b>	<b>50</b>
1) Хүүхэдтэй сэтгэл зүйн холбоо тогтоох	50
2) Хүүхдийн уйлах шалтгааныг ойлгож, тайвшруулах	52
3) Хүүхдийг ойлгох	53
4) Хүүхдийн ааш зангийн онцлогийг ойлгох	54
5) Хүүхдийн зан чанарт тохируулан хүмүүжүүлэх	55
6) Хүүхэдтэй тоглох	56
<b>7. Нярайн дархлаажуулалт</b>	<b>57</b>
1) Вакцинжуулалтын хуваарь	57
2) Төрсний дараах 1 сарын дотор хийх шаардлагатай вакцин	57
3) В гепатит	58
4) BCG вакцин	58
5) Вакцин хийлгэх үед анхаарах зүйл	59

## Contents

### II. Эхийн эрүүл мэндийн арчилгаа

<b>1. Бие махбодын өөрчлөлт ба дасан зохицол</b>	<b>62</b>
1) Хязангийн өвдөлт	62
2) Шавхрага	63
3) Умай сэргэх үйл явц	65
4) Төрсний дараах өвдөлт	67
5) Шээх үйл ажиллагаа	68
6) Өтгөн гаргах үйл явц	69
7) Суух ванн	70
8) Усанд орох ба Шүдээ угаах	71
9) Төрсний дараах хаван	72
10) Хөлрөх	73
<b>2. Төрсний дараах биеийн эрүүл мэнд</b>	<b>73</b>
1) Төрсний дараах халууралт	73
2) Халдвар	74
3) Аарцаг болон нурууны өвдөлт	76
4) Төрсний дараах цус алдалт	77
5) Гематом	79
6) Аарцгийн ёроолын булчингийн гэмтэл	79
<b>3. Төрсний дараах сэтгэцийн эрүүл мэнд: Сэтгэл санааны өөрчлөлт</b>	<b>79</b>
1) Төрсний дараах гуниг (postpartum blue) ба төрсний дараах сэтгэл гутрал	80
2) Төрсний дараах сэтгэцийн эмгэг	81
3) Сэтгэл гутралаас сэргийлэх арга	82
4) Төрсний дараах сэтгэл гутралтай эхийг дэмжих гэр бүлийн арга замууд	83
<b>4. Эхийн эрүүл мэндийн үнэлгээний тойм</b>	<b>83</b>



Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргаа — эхнээс нь дуустал

## II. Эхийн эрүүл мэндийн арчилгаа

<b>5. Хөхүүлэлтийн эхлэл</b>	<b>85</b>
1) Хөхний өөрчлөлт	86
2) Хавтгай болон хонхойсон хөхний товч	86
3) Амжилттай хөхүүдэлт	87
4) Хөхүүлэх зөв хөхүүлэх 6 алхам	89
<b>6. Хөхүүлэлтэд дасан зохицох</b>	<b>90</b>
1) Сүү гоожих үед	90
2) Хөхний толгойн төөрөгдөл (Nipple Confusion)	90
3) Хөхүүлэхтэй холбоотой хүндрэлүүд	91
4) Хөхүүдэлт ба хооллолт	96

## Contents


### III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

<b>1. Эхийн хоол тэжээлийн менежмент</b>	<b>100</b>
1) Хөхүүлж буй эхийн тэжээлийн хэрэгцээ	100
2) Хөхүүлж буй эхийн эрүүл хооллолтын менежмент	105
3) Төрсний дараах таргалалтын менежмент	110
4) Төрсний дараах эрүүл мэндийг дэмжихийн тулд хоолны дэглэм баримтал	111
5) Эрүүл төрсний дараах хоол хүнс бэлтгэх	113
<b>2. Төрсний дараах дасгал хөдөлгөөний менежмент</b>	<b>117</b>
1) Төрсний дараах дасгал хөдөлгөөн ба биеийн идэвхтэй байдал	117
2) Дасгалын удирдамж ба зөвлөмжүүд	118
3) Төрсний дараах дасгал хөдөлгөөн эхлэх хугацаа	119
4) Дасгал хийхэд хориглох заалт	119
5) Дасгал хийхдээ анхаарах зүйлс	120
6) Хөхүүл эхийн дасгал	121
7) Жирэмслэлтээс үүдэлтэй өөрчлөл ба дасгал	121
8) Бэлтгэл дасгал	124
9) Сунгалтын дасгал	125
10) Төрсний дараах дасгал	126
11) Аэробик дасгал	128
12) Дасгалын дараах тайвшруулах дасгалын арга, ач холбогдол	129



Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны  
мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргаа — эхнээс нь дуустал



Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны  
мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргаа — эхнээс нь дуустал



# I

## Нярайн эрүүл мэндийн арчилгаа

1. Нярайн онцлог
2. Нярай болон бага насны хүүхдийг арчлах
3. Нярай болон бага насны хүүхдийн хэвийн бус шинж тэмдгүүд
4. Нярай болон нэг хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн менежмент
5. Хөхүүлэх
6. Хүүхэдтэй харилцаа холбоо тогтоох
7. Нярайн дархлаажуулалт

## I • Нярайн эрүүл мэндийн арчилгаа

### 1 Нярайн онцлог

Нярай үе гэдэг нь төрснөөс хойш 4 долоо хоног хүртэлх хугацаа юм. Нярай хүүхэд нь насанд хүрэгчдээс олон талаар ялгаатай онцлогтой ба гадаад төрх, бие махбодийн үйл ажиллагаа, мэдрэхүйн онцлог болон рефлексийн үйлдлүүдийг тайлбарлаж, хүүхдийг илүү сайн ойлгоход туслах зорилготой болно.

#### 1) Гадаад төрхийн онцлог ба дасан зохицол

##### ① Биеийн байрлал


- Ургийн хувьд умайн давчуу орчинд 9 сарын турш гар, хөлийг нугалсан байрлалтай байдаг тул төрсний дараа ч эхийн хэвлийд байсан шиг тохой, өвдөгөө нугалсан байрлалыг авдаг.
- Гар, хөлийг нь тэнийлгэсэн ч удалгүй буцаад анхны байрлал руугаа ордог нь хэвийн үзэгдэл юм.
- Цаг хугацаа өнгөрөхийн хирээр үе мөчний хөдөлгөөн идэвхжиж, булчингийн хүч нэмэгдэхэд гар, хөл нь аяндаа тэнийдэг.



[Зураг 1] Нярайн биеийн байрлал


② Толгой ба зулайн хэсэг

- Нярай хүүхдийн зулай бүрэн битүүрээгүй төрдөг. Толгойн урд болон ард зөөлөн хэсэг байдаг бөгөөд урд хэсгийг их зулай, ар хэсгийг бага зулай гэж нэрлэнэ.
- Гурвалжин хэлбэрийн бага зулай нь төрснөөс хойш 3 сарын дотор битүүрдэг бол түүнээс том хэмжээтэй их зулай нь 1 жил 6 сар хүртэл битүү байх нь бий.
- Зулай удаан битүүрч байна гээд санаа зовох хэрэггүй бөгөөд зүгээр л гараараа дарж, гэмтээхгүй байхыг анхаарах хэрэгтэй, цаг хугацааны явцад байгалийн жамаар битүүрнэ.



[Зураг 2] Их зулай ба бага зулай

- Нярайн толгой овойж хавдсан мэт харагдах нь төрөлтийн үед ургийн толгой дарагдаж, хуйханд хаван үүссэнтэй холбоотой бөгөөд үүнийг **төрлөгийн хаван** гэж нэрлэдэг. Энэ нь төрснөөс хойш 3-4 хоногийн дотор шимэгдэж арилна.
- Толгой дээр нь зөөлөн овойсон юм тэмтрэгдэх нь судас хагарч, гавлын яс болон хатуу бүрхүүл (хальс) хооронд цус хуримлагдсанаас үүсдэг бөгөөд үүнийг **гавал ясны дээрх цус хуралт** гэж нэрлэнэ. Энэ нь төрснөөс хойш 3-6 долоо хоногийн дотор аяндаа арилдаг.



[Зураг 3] Төрлөгийн хаван ба гавлын ясны дээр цус хурсан байдал

③ Хүзүү ба цээж

- Хүзүү богино, олон арьсны нугалаастай, цээж нь бөөрөнхий, толгойноос арай жижиг бөгөөд 2 талд ижил хэмжээтэйэй байна.
- Хүзүүний булчин бүрэн хөгжөөгүй тул төрснөөс хойш 3-4 сар хүртэл толгойгоо дааж чадахгүй, тиймээс хүүхдийг тэврэх эсвэл байрлалыг нь өөрчлөхдөө толгойг нь заавал түшиж өгөх хэрэгтэй.
- Эхийн дааврын нөлөөгөөр хөх бага зэрэг хөөж томорч эсвэл сүү гарах нь бий, энэ нь удахгүй арилна.
- Амьсгалах үед цээж нь хэвлийн хамт өргөгдөнө.

④ Хэвлий

- Хэвлийн булчин сул учраас гэдэс бөөрөнхий хэлбэртэй, бага зэрэг цүлхийсэн бөгөөд зөөлөн байна.
- Хүйс орчмын хэсэгт хүй нь харагдах бөгөөд төрсний дараах хэдхэн цагийн дотор хүй хатаж эхэлж хэмжээ нь багасан, хар өнгөтэй болж хувирна. Цэвэр, хуурай байлгавал төрсний дараах 1-2 долоо хоногийн дараа бүрэн хатаж унадаг.

⑤ Нуруу ба өгзөг

- Нярай хүүхэд нумарсан байрлалтай байдаг тул нуруу бөөрөнхий харагдана. Алхаж эхлэх хүртэл нурууны хэвийн хэлбэржилт бүрэн хөгжөөгүй байна.
- Өгзөгний хэлбэр, арьсны нугалаасууд 2 талд ижил харьцаатай байх бөгөөд хошного онгорхой байна.
- Нуруу болон өгзөг орчимд цэнхэр өнгийн “монгол толбо” харагдах ба заримдаа бугуй, шагай орчимд ч ажиглагддаг. Ихэвчлэн хүүхэд сургуульд орох насанд энэ толбо алга болдог.

⑥ Гар ба хөл

- Гар нь тохойгоор нугарсан байдалтай 2 талд ижил хөдөлгөөнтэй байдаг. Гар, хурууг бүрэн тэнийлгэхэд хурууны үзүүр гуяны дунд хүртэл хүрнэ. Гарын алга булшгар бөгөөд хуруунууд сул атгасан байрлалтай байна.
- Хөл богино, өвдгөөрөө нугарсан тул нумарсан мэт харагддаг ба гуян дээр арьсны нугалаас байна. Хөлийн ул булшгар бөгөөд урд 2/3 хэсэгтээ үрчлээтэй байдаг.

⑦ Бэлэг эрхтэн

- Эмэгтэй нярай хүүхдийн гадна бэлэг эрхтэн улайж хавдсан харагдах ба урд талд нь шээсний сүв харагдана. Ихэнх эмэгтэй нярайд эхийн дааврын нөлөөгөөр цусны толбо эсвэл салст ялгадас гарах нь бий.

I. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Эрэгтэй нярай хүүхдийн хуухнаг том, шодойн гадна хэсэг олон нугалаастай бөгөөд шодойн үзүүр нь тээрхийгээр бүрхэгдсэн байна. Хэрэв хөвч хөндсөн бол шодойн үзүүр ил гарсан байх ба бага зэрэг хаван байж болно.

⑧ Нярайн арьсыг бүрхсэн бүрхүүл (Верникс)

- Шинэ төрсөн нярайн арьс нь цагаан өнгийн бяслаг шиг тослог бодис оор бүрхэгдсэн байдаг. Энэ нь ургийн усанд хөвж байх үед арьсыг хамгаалах бүрхүүл болж, төрөлтийн үед төрөх замаар дамжин гарах хөдөлгөөнийг хөнгөвчилдөг.
- Жирэмсний сүүлийн саруудад энэхүү бүрхүүл аажмаар багасаж, төрөх үед ихэвчлэн хүүхдийн суга, цавь орчимд үлддэг. Төрсний дараа хүүхдийн эмзэг арьсыг хамгаалж чийгшүүлэх үйлчилгээ үзүүлж, усны ууршилтыг багасгана. Үүнд агуулагдах байгалийн антибиотик бодисууд нь халдвараас хамгаална.
- Хүүхдийг угаахдаа энэхүү бүрхүүлийг зориуд арчиж авах шаардлагагүй бөгөөд хүчээр арчих нь хүүхдийн нимгэн арьсыг гэмтээж болзошгүй тул зайлсхийх хэрэгтэй.
- Тосон бүрхэвч нь аяндаа хатаж, төрсний дараах 3-4 хоногоос хальс мэт гуужиж эхэлж, 1-2 долоо хоногийн дараа бүрэн алга болдог.



[Зураг 4] Нярайн хөл болон хөлийн арьсны тосон бүрхэвч

⑨ Сүүн толбо (Милия)

- Нярайн ойролцоогоор 50%-д тосны булчирхай бөглөрснөөс үүссэн цагаан эсвэл шар өнгийн будааны хэмжээтэй жижиг толбо гардаг бөгөөд үүнийг **сүүн толбо** гэж нэрлэнэ. Ихэвчлэн хацар, хамар, эрүүн дээр илэрдэг. Шахаж болохгүй бөгөөд тусгай эмчилгээ шаардалгүй хэдхэн долоо хоногийн дараа аяндаа арилна.

⑩ Үсний үлдэгдэл (Лануго)

- Ураг эхийн хэвлийд байхдаа бие нь зөөлөн, нарийн үсээр бүрхэгдсэн байдаг ба төрөх үед мөр, нуруу, гарын дээд хэсэг, хацар зэрэгт үлдсэн байх нь элбэг.

## 2) Физиологийн болон мэдрэхүйн онцлог ба дасан зохицол

### ① Нярайн биеийн халуун, амьсгал ба зүрхний цохилт

- Биеийн халууныг суганд хэмжихэд 36.4-37.2°C байх нь хэвийн бөгөөд тасалгааны температурыг тогтвортой байлгаж, нярайн биеийн халууныг хадгалах нь маш чухал.
- Амьсгалын тоо минутанд 30-60 удаа байх ба цусанд шаардагдах хүчилтөрөгчийг хангахын тулд насанд хүрэгчдээ ойролцоогоор 2.5 дахин хурдан амьсгалдаг.
- Нярай хүүхдийн зүрх нь биетэй нь харьцуулахад жижиг тул зүрхний цохилт насанд хүрэгчдээ хоёр дахин хурдан буюу минутанд 120-160 удаа цохилдог.

### ② Жин ба өндөрт гарах өөрчлөлт

- Нярайн дундаж жин 3.4 кг бөгөөд нийт нярайн 95%-д жин нь 2.5-4.2 кг байдаг.
- Төрсний дараах 4-5 хоногт төрөх үеийн жин 5-10%-иар буурдаг. Энэ нь нярайн биед хуримтлагдсан илүүдэл шингэн, зунгаг гадагшлах болон эхний өдрүүдийн шим тэжээлийн дутагдлаас шалтгаалдаг. Ойролцоогоор 2 долоо хоногийн дараа жин нь төрөх үеийн хэмжээндээ эргэн очдог.

<Хүснэгт 1> Нярайн жин ба өндөр

Хүйс	Жин(кг)	Өндөр(см)
Эрэгтэй	3.34±0.15	49.88±0.04
Эмэгтэй	3.23±0.14	49.15±0.04

### ③ Физиологийн шарлалт

- Физиологийн шарлалт нь ойролцоогоор 50%-д ажиглагддаг хөнгөн шарлалт бөгөөд төрснөөс хойш 24 цагийн дараа эхэлж, 3 дахь өдөр хамгийн хүчтэй илэрч, өөр шинж тэмдэг дагалдахгүй бол ихэвчлэн 7-10 дахь хоногт аяндаа арилна.
- Энэ нь бие махбодоос үүссэн билирубин гэх бодисыг элэг бүрэн боловсруулж чадахгүйгээс болж цусанд билирубины хэмжээ түр хугацаанд нэмэгдсэнтэй холбоотой.

### ④ Зунгаг

- Хар ногоон өнгийн, наалдамхай, үнэргүй зунгаг нь ургийн хэвлийд байхдаа залгисан ургийн ус, арьсны эд, цөс зэргээс бүрддэг ба төрсний дараах 2-3 хоногт гадагшилна.
- Дараа нь зунгаг болон шар өнгийн өтгөний холимог ногоовтор-шар өнгийн өтгөн гарч, улмаар аажмаар шар өнгөтэй энгийн өтгөнд шилжинэ.

⑤ Хордлогот улайлт

- Нярайн 30-70%-д төрсний дараахан алга, ул хэсгийг эс тооцвол бусад биений хэсэгт улаан толбо үүсч, төв хэсэгт нь жижиг цэврүү эсвэл идээт цэврүү байдаг.
- Энэ нь нярайн тууралт эсвэл атопийн дерматиттай төстэй харагддаг ч бөөгнөрөлгүй байдаг нь онцлог.
- Ихэвчлэн төрсний дараах 2-3 дахь өдөр хамгийн хүчтэй илэрч, дараагийн 2-3 хоногийн дотор аяндаа арилдаг.

⑥ Мэдрэхүйн эрхтнүүд

- **Хараа:** Нярай хүүхэд юмсыг харж чаддаг ч бүрэн ялгаж таньж чадахгүй. Хэт ойрын зүйлсээс илүү 20-30 см зайтай объектыг илүү сайн ялгана.
- Төрсний дараах 2 сар орчмоос хол зайд байгаа хурууг аажуухан хөдөлгөхөд харцаараа дагаж эхэлдэг. Гэхдээ булчин бүрэн хөгжөөгүй тул түр хугацаанд харц дотогшоо чиглэсэн мэт харагдах хиймэл хялар байдал үүсэж болно.
- Өнгө ялгах чадвар нь 4-6 сартайгаас хөгжиж эхэлнэ.
- Нулимс нь төрсний дараах 2-4 долоо хоногоос үүсч эхэлдэг тул өмнө нь уйлсан ч нулимс гардаггүй.
- **Сонсгол:** Нярайн сонсгол сайн хөгжсөн бөгөөд ургийн үедээ ч дуу чимээнд хариу үйлдэл үзүүлдэг. Нярай хүүхэд дуу чимээнд маш мэдрэмтгий тул гэнэт чанга чимээ гарвал цочдог. Хүний хоолойны дууг таашаадаг тул сэрүүн байх үед зөөлөн, намуухан хоолойгоор ярьж өгөх нь өсөлт хөгжилд нь тустай.
- **Амг, үнэр:** Нярай хүүхэд чихэрлэг, гашуун, исгэлэн амтыг ялгаж чаддаг төдийгүй үнэрийг ч ялгаж эхийн болон бусдын үнэрийг таньдаг.
- **Мэдрэхүй:** Мэдрэхүй нь сайн хөгжсөн тул өвдөлтөнд маш мэдрэмтгий, ялангуяа нүүр, гар, хөлний мэдрэхүй өндөр байдаг.



[Зураг 5] Хуурамч хялар (Псевдострабизм)

3) Рефлекс

① Хөхөх рефлекс

- Хацар, уруулаас болон амны эргэн тойронд хуруу эсвэл хөхний толгойгоор зөөлөн хүрэхэд тэр зүг рүүгээ толгойгоо эргүүлж, амаа ангайн хөхөж эхэлдэг.
- Энэ рефлекс нь төрсний дараах 5-6 сард аажмаар багасч, 1 нас хүрэхэд алга болдог.

### ② Моро рефлекс

- Хүүхдийн байрлалыг гэнэт өөрчлөх эсвэл чанга дуу гаргахад хүүхэд тэврүүлэх гэж буй мэт хоёр гараа дэлгэн урагш сунгаад удалгүй тайван байрлалд эргүүлж нугалдаг.
- Моро рефлекс нь төрсний дараах 4 дүгээр сараас багасч эхэлж, 6 сартайдаа бүрэн алга болдог.



[Зураг 6] Моро рефлекс

### ③ Атгах рефлекс

- Хүүхдийн алган дээр ямар нэг зүйл эсвэл хуруугаар хүрэхэд гараа атгаж, уланд нь хүрвэл хуруунуудаа нугалж атгадаг.
- Энэ рефлекс нь төрсний дараах 3-4 сард алга болно.


### ④ Алхах рефлекс

- Хүүхдийг босоо байрлалд барьж, хавтгай гадаргуу дээр нэг хөлийг нь хүргэхэд нөгөө хөлөө өргөж алхаж буй мэт хөдөлгөөн хийдэг.
- Энэ рефлекс нь төрсний дараах 1-2 сард арилна.

### ⑤ Хүзүү чангарах рефлекс

- Нярайн толгойг нэг тал руу эргүүлэхэд толгойгоо эргүүлсэн талын гар, хөл тэнийж, эсрэг талын гар, хөл нугардаг бөгөөд энэ нь тулааны бэлэн байдал эсвэл хийж буй мэт харагддаг тул хүзүү чангарах рефлекс гэж нэрлэнэ.
- Энэ нь төрсний дараах 2 дахь долоо хоногт илэрч эхлэн, 6 сартайд арилдаг.


1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа



[Зураг 7] Барих рефлекс, Алхах рефлекс, Хүзүүний чангаралтын рефлекс

6) Бабинскийн рефлекс

- Хүүхдийн хөлийн улыг өсгий талаас нь хурууны үзүүр рүү чиглүүлэн хуруу эсвэл үзгээр зөөлөн зурвал хөлийг тэнийлгэж, бүх хурууг дэлгэнэ.
- Энэ рефлекс нь төрсний дараах 1 нас хүрэхэд алга болно.



[Зураг 8] Бабинскийн рефлекс

2 Нярай болон бага насны хүүхдийг арчлах


1) Биеийн халууныг хадгалах

- Нярайн арьс болон өөхөн давхарга нимгэн бөгөөд биеийн хэмжээтэй харьцуулахад арьсны гадаргуугийн талбай том тул дулааны алдагдал их байдаг. Мөн биеийн халуунаа зохицуулах чадвар сул учир өрөөний температурыг 24-26°C орчимд барих хэрэгтэй.
- Биеийн халууныг хадгалах зорилгоор зузаан дэвсгэр эсвэл хэт зузаан хөнжил хэрэглэх, мөн хөнжлийг нүүр хүртэл бүтээх нь амьсгал багтрах аюултай тул зайлсхийх хэрэгтэй.

- Нярайн захын цусны эргэлт сайн хөгжөөгүй тул гар, хөл амархан даардаг ба дулаан байлгах хэрэгтэй.
- Хүүхдэд сүү өгөхөөс өмнө эсвэл живх солих үед гар, хөлд зөөлөн иллэг хийж цусны эргэлтийг сайжруулна.

## 2) Хүйг арчлах

- Хүй нь ургийн болон эхийн хоорондох цусны урсгалаар хүчилтөрөгч болон шим тэжээл дамжуулж, хүүхдийн өсөлтөд чухал үүрэгтэй.
- Хүүхэд төрсний дараа хүйг тасалж, үлдсэн хэсэг нь нярайн хэвлийд үлддэг.
- Хүйг цэвэр, хуурай байлгахын тулд усанд оруулсны дараа эсвэл шээс, баасанд бохирдсон үед нойтон алчуураар зөөлөн арчиж, 70%-ийн спиртийг самбай эсвэл хөвөнтэй модон савханд шингээж хүй хүрсэн хэсгийг арчиж өгнө.
- Живхийг хүйний доод хэсэг хүртэл өмсгөж, хүйтэй хүрэлцэгүй, бүрхэхгүй байхад анхаарна.
- Хүй нь унаж дуустал хүүхдийг усанд бүрэн дүрж угаахгүй. Хэрэв хүй бүрэн норвол арчиж хуурайшуулан, спиртээр ариутгаад бүрэн хатаана.
- Цэвэрхэн, хуурай хадгалсан хүй нь төрсний дараах 1-2 долоо хоногийн дараа аяндаа хатаж унадаг.
- Хүй унасны дараа ч шингэн ялгарах эсвэл цус гарч болох тул бүрэн эдгэх хүртэл өдөрт нэг удаа 70%-ийн спиртээр ариутгаж байх хэрэгтэй.
- Хэрэв хүйнээс идээ ялгарах, хурц үнэр гарах, эсвэл улайх шинж илэрвэл эмнэлэгт үзүүлнэ.



[Зураг 9] Хүй эдгэрч унах үйл явц

Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024). Төрсний дараах сувилгаа, тусламж үйлчилгээний гарын авлага

### 3) Хүүхдийг усанд оруулах

#### ① Усанд оруулахын өмнөх бэлтгэл

- Өдрийн турш хүүхдийн ааш зан тайван үед усанд оруулахаар төлөвлөнө.
- Усанд оруулахын өмнө хэрэглэгдэх бүх зүйлсийг (нярайн дотуур цамц, живх, ороох даавуу, хөвөнтэй модон савх, лосьон, нунтаг, спирт, самбай, алчуур, том алчуур гэх мэт) гарын дор бэлтгэнэ.
- Нярайн усанд оруулах ваннад 40°C халуун ус, зайлж угаахад зориулсан түмэнд 42°C ус, жижиг гар алчуур, том алчуур, төвийг сахисан саван бэлтгэнэ.

#### ② Үс угаах

- Хүүхдийг живхтэй нь үлдээн бусад хувцсыг нь тайлж, толгойноос бусад биенийг алчуураар ороож тэврэнэ.
- Чихэнд нь ус орохоос сэргийлж эрхий болон долоовор хуруугаараа чихний дэлбээг зөөлөн дарж бөглөнө.
- Нойтон зөөлөн даавуугаар дараах дарааллаар нүүрийг нь арчина: хөмсөг → нүдний орчим → хамар → хацар → эрүү.
  - Нүдийг дотор булангаас гадна тал руу нь арчина.
  - Нөгөө нүдийг нь арчихдаа цэвэр самбай ашиглана.
- Биений дулаан алдагдахаас сэргийлж, бүх биенийг угаахаас өмнө нярайн үсийг тусад нь ваннд угааж, алчуураар арчиж хурдан хатаана.

#### ③ Нүд арчлах

- Нярайн нулимсны булчирхай бүрэн хөгжөөгүй тул нулимс урсаж чадахгүй нүдэндээ тогтож, нүдэнд нулимсны ялгадас ихээр үүсч, нүд орчим хавдах нь элбэг.
- Нүдээ нээхэд хүндрэлтэй болох, шаргал өнгийн наалдамхай эсвэл их хэмжээний нулимс гарах нь нярайн нүдний үрэвслийн шинж байж болох тул анхааралтай ажиглах шаардлагатай.
- Нүдний үрэвслийг эмчлэхгүй удвал эвэрлэг бүрхүүл гэмтэх аюултай тул анхааралтай ажиглаж арчилна.
- Нулимсны булчирхайд иллэг хийх нь нулимс сайн гадагшлахад тусалж, булчирхайны хөгжилд дэмжлэг үзүүлэн сувгийн бөглөрлөөс урьдчилан сэргийлнэ.
- Нулимсны ялгарал байвал арчиж цэвэрлээд физиологийн давсны уусмалаар нүдийг нь арчиж цэвэрлэнэ.
  - Нүдийг арчихдаа ариутгасан самбай хэрэглэн дотор булангаас гадна булан руу арчина, нөгөө нүдийг арчихдаа шинэ самбай хэрэглэнэ.
  - Хүүхдийн нүдийг арчихын өмнө болон дараа гараа сайтар угааж ариутгаснаар хоёрдогч халдвараас урьдчилан сэргийлнэ.

- Нулимсны ялгарал хатаж наалдсан бол хүчээр хуулж болохгүй, харин физиологийн давсны уусмал шингээсэн самбайгаар хангалттай зөөлрүүлсний дараа салгаж авна.
- Нүдэнд их хэмжээний нулимсны ялгарал үүсэх эсвэл идээтэй ялгарал гарах тохиолдолд эрүүл мэндийн хариуцсан ажилтанд мэдэгдэж, нярай, хүүхдийн эрүүл мэндийн бүртгэлд тэмдэглэн, шаардлагатай бол эмчийн үзлэгт хамруулах арга хэмжээг авна.



[Зураг 10] Нярайн нүдийг арчих арга

Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024). Төрсний дараах сувилгаа, асаргааны гарын авлага

#### ④ Усанд оруулах

- Хүүхдийг усанд тав тухтай хэвтүүлээд, самбайд хүүхдийн биеийн саван шингээж зөөлөн арчина.
- Хүүхэд гараас халтирч унахгүй байхаар суганаас нь гараа шургуулан аюулгүйгээр барина.
- Цээж, гэдэс, гар хэсэгт нь ус асгаж угаах бөгөөд ус хүүхдийн нүүрэнд цацагдахаас болгоомжилно.
- Өгзөг, хөл, бэлэг эрхтнийг угаах ба эмэгтэй хүүхдийн бэлэг эрхтнийг урдаас нь хойш нь арчина.
- Хүүхдийг суулгаж, нуруу болон хүзүүг угаана.
- Цэвэр, бүлээн усаар хурдан зайлаад алчуураар дарж арчиж, живх, хувцсыг өмсгөнө. Живхийг хүйтэй хүрэлцэхгүй байхаар өмсгөнө.

I. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Шаардлагатай бол биеийн тос түрхэнэ.
- Эцэст нь хүй, чих, хамрыг цэвэрлэнэ.
- Хөвөнтэй модон савх хэрэглэх үед арьсыг гэмтээж болзошгүй тул маш зөөлөн хэрэглэнэ.

 <p>1</p>	 <p>2</p>
<p>• Усанд оруулах хэрэгслийг урьдчилан бэлтгэнэ.</p>	<p>• Усны температурыг тохойгоор шалгана.</p>
 <p>3</p>	 <p>4</p>
<p>• Толгойг нь алчуураар ороож хамгаалсны дараа цэвэр алчуурыг норгож нүднээс эхлэн нүүрийг нь арчина. Арчих хэсгийг нь алчуураар бага зэрэг шахаж, бүлээн усанд норгосон самбайгаар зөөлөн арчина.</p>	<p>• Ариутгасан хөвөнтэй савх эсвэл самбайгаар хүүхдийн хүй орчмыг сайтар хуурайшуулна.</p>
 <p>5</p>	 <p>6</p>
<p>• Живхийг солиод, бэлэг эрхтэн болон хошногоны хэсгийг дээрээс доош чиглэлтэй арчина.</p>	<p>• Хүүхдийн толгойг нярайн савангаар зөөлөн угааж, бүлээн усаар зайлан, биеийн дулаан огцом буурахаас сэргийлнэ.</p>
 <p>7</p>	 <p>8</p>
<p>• Цэвэр алчуураар норгосон биеийг нь сайн арчиж хатаасны дараа тос, живхний тос, нунтаг зэргийг түрхэнэ.</p>	<p>• Цэвэр хувцас өмсгөж, үсийг нь сайтар самнана.</p>

[Зураг 11] Нярайг усанд оруулах үе шат

Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024). Төрсний дараах сувилгаа, асаргааны гарын авлага

#### 4) Шээх ба өтгөн гадагшлуулах

- Нярай хүүхэд төрсний дараах эхний 3 хоногт шээх тоо цөөн байдаг ба 5-7 дахь өдрөөс эхлэн өдөрт 6-аас дээш удаа шингэн шээдэг.
- Төрсний дараах 3-5 дахь өдрүүдэд өтгөн нь харьцангуй шингэн, салиа агуулсан ногоовтор-шар өнгөтэй байна. 5 дахь өдрөөс хойш өтгөний давтамж ба шинж чанар нь хөхөөр хооллох эсвэл нэмэлт тэжээлээр хооллохоос хамааран өөр өөр байдаг.
- Хөхөөр хооллох үед өдөрт 2-4 удаа өндөгний шар өнгөтэй, шингэн нухаш шиг өтгөн гарна. Харин нэмэлт тэжээлээр хооллох үед өдөрт 1-2 удаа шар өнгийн хатуулаг өтгөн гардаг.
- Шээс хүрсэн тохиолдолд цэвэр усаар угаахад хангалттай, харин өтгөнөөр бохирдсон бол савангаар сайтар угааж өгөх нь живхний тууралтаас сэргийлнэ.


#### 5) Арьс арчилгаа

##### ① Хөлсний тууралт

- Хэт халуун эсвэл чийглэг орчинд хөлс бүрэн гадагшиж чадахгүй арьсан дор хуримтлагдах, эсвэл хөлсний булчирхайн эргэн тойронд үрэвсэл үүсэхийг хөлсний тууралт гэнэ. Энэ нь ихэвчлэн зуны улиралд ажиглагдана.
- Нярай хүүхэд их хөлөрдөг боловч биений халуун зохицуулах чадвар сул байдаг тул арьсны нугалаастай хэсэг болон живх хүрдэг хэсэгт илүү их гардаг.
- Улаан өнгийн жижиг товруу үүсч, хүндэрвэл нянгийн халдвар авч үнэр гарч идээтэй шингэн ялгарч болно.
- Хөлсний тууралт гарсан бол хүүхдийг сэрүүн орчинд байрлуулснаар хурдан эдгэрнэ.

##### ② Живхний тууралт

- Живхний тууралт нь голчлон шээсэнд агуулагдах аммиакын улмаас үүсдэг, заримдаа даавуун живх угаахад хэрэглэсэн угаалгын бодис бүрэн зайлагдаагүйгээс үүсэх боломжтой.
- Урьдчилан сэргийлэхийн тулд живхийг ойр ойрхон сольж, солих бүрдээ хүүхдийн арьсыг бүлээн усаар угааж, нунтаг цацлага түрхэнэ. Даавуун живх хэрэглэдэг бол нярайд зориулсан савангаар угааж, савангийн үлдэгдлийг бүрэн арилгахын тулд сайтар зайлах хэрэгтэй.
- Тууралт гарсан бол даавуун живх хэрэглэж ойр ойрхон сольж, өдөрт дор хаяж 20 минут тууралттай хэсгийг агаарт болон нарны гэрэлд ил гаргана.
- Хэрэв үрэвсэл бага бол нунтаг цацлага түрхэж, идээт шингэн гарч байгаа бол эмчийн жороор өгсөн тосыг түрхэнэ.
- Нунтаг цацлага болон тосыг хамт хэрэглэх нь арьсыг цочроох тул хамтад нь хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.



[Зураг 12] Живхний тууралт

Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024). Төрсний дараах сувилгаа, асаргааны гарын авлага

### ③ Живх хэрэглэх

- Даавуун живх нь зөөлөн, тав тухтай, агаар нэвтрүүлэлт сайтай тул живхний тууралтаас урьдчилан сэргийлэхэд тохиромжтой боловч цаг тухайд нь солихгүй бол шингэх чадвар нь буурч, нян болон аммиак хуримтлагдаж тууралтын шалтгаан болдог.
- Нөхцөл байдалд тааруулан даавуун живх болон нэг удаагийн живхийг ээлжлэн хэрэглэх нь хамгийн сайн. Шөнө болон гадуур гарахдаа шингээлт сайтай нэг удаагийн живхийг ашиглаж, гэртээ өдрийн цагаар даавуун живх хэрэглэвэл тохиромжтой.
- Хэрэглэсэн даавуун живхийг дахин хэрэглэхдээ шууд угааж хэрэглэнэ. Харин хэрэглэсэн живхийг усаар дэвтээж бөөндөж угаавал нян, хөгц үүсэх аюултай тул заавал буцалгах эсвэл халуун усанд 10 минут орчим дэвтээж угаана. Живхийг угааж нарны гэрэлд хатаах, үүлэрхэг өдөрт индүүдэж хэрэглэх нь тохиромжтой.
- Нярай хүүхэд хөхүүлэх үедээ болон хөхүүлсний дараа ихэвчлэн шээж, баадаг тул хөхүүлсний дараа 20 минут орчим нурууг нь илж хээрүүлэх, дараа нь живхийг нь сольж унтуулах нь тохиромжтой.

### ④ Живх солихын өмнөх бэлтгэл

- Живх солихоос өмнө хүүхдийг арчих нойтон салфетка эсвэл даавуу, хамгаалалтын тос, цэвэр хувцас зэрэг зүйлсийг бэлтгэж, бүгдийг гар хүрэхэд ойр байрлалд байршуулна.
- Живх, нойтон салфетка, ариун цаас, жижиг алчуур, нунтаг цацлага зэрэг живх солих хэрэгслийг сагсанд хийж нэг дор байрлуулбал хэрэглэхэд илүү хялбар.

### ⑤ Живх солих арга

- Живхийг солихдоо өсөлтийн мөгөөрс гэмтэхээс сэргийлж өгзгийг нь хэт өндөр өргөхгүй байхад анхаарна.
- Живх нойтон удаан байх эсвэл шингэн өтгөн ихээр гарах үед живхний тууралт үүсэх эрсдэлтэй тул шээс, өтгөн гарсны дараа даруй солино.
- Живх солих үед нойтон алчуур эсвэл зөөлөн даавуугаар бие зассан хэсгийг арчина.

- Живхийг солихдоо норсон хэсгийг богино хугацаанд агаарт ил гаргаж, өгзгийг бүрэн хуурайшуулсны дараа живхийг өмсгөнө.
- Хүйг дээш байрлуулж, живхийг хүйний доод хэсэг хүртэл өмсгөнө.

## 6) Хүүхдийн нойр

### ① Ерөнхий анхаарах зүйлс

- Нярай хүүхэд хөхүүлэх цагийг эс тооцвол өдөрт 16–20 цаг унтдаг.
- Нярай хүүхдийн ходоод жижиг тул 2 цаг тутамд, заримдаа түүнээс ч ойр ойрхон хөхүүлэх шаардлагатай.
- Шөнө сайн унтуулахын тулд өдрийн цагаар унтуулахгүй байх эсвэл хүүхдийг уйлуулах нь буруу. Учир нь хүүхдийн өсөлт хөгжилд хангалттай нойр зайлшгүй шаардлагатай бөгөөд өдрийн цагаар хангалттай унтаагүй хүүхэд шөнө ч амар тайван унтаж чадахгүй.
- Нярай хүүхдийн мэдрэлийн хөгжил бүрэн гүйцээгүй байдаг тул өдөр, шөнийг ялгахгүй, шөнө өдрийн цагаас илүү олон удаа сэрэх нь түгээмэл. Ийм тохиолдолд шөнийн цагаар хангалттай хэмжээний сүү өгч цадтал нь хооллох, унтахын өмнө нярайн иллэг болон дасгал хийж өгөх нь нь гүн нойрсоход тусалдаг. Мөн хүүхдийг ороох даавуугаар сайн ороох эсвэл зүрхний цохилтын давтамжтай уялдуулсан аялгуутай аяархан хөгжим сонсох нь хүүхдэд тайвшрал өгч удаан, гүн унтахад тустай. Өрөөний гэрлийг бүдэг, харанхуй болгож тайван тухтай орчныг бүрдүүлнэ.



#### <Хоёр гарын сунгалт>

Мөртэй нэг шугамд, биетэй тэгш өнцөг үүсгэх байдлаар хоёр гарыг хөнгөнөөр хоёр тал руу нь татаж тэнийлгэнэ. Дараа нь урд тал руу нь зөөлөн татаж, хоёр гараа нийлүүлнэ.



#### <Хоёр хөлийн сунгалт>

Шагайг нь барьж, хөлийг гэдэс рүү нь зөөлөн дарж өгөх хөдөлгөөнийг хэд хэдэн удаа давтана. Дараа нь хоёр хөлийг нийлүүлээд доош нь бүрэн тэнийлгэнэ.

[Зураг 13] Нярайн дасгал

★ Хүүхдийг хөнжилдөө хэрхэн боох вэ



- ① Зурагт үзүүлсэнчлэн дөрвөлжин ороох даавууг гурвалжин хэлбэртэй болгон нугалсны дараа хүүхдийг хэвтүүлнэ.
- ② Гурвалжингийн нэг талын үзүүрийг хүүхдийн мөрнөөс бүсэлхийн хэсэг хүртэл ороон бооно.
- ③ Гурвалжингийн доод үзүүрийг цээж хүртэл нь дээш татаж, илүү гарсан хэсгийг нь дотогш нямбайлан эмхэлнэ.
- ④ Гурвалжингийн үлдсэн үзүүрээр хүүхдийн мөрийг ороон бүсэлхийн хэсэг хүртэл ороож боогоод, илүү гарсан хэсгийг нь дотогш нямбайлан эмхэлнэ.

Эх сурвалж: <https://m.blog.naver.com/PostView.naver?isHttpsRedirect=true&blogId=ys2sy&logNo=60199749860>

② Нойрны хэв маяг

- Шинэ төрсөн хүүхэд идэх болон уйлах үеийг эс тооцвол ихэнх цагийг унтаж өнгөрүүлдэг бөгөөд энэ хэв маяг нь 3 сар хүртэл үргэлжилж, өдөрт нийт 15 цаг ба түүнээс дээш унтдаг.
- Үүнээс хойш өдөр унтах хугацаа аажмаар багасч, нийт нойрны цаг багасах боловч шөнө үргэлжлэн унтах хамгийн урт хугацаа аажмаар нэмэгддэг.
- 6 сартайгаас эхлэн шөнөдөө 6–8 цаг унтаж, шөнө сэрэхгүй унтдаг өдрийн тоо нэмэгдэж эхэлдэг.
- Унтаж байх үед тархинаас өсөлтийн даавар идэвхтэй ялгардаг тул нам гүм, тав тухтай орчныг бүрдүүлж хүүхдийг гүн нойрлуулах нь өсөлт хөгжилд нь чухал ач холбогдолтой.

③ Хүүхдийн хамгийн тухтай унтах байрлал

- **Дээш харуулж унтуулах:** Хүүхдийн нүүр дээш харж, нуруу нь орон дээр тэгшхэн наалдсан байрлалд байхаар анхаарч, нуруу бөгтийхгүй, хажуу тийшээ мурийхгүй байрлалд хэвтүүлнэ. Хэрэв бөөлжвөл амьсгалын зам руу орох аюултай тул толгойг нь нэг тал руу зөөлөн эргүүлнэ.
- **Хажуу харуулж унтуулах:** Бөөрөнхийлж ороосон алчуур эсвэл жижиг дэрийг нурууны

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

ард тавьж тогтвортой хэвтүүлбэл бөөлжих үед бөөлжис амархан гарч аюулгүй. Гэвч нэг тал руугаа дандаа хэвтүүлбэл толгой хэлбэрийн нэг тал дарагдаж болох тул хоёр талдаа ээжижиг унтуулна.

- **Тэврээд унтуулах:** Эхийн тэвэрт унтуулах нь ээжид ачаалалтай ч хүүхэд тайван унтдаг. Хүүхэд эхийн тэвэрт унтсаны дараа өгзөгнөөс нь эхлэн зөөлөнөөр орон дээр тавьж, дараа нь толгойг нь зөөлөн тавина. Заримдаа ээжийн тэврэлтээс тавьмагц сэрдэг нь ор орчны температур харьцангуй хүйтэн байгаатай холбоотой тул унтах газрыг урьдчилан дулаацуулах нь тус болдог.

<Хүснэгт 2> насанд тохирох хүүхдийн унтах хэв маяг

Сар нас	Шөнийн нойр (цаг)	Өдрийн нойр (цаг)	Нийт нойр (цаг)	Өдрийн унтлагын тоо
~4 долоо хоног	8~9 цаг	7~8 цаг	16~17 цаг	4 удаа
4 долоо хоног~3 сар	9~10 цаг	5~6 цаг	15~16 цаг	3 удаа
3~6 сар	10~11 цаг	3~4 цаг	14~15 цаг	2 удаа
6~12 сар	11~12 цаг	2~3 цаг	13~14 цаг	2 удаа

Эх сурвалж: Richard E. Behrman, Robert M. Kliegman, Hal B. Jenson, Nelson Textbook of Pediatrics, 18th edition, SAUNDERS

7) Хүүхдийн хувцас угаах

Нярайн арьс маш эмзэг тул нян, гадны бохирдолд өртвөл амархан үрэвсэх эрсдэлтэй. Иймээс хүүхдийн хувцас болон даавуун живхийг сайтар угааж, ариутгаж хэрэглэх хэрэгтэй бөгөөд заавал том хүний хувцаснаас тусад нь угаана.

① Нярайн угаалга арчилгаанд анхаарах зүйлс

- Угаахаасаа өмнө угаалгын машиныг зориулалтын цэвэрлэгч эсвэл байгалийн гаралтай цэвэрлэгчээр угааж цэвэрлэнэ.
- Боломжтой бол нярайн хувцсыг тусдаа угаалгын машинаар угааж, том хүний хувцаснаас тусад нь угаана. Ялангуяа том хүний дотуур хувцаснаас бүрэн тусгаарлаж угаана.
- Өтгөн хүрэн даавуун живхийг тусад нь угааж, заавал буцалгаж ариутгасны дараа хэрэглэнэ.
- Нярайд зориулсан тусгай угаалгын нунтаг (хадгалалтын бодисгүй, ПАВ буюу гадаргуу идэвхт бодисгүй, хиймэл үнэргүй) хэрэглэнэ.
- Хэрэв хүүхэд амны салстын мөөгөнцөр, ангино туссан эсвэл өтгөн ихээр гардаг бол бүх нярайн хувцсыг буцалгаж угаана. Хэрэв амны мөөгөнцөр оношлогдсон бол гэрийн бүх хувцас (том хүний хэрэглээний зүйлс орно), ор дэрний цагаан хэрэглэл, хүүхдийн тоглоомыг нарны гэрэлд ариутгана. Хүүхдийн байнга хэрэглэдэг хувцас, сүүн сав, хүүхдийн гарын алчуурыг буцалгаж угаасны дараа гэрэлтэй газар наранд ариутгана.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Байгалийн материалаар хийсэн хувцас нь буцалгавал эсрэгээрээ нянгийн эсрэг чанар нь буурч, материал гэмтэж болох тул угаахаасаа өмнө шошгыг нь заавал шалгана.

② Хүүхдийн хувцас угаах арга

- Даавуун живх болон хүүхдийн хувцсанд наалдсан өтгөн, бөөлжис зэрэг бохирдлыг сэгсэрч авсны дараа 10 минут орчим усанд дэвтэнэ.
- Хүүхдийн зориулалтын угаалгын нунтаг ашиглан бохирдолтой хэсэгт онцгой анхаарч бүхэлд нь угааж, усыг нь цэвэр тунгалаг болтол бүлээн усаар хэд хэдэн удаа зайлана.
- Халуун усанд 10 минут орчим дэвтээж ариутгах эсвэл буцалган ариутгана.
- Сүүлчийн зайлалтын усанд хүүхдийн зориулалтын даавуу зөөлрүүлэгчийг хийж зайлах боломжтой.
- Хувцас болон живхийг салхи болон нарны гэрэл сайн тусгах газарт хатааж нарны гэрлээр ариутгана.
- Үүлэрхэг өдөр бол сэнс ашиглан хатааж, дараа нь индүүдэж ариутгана.
- Хатаасан даруйд хуйлж авч цэгцлэн хадгална.

8) Хүүхдийн хумс арчилгаа

Хүүхдийн хумс хурдан ургаж, хурц байдаг тул өөрийнхөө нүүрийг маажих тохиолдол олон байдаг. Иймээс заавал хумсны бээлий өмсгөх хэрэгтэй. Төрсний дараах нэг долоо хоногийн дараа хумс нэлээд ургасан байдаг тул нярайн зориулалтын хумс авах хэрэгслээр авч өгөх ёстой. Хумсыг авахдаа дугуй хэлбэрээр авч болохгүй, ингэснээр хоёр үзүүр нь гүн огтлогдож, хумсны хоёр талаар шарх үүсэх эрэдэлтэй тул шулуун авч, үзүүрийн хоёр талыг зөөлөн өнгөлнө.

3 Нярай болон бага насны хүүхдийн хэвийн бус шинж тэмдгүүд

Нярай хүүхэд маш өчүүхэн өөрчлөлтөд ч мэдрэг хариу үйлдэл үзүүлж олон төрлийн шинж тэмдэг илэрч болох боловч эдгээр шинж тэмдэгт хэт мэдрэгээр хандаж санаа зовох шаардлагагүй. Гэсэн хэдий ч нярайн биеийн хөгжил бүрэн гүйцээгүй, халдварт өвчнөөс хамгаалах дархлааны тогтолцоо нь дутуу хөгжсөн байдаг тул анхааралтай арчилгаа хийсэн ч төрөлхийн эсвэл олдмол янз бүрийн хэвийн бус шинж тэмдэг илэрч болно. Эдгээрийн зарим нь хүүхэд өсөж хөгжих явцад аяндаа эдгэрдэг бол зарим нь ноцтой хүндрэл дагуулж болох өвчинд хүргэж болзошгүй. Тиймээс хүүхэд хэвийн бус шинж тэмдэг ажиглагдвал яаралтай мэргэжлийн эмчтэй зөвлөлдөх нь зүйтэй.

## 1) Халуурах

### ① Биений халууны зохицуулалт

- Нярайн биений халуун зохицуулах чадвар бүрэн хөгжөөгүй тул орчны температурын өөрчлөлтөд ихээхэн мэдрэмтгий байдаг бөгөөд халуун нь амархан нэмэгдэж, буурч болно. Тиймээс өрөөний температур, хүүхдийн хувцасны зузаан, хэрэглэж буй хөнжил болон даавуу зэрэгт маш нарийн анхаарах хэрэгтэй.
- Хөхүүлсний дараа, хүүхэд нойрмоглох үед, уйлсны дараа, эсвэл бие зассаны дараа ч биений халуунд өөрчлөлт гарч болдог. Тиймээс хүүхдийн халууныг хэмжихдээ заавал нэг ижил биений хэсэгт, ижил нөхцөлд, нэг төрлийн халуун хэмжигчээр хэмжих хэрэгтэй.
- Тасралтгүй хөдөлгөөнтэй нярайн биений халууныг хэмжих хамгийн найдвартай арга нь суганы халуун хэмжих арга юм.
- Хүүхэд 6 сар хүртэлх насандаа эхээс авсан дархлааны хамгаалалтын тогтолцооныхоо ачаар өвчинд тийм ч амархан өртдөггүй. Гэвч жирэмсэн үе эсвэл төрөлтийн явцад эхээс өвчин халдварласан тохиолдолд нярайд өндөр халуурах шинж илэрч болно. Хүүхэд халуурах үед дараах аргыг хэрэглэх нь зүйтэй.
- Өрөөний температурыг багасгаж, хөнжил болон ороох даавууг тайлж сэрүүхэн байлгана.
- Шингэний дутагдлын эрсдэлтэй тул буцалгаж хөргөсөн цэвэр усаар шингэнийг нөхнө.
- Бүлээн нойтон алчуураар хүүхдийн нүүр, гар, хөлийг арчина.
- 38°C-аас дээш халуурвал 30 минут тутам халууныг нь шалгана.
- Дээрх арчилгаа хийсний дараа ч 38°C-аас дээш халууралт 2 цагийн турш үргэлжилбэл эмнэлэгт очиж халдварт өвчний шинжилгээ өгөх хэрэгтэй.

### <Хүснэгт 3> Халуун хэмжигчийн төрлүүд

Төрөл	Зураг	Тайлбар
Чихний халуун хэмжигч		Чихний хэнгэрэг болон түүнийг хүрээлсэн арьснаас ялгарч туяаг ашиглан биений халууныг хэмждэг хэрэгсэл. Шулуун гэдсээр хэмждэг халуунаас 0.52 секундэд хурдан хэмжих боломжтой тул хэрэглэхэд тохиромжтой, мөн мөнгөн устай термометртэй харьцуулахад аюул багатай, харьцангуй нарийвчлал сайтай.
Цахилгаан халуун хэмжигч		Үзэг хэлбэрийн загвартай, ам эсвэл суганд хэмждэг. Хямдхан, нарийвчлал өндөр тул өргөн хэрэглэгддэг. Хэмжилт дуусахад дохионы чимээ гарч, LCD дэлгэц дээр халууныг харуулдаг.

1. Нярайн эрүүд мэндийн аричлгаа

Төрөл	Зураг	Тайлбар
Мөнгөн устай халуун хэмжигч		Хамгийн нарийвчлал сайтай халуун хэмжигч боловч мөнгөн усны хордлогын аюултай тул хэрэглэхийг зөвлөдөггүй.
Инфра улаан духны халуун хэмжигч		Амархан, хурдан үр дүн гаргадаг ба духан дээр байрлах чамархайн артерийн (temporal artery) температур хэмжих замаар биеийн халууныг тодорхойлдог. Чихний халуун хэмжигчээс илүү нарийвчлалтайд тооцогддог бөгөөд чихний халуун хэмжигчийн гадаад чихний сувгийн өнцөг, хэмжигчийн хэрэглэгчээс шалтгаалах алдааг нөхдөг.

② Биеийн халуун хэмжих арга

- Суганы халуун хэмжих арга
  - Хүүхдийн гар өргөж, сугыг нь хэдэн минут хөргөж хатаана. Учир нь чийгтэй үед халуун бага гарч болно. Мөн зузаан хувцас өмсүүлсэн бол халуун хэт өндөр гарах эрсдэлтэй тул анхаарах хэрэгтэй.
  - Халуун хэмжигчийн үзүүрийг суганд нь байрлуулж, тохойг нь биерүү нь дарж 4–5 минутын турш хэмжинэ.
  - Суганы халуун 38°C –аас дээш байвал халуурч байна гэж үзнэ.
- Чихний халуун хэмжих арга
  - Халуун хэмжигчийн линз үзүүрийг хүүхдийн чихэнд зөөлөн оруулж, хэнгэртэй нэг шугамд байхаар тааруулж барина.
  - Эхлэх товчийг дарж "пи" гэсэн дуу гарсны дараа дэлгэц дээрх халууныг уншина.
  - Ар талын гэрэл анивчиж байвал дахин хэмжих шаардлагатай.

③ Халууралтын таталт (Febrile seizure)

- Төв мэдрэлийн системийн халдваргүйгээр халууралтын хамт илэрдэг таталтыг халууралтын таталт гэнэ. Энэ нь 3 сартайгаас 5 нас хүртэлх хүүхдийн 3–5%-д тохиолддог.
- Халууралтын шалтгааны 70% нь ханиад зэрэг амьсгалын дээд замын халдвар байдаг.
- Шинж тэмдэг: Халуун огцом өсөхөд биеийн мөчүүд чангаран, уруул хөхөрч, нүд эргэлдэх гэх мэт бүх биеийн шинж тэмдэг илэрнэ. Ихэвчлэн таталт хэдхэн секундээс хэдэн минут үргэлжлэх ба 15 минутаас хэтэрдэггүй.
- Халууралтын таталт илэрвэл хувцсыг тайлж, бүлээн нойтон алчуураар биеийг арчиж халууныг бууруулна. Шаардлагатай бол шулуун гэдсээр хийж хэрэглэх лаа хэлбэрээр

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

халуун бууруулах эм хэрэглэж болно.

- Хэрэв таталт 10 минутаас дээш үргэлжилбэл яаралтай түргэн тусламжид хандана. Таталт дууссаны дараа онош тодруулахын тулд эмнэлэгт үзүүлнэ.

## 2) Амьсгалын хүндрэл

- Нярайн амьсгалын тоо хурдан өөрчлөгддөг тул хүүхэд тайван байгаа үед нь нэг минутын турш амьсгалын тоог тоолох ёстой.
- Нярайн хэвийн амьсгалын тоо минутанд 30–60 удаа.
- Амьсгалын хүндрэл нь минутанд 60-аас дээш удаа амьсгалах, цээж хонхойх, цээж болон гэдэс төвхөлзөх мэт хөдөлгөөн, амьсгалах үед хяхтнах мэт дуу гаргах, арьс хөхрөх зэрэг шинж тэмдгээр илэрнэ.
- Амьсгалахгүй байх байдал 20 секундээс удаан үргэлжлэх, эсвэл арьс хөхрөх, зүрхний цохилт удаашрах шинж илэрвэл таталт эсвэл цусанд халдвар (үжил) байх магадлалтай тул яаралтай эмнэлэгт хүргэх шаардлагатай.
- Хөхүүлэх үед болон унтаж байхдаа арьс хөхөрч байгаа нярай хүүхдийг онцгой анхааралтай ажиглах хэрэгтэй.



[Зураг 14] Silverman–Anderson амьсгалын үнэлгээний шалгуур

Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024). Төрсний дараах сувилгаа, асаргааны гарын авлага

## 3) Бөөлжих

- Нярайн улаан хоолой болон ходоодыг холбосон булчин бүрэн хөгжөөгүй байдаг тул хооллосны дараа хэврүүлэхгүй бол бөөлжих нь түгээмэл.
- Ханиад, хурц ходоод гэдэсний үрэвсэл, тархи нугасны үрэвсэл зэрэг халдварын үед, эсвэл төрөлхийн ходоодны гарах хэсгийн нарийсал, гэдэсний түгжрэл зэрэг ноцтой эмгэгийн үед бөөлжилт хүчтэй илэрдэг.

- Хүүхэд бөөлжиж эхэлбэл толгойг нь хажуу тийш эргүүлж бөөлжис амьсгалын замд орохоос сэргийлж, дээд биеийг нь өндөрлөж бөөлжихийг багасгана.
- Бөөлжсөнөөс хойш шингэний дутагдлыг нөхөхийн тулд бага багаар усыг аажуухан уулгана.
- Бөөлжих нь улам ойр давтамжтай эсвэл хүчтэй болох, эсвэл халууралт дагалдах тохиолдолд хүүхдийн эмчид хандаж нарийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй.

#### 4) Шингэн алдалт (Дегидратаци)

- Шингэн алдалт гэдэг нь биеэс гадагшилж буй нийт шингэний хэмжээ орж буй шингэнээс илүү байхыг хэлнэ. Энэ нь нярай хүүхдэд түгээмэл тохиолддог.
- Ихэвчлэн шингэнийг хангалттай авч чадахгүй үед шингэн алдалт үүсдэг ч бөөлжих, суулгах зэрэг шингэний алдагдал нэмэгддэг нөхцөлд ч илэрнэ. Ялангуяа нярай хүүхдийн биеийн гадаргуугийн талбай харьцангуй том тул арьсаар шингэн ихээр алдагдаж болно.
- Нярай хүүхдийн шингэн алдалтын шинж тэмдгүүд нь: толгойн зулайн хэсэг хонхойх, шээсний хэмжээ ба давтамж багасах, амны салет болон хэл хуурайших, арьсны уян чанар алдагдах, халууны өөрчлөлт, сул дорой байдал, нойрмоглох гэх мэт.
- Хүүхэд идэвхтэй, шинж тэмдэг нь хөнгөн бол хөхүүлэх эсвэл хооллолтоор дамжуулан шингэнийг нөхнө. Харин чихэртэй ус, зөгийн балтай ус өгөх нь суулгалтыг улам дордуулж болзошгүй тул өгөхгүй.
- Хэрэв шинж тэмдэг хүндэрч, хүүхэд сульдах, унтаарах, бөөлжилт ихэсч уухаар шингэн нөхөх боломжгүй бол яаралтай эмнэлэгт үзүүлнэ. Ялангуяа байнга суулгаж, өтгөнд цус эсвэл идээ байвал яаралтай эмнэлэгт үзүүлж шинжилгээ хийлгэх шаардлагатай.

#### 5) Өтгөний байдал

Хүүхдийн өтгөний байдал нь хөхүүлэлт болон нэмэлт тэжээлээр хооллох эсэхээс хамаарна. Мөн хөхүүлж буй ээжийн хоол хүнсний төрөл ч нөлөөлдөг. Өтгөн нь хүүхдийн эрүүл мэндийн байдлыг илэрхийлдэг тул сайтар ажиглах шаардлагатай.

- **Ногоон өтгөн:** Өтгөнд билирубин их хэмжээгээр агуулагдахад ногоон өнгөтэй болно. Мөн сүүний уурагт харшилтай үед гэдэсний хөдөлгөөн ихэсч, хоол хүнс гэдсээр хурдан дамжин цөс их хэмжээгээр холидон ногоон өнгөтэй болдог. Ээж нь шар-ногоон өнгийн хүнсний ногоо эсвэл төмөр ихтэй хоол хүнс идсэн үед ч хүүхэд ногоон өнгийн өтгөн гаргана. Бактери болон вирусн гаралтай гэдэсний үрэвслийн үед ч ногоон өтгөн гарч болно.
- **Улаан эсвэл хар өнгийн өтгөн:** Улаан өнгийн шинэхэн цустай өтгөн болон хар өнгийн өтгөн удаан хугацаанд гарч байвал гэдэсний цус алдалт сэжиглэгдэнэ.
- **Цагаан бичмэгтэй өтгөн:** Нярай хүүхдэд сүү болон сүүн тэжээл дэх уураг, өөх тосыг задалдаг шүүрэл дутагдалтай байдаг тул жижиг будаа мэт цагаан бичмэг агуулсан өтгөн

гарах нь элбэг. Энэ нь хоол боловсруулалт дутуу байгаагийн шинж боловч эрүүл мэндийн ноцтой асуудал биш бөгөөд хүүхэд өсөхийн хэрээр сайжирна.

- **Салсттай өтгөн:** Гэдэсний салст бүрхүүлийн үрэвслийн үед наалдамхай салсттай өтгөн гарна. Хэрэв салсттай өтгөнд үр тариа мэт бижмэг дагалдаж, суулгалттай байвал гэдэсний үрэвсэл (энтерит) сэжиглэгдэнэ.
- **Суулгалт:** Хүүхэд сайн идэж, тоглож байгаа үед түр хугацаанд шингэн өтгөн гарахыг суулгалт гэж үзэхгүй. Хөхүүлж байгаа ээжийн хоол хүнс хүүхдийн гэдсэнд шууд нөлөөлж болох тул ээж нь чанартай, тэнцвэртэй хооллож, нэг төрлийн хүнс эсвэл жимсийг их хэмжээгээр идэхээс зайлсхийх хэрэгтэй. Нэмэлт тэжээл хэрэглэж байгаа хүүхэд сүүний уурагт харшилтай бол суулгалт үүсч болно. Энэ тохиолдолд тусгай зориулалтын сүү (суулгалтын үед хэрэглэдэг) хэрэглэхээс өмнө мэргэжлийн эмчтэй зөвлөнө. Гэхдээ хүүхэд идэхгүй, байнга уйлагнаж, шингэн ногоон өнгийн өтгөн удаан хугацаанд гарч байвал бактерийн гаралтай суулгалт сэжиглэгдэнэ.
- **Өтгөн хаталт:** Эрүүл нярай хүүхэд төрсний дараах 24-36 цагийн дотор зунгаага гаргадаг. Хэрэв гаргахгүй бол гэдэсний бөглөрөл, нарийсал, төрөлхийн мегаколон, бамбай булчирхайн дааврын дутагдал, зунгагийн бөглөрөл зэрэг эмгэгүүд сэжиглэгдэнэ. Эхний зунгаг гарсны дараах өтгөн хаталт нь ихэвчлэн буруу хооллолттой холбоотой. Хэрэв хүүхэд 3 долоо хоног хүрэхээс өмнө өдөрт нэг удаа ч өтгөн гаргахгүй байвал хүүхдийн эмчид үзүүлэх хэрэгтэй. 5 хоног-3 долоо хоногийн хооронд багахан өтгөн өдөрт 1-2 удаа гарч байвал хоолны хэмжээг дахин шалгана. 3-4 долоо хоногтой болоход өтгөний давтамж аажмаар багасч болно. Өдөр бүр өтгөн гаргахгүй байсан ч хүүхэд сайн идэж, сайн тоглож байвал ажиглаж болно. Хэрэв хүүхэд өтгөнөө тогтмол гаргахгүйгээр, тавгүйрхэж байвал вазелин түрхсэн хөвөнтэй савхаар шулуун гэдсийг зөөлөн цочрооно. Хэрэв тийм аргаар ч өтгөн гаргахгүй эсвэл дандаа тийм аргаар гаргаж байвал эмнэлэгт үзүүлж шинжилгээ хийлгэнэ.

#### 6) Улаан шээс

Нярайн бөөр бүрэн хөгжөөгүй тул шээсэнд агуулагдах шээсний хүчил шүүгдэхгүй шууд гарч болно. Энэ үед шээсэнд цусны дусал мэт улаан толбо ажиглагдаж, шээсний өнгө улайж харагдах нь байдаг. Энэ шинж тэмдэг нь аажмаар багасч 2 долоо хоногийн дараа арилдаг.

#### 7) Нүдэнд нулимсны ялгадас үүсэх

Нярайн нулимсны суваг бүрэн хөгжөөгүй тул нулимс гадагш урсгаж чадахгүй, нүдэнд нулимсны ялгадас тогтож болно. Гэвч 3 долоо хоногтой болоход аяндаа эдгэрнэ.

#### 8) Шарлалт

Хөхөөр хооллодог хүүхдэд илэрдэг шарлалт нь хоёр төрөл: эхний өдрүүдэд илэрдэг **эрт үеийн хөхний сүүний шарлалт** болон хөхний сүүтэй холбоотой **хөхний сүүний шарлалт** гэж ангилагдана.

① Эрт үеийн хөхний сүүний шарлалт

- Хөхөөр хооллодог хүүхдийн ойролцоогоор 15%-д төрсний дараах 3 хоногоос 1 долоо хоногт эрт үеийн хөхний сүүний шарлалт илэрдэг бөгөөд энэ нь хангалтгүй хөхүүлэлтээс үүдсэн калорийн дутагдал болон шингэн алдалтаас болдог. Иймээс урьдчилан сэргийлэхийн тулд төрөлтийн дараа 30 минут–1 цагийн дотор эхлээд хөхүүлж эхлэн, шөнө хооллохыг оролцуулан 2-3 цаг тутамд өдөрт 10-аас дээш удаа хөхүүлнэ.
- Ус өгөх нь калорийн хэрэглээг багасгаж, харин ч шарлалтыг дордуулж болзошгүй тул ус өгөхөөс зайлсхийх хэрэгтэй.
- Шээс ба өтгөнийг сайн гадагшлуулахын тулд хангалттай хэмжээгээр ойр ойрхон хоолловол төрсний дараах 1 долоо хоногоос шарлалт намжиж эхэлнэ.

② Хөхний сүүний шарлалт

- Хөхний сүүний шарлалт нь төрсний дараах 1 долоо хоногоос эхэлж, зарим тохиолдолд 10 долоо хоног хүртэл үргэлжилж болно.
- Хөхөөр хооллодог хүүхдийн 2% орчимд ажиглагддаг. Хэрэв шарлалт хөнгөн бол хөхүүлэлтийг зогсоох шаардлагагүй бөгөөд хооллолт үргэлжилсэн ч шинж тэмдэг аажмаар сайжирдаг.
- Харин шарлалт хэт хүчтэй байвал, эсвэл төрсний дараах 1 сарын дараа ч нүдэнд харагдахуйц шарлалт ажиглагдвал заавал мэргэжлийн эмчид үзүүлэх ёстой.



[Зураг 15] Нярайн шарлалт

③ Эмгэг шарлалт

Төрсний дараах 24 цагийн дотор шарлалт илрэх, шинж тэмдэг хурдтай нэмэгдэх, хөхүүлэхгүй байхад ч 10-14 хоногоос дээш үргэлжилбэл эмгэг шарлалт байх магадлалтай. Хүүхэд сайн

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

хөхөхгүй байх, хоол идэхээс татгалзах, сул дорой болох, өтгөний өнгө цайвар байх, шээсний өнгө хар бараан байх зэрэг шинж тэмдэг илэрвэл эмгэг шарлалтыг сэжиглэж, яаралтай мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээ авах шаардлагатай.

<Хүснэгт 4> Шарлалтын төрөл ба онцлог

Ангилал	Физиологийн шарлалт	Эмгэг шарлалт	Эрт үеийн хөхний сүүний шарлалт	Хөхний сүүний шарлалт
Тоо гаралт	Нярайн 50%	–	Хөхөөр хооллодог хүүхдийн 15%	Хөхөөр хооллодог хүүхдийн 2%
Шалтгаан	Нярайн элэгний үйл ажиллагаа бүрэн гүйцээгүйгээс цусанд билирубины хэмжээ түр хугацаанд ихсэх	Янз бүрийн шалтгаан	Хангалтгүй хөхүүлэлтээс шалтгаалсан калорийн дутагдал, шингэн алдалт	Хөхний сүүтэй холбоотой
Шинж тэмдэг ба явц	– Хөнгөн шарлалт – Төрсний дараах 24 цагийн дараа илэрч, 3 дахь өдөр хамгийн хүчтэй – 7–10 хоногийн дараа аяндаа арилна	– Төрсний дараах 24 цагийн дотор илрэх, шинж тэмдэг хурдан даамжрах – Хөхүүлэлтгүй ч 10–14 хоногоос дээш үргэлжилбэл эмгэгийн гаралтай байж болзошгүй – Хөхөхгүй, хоол идэхгүй – Сул дорой болох – Өтгөний өнгө цайвар – Шээсний өнгө хар бараан	– Төрсний дараах 3 хоног–1 долоо хоногт илэрнэ – Ойр ойрхон хооловлол 1 долоо хоногоос шинж тэмдэг намжина	– Төрсний дараах 1 долоо хоногт илэрч 10 долоо хоног хүртэл үргэлжилж болно – Хөхүүлэлтийг үргэлжлүүлбэл шинж тэмдэг аажмаар сайжирна
Урьдчилан сэргийлэх ба арга хэмжээ	–	– Яаралтай эмнэлэгт үзүүлэх	– Төрсний дараа 30 минут 3 цаг тутам өдөрт 8 ба түүнээс дээш удаа хөхүүлэх	– Хөхүүлэлтийг тогтмол үргэлжлүүлэх – Төрсний дараах 1 сарын дараа ч нүдэнд харагдахуйц шарлалт байвал эмнэлэгт үзүүлэх

Эх сурвалж: Hong Chang's Pediatrics, 12 дахь хэвлэл.

9) Ивэрхий

① Цавины ивэрхий


- Дотор эрхтнүүд нь хэвлийн хөндийд байрлаж, хэвлийн гялтан хальсаар бүрхэгдсэн байдаг. Эдгээр эрхтэн өөрийн байршлаасаа гадагш шилжин гарч ирвэл ивэрхий гэнэ. Ялангуяа цавины (гуяны дээд хэсгийн) хэсэгт үүсвэл цавины ивэрхий гэж нэрлэнэ.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Хүүхэд чангаар уйлах, баах үедээ хэвлийн даралт нэмэгдэж гэдэсний нэг хэсэг цавины хэсэг рүү доош шилжиж, ивэрхий үүсдэг.
- Хэрэв ивэрхий өөрөө засрахгүй, цавины нүхэнд гацаж, цусны эргэлт саатвал гэдэсний эд үхжилд хүргэж болзошгүй ноцтой байдал үүснэ. Иймээс ивэрхий сэжиглэгдсэн тохиолдолд мэргэжлийн эмчид яаралтай үзүүлэх хэрэгтэй.

② Хүйсний ивэрхий

- Хүйсний цагираг (хүйсний эргэн тойрон дахь нүх) бүрэн хаагдаагүйгээс шалтгаалан хүүхэд уйлах эсвэл ханиах үед гэдэсний хальс эсвэл нарийн гэдэсний нэг хэсэг хүйсний хэсгээр овойж гарч ирэхийг хүйсний ивэрхий гэж нэрлэнэ.
- Хүйсний ивэрхий нь дутуу төрсөн нярай болон эмэгтэй хүүхдэд голчлон ажиглагддаг бөгөөд цавины ивэрхийн адил гэдэс саажиж цусны эргэлт тасарч эд үхжилд хүргэх аюул багатай.
- Ихэнх тохиолдолд хэмжээ нь 1 см-ээс бага бөгөөд 95%-д нь төрсний дараах эхний нэг жилийн дотор өөрөө аяндаа эдгэрдэг.
- Харин 1-2 наснаас хойш хэмжээ нь томорч байгаа эсвэл 3-4 нас хүртэл арилахгүй хэвээр байвал хүйсний цагирагны дутагдлыг нөхөх мээ заслын эмчилгээ шаардлагатай.



10) Атопийн дерматит

- Атопийн дерматит нь харшлын гаралтай үрэвсэлт арьсны өвчин бөгөөд ихэвчлэн төрснөөс хойш 2 сар өнгөрсний дараа илэрч, нярай хүүхдийн 2-8%-д ажиглагддаг.
- Шалтгаан нь тодорхойгүй боловч удамшлын болон хүрээлэн буй орчны хүчин зүйлтэй холбоотой гэж үздэг. Атопийн дерматиттай нярай хүүхэд харшлын гаралтай хамрын үрэвсэл (аллергит ринит) болон астма өвчинд өртөх магадлал өндөр байдаг.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

- Шинж тэмдэг нь улаан тууралт гарах загатнах, шүүрэл гарах, эсвэл хаг үүсэх зэрэг орно. Мөн биеийн олон хэсгийн арьс маш их хуурайшиж, цагаан хайрстай болж, хайрс мэт харагдана. Хэрэв шинж тэмдэг хүндэрвэл заавал мэргэжлийн эмчийн эмчилгээ шаардлагатай.

< Атопийн дерматитаас сэргийлэх ба зовиурыг намжаах аргууд >

- а. Хүүхдэд харшил өгөх сүүний уургийн нөлөөг багасгахын тулд хөхөөр хооллоно.
  - б. Хоол хүнсний харшил үүсэхээс сэргийлэхийн тулд нэмэгдэл хоолыг 6 сар өнгөрсний дараа эхлүүлнэ.
  - в. Хэт халуун эсвэл хуурай орчинд шинж тэмдэг дорддог тул өрөөний температурыг 2 6°C – аас бага, чийгшлийг 50% – иас дээш байлгах.
  - г. Зөв агааржуулалт, нарны гэрлээр орчныг цэвэр, эрүүл байлгана.
  - д. Тоосны хачиг ихээр хуримтлагддаг орны хэрэглэл, хивс зэргээс хүүхдийн арьсыг шууд хүргэхээс зайлсхийх.
  - е. Бүлээн усаар долоо хоногт 2-3 удаа хүүхдийг угаана.
  - ж. Угаасны дараа чийгшүүлэгч тос түрхэж, арьсыг хуурайшиж гэмтэхээс хамгаална.
3. Шинж тэмдэг хүндэрсэн үед нунтаг цацлага хэрэглэхгүй.

11) Мөгөөрсөн хоолойн төрөлхийн нарийсал

- Нярай болон бага насны хүүхэд амьсгаа авах үед хүнгэнэх чимээ гардаг бөгөөд үүнийг төрөлхийн мөгөөрсөн хоолойн нарийсал гэдэг.
- Эхний хэдэн сарын турш шинж тэмдэг даамжирч, хөхүүлэхэд хүндрэл учирч, өсөлт хөгжил удаашихаар нь бий. Гэвч амьсгалын зам аажмаар хөгжихийн хэрээр шинж тэмдэг сайжирч, ихэвчлэн 18 сартай болоход аяндаа эдгэрнэ.
- Тусгай эмчилгээ шаардлагагүй боловч ханиад хүрэх, уйлах үед шинж тэмдэг сэдэрдэг тул амьсгалын дээд замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй.
- Хөхүүлэхэд хүндрэлтэй бол жижиг хөхний толгойтой үед хэрэглэдэг сав ашиглах эсвэл дуслаар хооллох аргыг хэрэглэнэ.

12) Амны салстны мөөгөнцөр

- Хэлний гадарга, тагнай, буйл болон амны салст дээр цагаан өнгөр мэт зүйл наалдсан байж, самбай эсвэл даавуугаар арчиж болохгүй, хүчтэй арчихад цус гарах бол үүнийг амны салстны мөөгөнцөр гэнэ.
- Амны мөөгөнцөр нь \*\*Кандида мөөгөнцөр\*\* ийн халдвараар үүсдэг. Энэ нь төрөлтийн явцад эхээс хүүхэд рүү халдвар дамжих эсвэл төрсний дараа ариун цэвэр муу хөхний толгой, тоглоомноос халдварлах замаар үүсдэг.

- Урьдчилан сэргийлэхийн тулд хөхний толгойн ариун цэвэр, хөхний толгойг тогтмол ариутгах нь чухал. Халдвар авсан тохиолдолд хүүхдийн эмчид үзүүлж эмчилгээ хийлгэнэ.
- Хөхөөр хооллож байгаа хүүхэд амны мөөгөнцөртэй бол ээж нь мөн хамт эмчилгээ хийлгэх шаардлагатай.



[Зураг 16] Амны салстны мөөгөнцөр

### 13) Нярайн гэдэс базлалт (Infantile colic)

- Төрсний дараах 4 долоо хоногоос эхлэн хүүхэд өдрийн турш тайван тоглож байгаад эсвэл шөнө сайн унтаж байгаад гэнэт амьсгал нь давчдаж байгаа мэт хүчтэй, татганан уйлж эхлэх тохиолдол байдаг. Ийм үед хүүхдийг тайвшруулах гэж оролдсон ч хэсэг хугацаанд уйлсаар байгаад гэнэт уйлахаа больж тайван тоглож эхлэх эсвэл унтаж болно. Үүнийг нярайн гэдэс базлалт гэх ба ихэвчлэн 3–4 сартайд аяндаа арилдаг.
- Шалтгаан нь их идэх, хоол боловсруулахад хүндрэлтэй байх, өтгөн хатах, сүүний уурагт харшилтай байх зэрэг байж болно. Мөн хүүхэд хэт их өлсөх эсвэл хэт цадсан үед, их ядарсан үед, эсвэл хооллохдоо агаарыг ихээр залгисан үед ч гэдэс базлалт үүсдэг.
- Гэр бүлийн харилцаа тогтворгүй байх, эцэг эхийн маргаан их байх, орчин чимээтэй, эмх замбараагүй байх зэрэг нь бас нөлөөлдөг.
- Гэдэс базлалтаас сэргийлэхийн тулд өрөөний температурыг хэт халуун эсвэл хүйтэн байлгахгүй байх, хувцсыг бариу биш тав тухтай өмсгөх, живхийг норвол шууд солих хэрэгтэй.
- Хүүхдийг хөхүүлэхдээ хэвтүүлж биш, тэвэрч хөхүүлж, хөхний савыг хангалттай налуулж агаарыг бага залгиулах, хооллосны дараа заавал хэрхүүлэх хэрэгтэй. Телевиз болон хөгжмийн дууг хэт чанга тавихгүй, орчныг цэвэр цэмцгэр байлгана. Хүүхдийг асарч буй ээж болон гэр бүлийнхэн үргэлж тайван, аз жаргалтай хандах нь чухал.
- Хүүхдийн гэдсийг дулаацуулахын тулд бүлээн ус хийсэн шилэн савыг гэдэсн дээр нь тавих эсвэл гэдсийг нь зөөлөн илэх нь өвдөлтийг намдаахад тусална.
- Хүүхдэд хөхөлт хөхүүлэх нь тайвшруулахад тустай.

- Ямар ч арга хэрэглэсэн ч хүүхэд хэдэн цагийн турш уйлсаар байвал, шулуун гэдэс цэврлэх (клизм) аргыг хэрэглэж гэдэсэнд байгаа өтгөн болон хийг гадагшлуулж болно.

#### 14) Нярайн аюулгүй байдлын менежмент (Эх сурвалж: Эрүүл мэнд, халамжийн яам & Хүүхдийн бодлогын судалгааны хүрээлэн (2024), Төрсний дараах сувилгаа, асаргааны гарын авлага)

##### ① Амьсгалын замд хоол орохоос сэргийлэх

- Нярай хүүхдийн амьсгал тогтвортой байхад хооллолт чухал нөлөөтэй.
- Байнга гулгих хамгийн түгээмэл шалтгаан: хооллох үед орсон агаар гэдэс дүүргэдэг.
- Нярайд хөхөө бариулахгүй байх.
- Толгойг өндөрлөж тэвэрч, ажиглан хооллох.
- Хооллох явцад ханиалгах, арьс цэнхэр болох зэрэг шинж тэмдэг илэрвэл шууд зогсоож, хүүхдийг тайван болсны дараа дахин хооллох.
- 2-3 цаг тутамд бага багаар хооллох.
- Хооллохын өмнө болон дараа хийг гаргаж гэдэс дүүрэлтийг бууруулах.
- Хооллосны дараа хүүхдийг дээш харуулж хэвтүүлэхгүй, толгойг нь хажуу тийш эргүүлж эсвэл хажуудуулж унтуулах.

##### ② Биений хэмийг хадгалах

- Нярай хүүхдийн биений дулаан барих чадвар сул, насанд хүрэгчдээс илүү хүйтэнд мэдрэмтгий тул биений дулааныг тогтвортой барих нь чухал.
- Биений дулааныг хэмжихдээ биенийг ил гаргах хугацааг аль болох бага байлгаж, хүрэлцэх зүйлсийг урьдчилан дулаацуулна.
- Усанд оруулах хугацаа 5–10 минутын дотор байна.
- Хүүхдийг агааржуулагчийн шууд салхинд өртүүлэхгүй байх.

##### ③ Нярайн гэнэтийн нас баралтын хам шинжээс (SIDS) урьдчилан сэргийлэх

(Эх сурвалж: Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв, Үндэсний эрүүл мэндийн мэдээллийн портал)

- Тодорхойлолт: Нэг нас хүрээгүй нярай хүүхэд гэнэт нас барсан боловч задлан шинжилгээ болон бусад шинжилгээгээр шалтгаан тодорхойлогдоогүй тохиолдол.
- Эрсдэлт хүчин зүйлс: Хүүхдийг дохиолдож (унтуулж) хэвтүүлэх, эхийн тамхи таталт, архины хэрэглээ, дутуу төрөлт гэх мэт.
- Урьдчилан сэргийлэх зөвлөмж:
  - Нярайг хүүхдийн ор эсвэл өлгийтэй орон дээр унтуулах.
  - Эхний 6 сардаа эцэг эхтэйгээ нэг өрөөнд унтах.
  - Эхийн орон дээр хамт унтуулахгүй байх.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа



- Хүүхдийг дээш харуулж унтуулаад, хүүхдийн өлгий эсвэл орны хатуу даавуу сонгох ба зөөлөн дэр эсвэл тоглоом тавихгүй.\*\*



- Нярайг унтуулахдаа нүүр нь малгай, ороолт, живх даавуу зэрэг зүйлсээр дарагдахгүй байхад анхаарна.



- Нярайн гэнэтийн нас баралтаас урьдчилан сэргийлэхийн тулд хөхөөр хооллолтыг зөвлөж байна.
- Нярайн гэнэтийн нас баралтаас урьдчилан сэргийлэх аргын талаар эхэд сургалт өгнө.
- Нярайн амьсгалын байдал, арьсны өнгөний өөрчлөлтийг тогтмол ажиглана.
- Жирэмсэн болон төрсний дараах үед тамхи татах, архи хэрэглэхээс зайлсхийх.

④ Амьсгалын замын бөглөрөл (гадны биетээс шалтгаалах)

- Гадны биет амьсгалын замд орсноор амьсгалын замыг хааж, амьсгалах боломжгүй болж богино хугацаанд амь насанд аюултай байдалд хүргэж болно.
- Амьсгалын замд гадны биет орвол эхлээд хөнгөн ханиах шинж илэрнэ.
- Ханиалгах үед амьсгалахад шүгэлдэх мэт чимээ гарч, царай цонхийж болно.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

- Хүндэрсэн тохиолдолд амьсгалах боломжгүй болж, ханнах чимээ гарахгүй, ярьж чадахгүй болно.

<Хүснэгт 5> Нярайн амьсгалын зам бөглөрөлд үзүүлэх яаралтай тусламж (Хэймлихийн арга)

Алхам	Арга	Тусламжийн тайлбар
1-р алхам		1. Байрлалыг зөв авах, 103-т мэдэгдэх <ul style="list-style-type: none"> <li>• Ойр байгаа хүнээр 103-т дуудлага өгүүлэх.</li> <li>• Хүүхдийг нүүр нь дээш харсан байдлаар гар дээрээ тавьж, толгой болон хүзүүг гараараа тогтвортой барина.</li> <li>• Нөгөө гараараа хүүхдийг нүүр нь доош харсан байрлалд эргүүлж, эрүүг барьсан гараараа тулж барина.</li> </ul>
2-р алхам		2. Нуруу руу 5 удаа цохих <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн толгойг цээжнээс нь доош байрлуулж, хүүхдийг тэвэрсэн гараа гуян дээрээ тогтооно.</li> <li>• Гарны алгаараа хүүхдийн хоёр далны хооронд 5 удаа цохино.</li> </ul>
3-р алхам		3. Цээж шахалт 5 удаа <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн нурууг тулж, толгойг цээжнээс доош байрлуулж, хүүхдийг тэвэрсэн гараа өвдөг дээрээ тавина.</li> <li>• Хүүхдийн хоёр хөхний толгойг холбосон шугамын доогуур хурууны хоёр хурууг (долоовор ба дунд хуруу) цээжний яс дээр байрлуулж, тодорхой хүчтэй 5 удаа дарна. (Даралт хийх үед хуруугаа цээжнээс салгахгүй.)</li> </ul>
4-р алхам		4. Амаас гадны биетийг авах <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн амны хөндийд байгаа биетийг шалгаж, хүрч болох бол авна. (Хүрэхгүй биетийг хүчээр авах гэж оролдохгүй.)</li> <li>• Хүүхэд ухаан алдах, биет гадагшлах, хүчтэй амьсгалах эсвэл ханнах хүртэл дээрх үйлдлийг давтана.</li> <li>• 103 түргэн тусламж иртэл давтан хийнэ.</li> </ul>

Эх сурвалж: Төв яаралтай тусламжийн төв, Суурь яаралтай тусламжийн гарын авлага ([https://www.e-gen.or.kr/egen/first\\_aid\\_basics.do?contentsno=20](https://www.e-gen.or.kr/egen/first_aid_basics.do?contentsno=20))

⑤ Нярай болон бага насны хүүхдийн зүрх-уушгины сэхээн амьдруулалт (CPR)

- Нярай болон нэг хүртэлх насны хүүхдэд зүрх зогсох гол шалтгаан нь **\*\*амьсгалын дутагдал** болон нярайн гэнэтийн нас баралтын хам шинж юм.

I. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- I наснаас дээш хүүхдэд гол шалтгаан нь гэмтэл байдаг.
- Насанд хүрэгчдийн гэнэтийн зүрх зогсолтоос ялгаатай нь бага насны хүүхдийн зүрх зогсолтын ихэнх тохиолдлыг урьдчилан сэргийлэх боломжтой



[Зураг 17] Нярай болон бага насны хүүхдийн авралын гинж

Эх сурвалж: Солонгосын Зүрх-Уушгины Сэхээн Амьдруулах Нийгэмлэг

<Хүснэгт 6> Нярай болон бага насны хүүхдийн цээж шахалт

1 наснаас доош нярайд цээж даралт хийх	Арга
	<p>Хоёр хөхний толгойг холбосон шугам ба цээжний ясны уулзварын доор нэг хурууны зайд хоёр хуруугаар дарж, минутанд 100 удаа, 4 см гүнээр даралт хийнэ.</p>
1-8 насны хүүхдэд цээж даралт хийх	Арга
	<p>Цээжний ясны хагас хэсэгт нэг эсвэл хоёр гарын хуруугаар минутанд 100 удаа, 5 см гүнээр даралт хийнэ.</p>

Эх сурвалж: Содэмүн дүүргийн Эрүүл мэндийн төв, Хүүхэд ба нярайн зүрх-уушгины сэхээн амьдруулах гарын авлага (<https://www.sdm.go.kr/health/contents/medicine/drug-safety/InfantsCpr>)

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

<Хүснэгт 7> Нярай болон бага насны хүүхдийн зүрх-уушгины сэхээн амьдруулах (CPR)

Алхам	Арга	Тусламжийн тайлбар
1-р алхам	Хариу үзэж буй эсэхийг шалгах	Хүүхдийг зөөлөн цохиж “Хүүс ээ, зүгээр үү?” гэж дуудах, нэрийг нь мэдэж байвал нэрээр нь дуудах.
2-р алхам	119-т мэдэгдэх	Хариу байхгүй бол орчин тойрныхноос тусламж дуудаж, 119-т шууд мэдэгдэнэ.
3-р алхам	Зүрх-уушгины сэхээн амьдруулах арга (CPR)	Аврагч ганцаараа бол цээж даралт: хиймэл амьсгал = 30:2 харьцаагаар гүйцэтгэнэ. Хоёр аврагч байвал нэг нь цээж дарж, нөгөө нь хиймэл амьсгал өгнө. Харьцаа: 15:2.Цээж даралт: минутанд 100 удааХиймэл амьсгал: минутанд 8-10 удаа. Нярайн тохиолдолд хамар, ам хоёрыг хамтад нь хааж хиймэл амьсгал өгнө.

4 Нярай болон нэг хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн менежмент

- Нярай үеийг төрснөөс хойш 1 нас хүртэлх хугацаа гэж тодорхойлдог бөгөөд энэ үе бол хүний амьдралын хамгийн хурдан өсөлттэй үе тул зохистой шим тэжээл авах нь маш чухал юм. Шаардлагатай шим тэжээлийг нөөцлөх цаг байхгүй учир өдөр бүр тохирсон хоол хүнс хэрэглэх шаардлагатай.
- Нярай хүүхдийн шим тэжээлийн зөвлөмжийг хэвийн өсөлттэй, эхийн сүүгээр хооллодог хүүхдийг суурь болгон тогтооно. Шим тэжээлийн менежмент хийхдээ зөвхөн тэжээлийн зөвлөмж бус, мөн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай шим тэжээлийг харгалзан үзнэ.

1) Энерги

- Нярай хүүхдийн биеийн жинд харьцуулсан биеийн гадаргуу их, бодисын солилцоо идэвхтэй эд эс ихтэй тул энергийн хэрэгцээ өндөр.
- Төрснөөс хойш 4 сар хүртэлх хугацаанд энергийн зөвлөмж нь 1 кг жинд 108 ккал, 4 сараас 12 сар хүртэлх хугацаанд 1 кг жинд 93 ккал гэж зөвлөдөг.
- Амьдралын эхний жилд авсан энергийн 85-90% нь өсөлт болон эд эрхтний хөгжилд, үлдсэн 10-15% нь хөдөлгөөнд зарцуулагддаг.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

<Хүснэгт 8> Нярайн энергийн хэрэгцээний тооцоолол

Нас	Өндөр (см)	Жин (кг)	Энергийн хэрэгцээ (ккал/өдөр)
Нярай 0-5 сар	61.9	6.5	600
6-11 сар	72.3	9.1	730

2) Уураг, нүүрс ус, өөх тосны зөвлөмж хэмжээ

- Уургийн зөвлөмж хэмжээ нь төрөх үед өдөрт биеийн жингийн 1 кг тутамд 3.1 г байх ба 6 сартайгаас хойш өсөлтийн хурд буурахад 2.37 г болгон багасгана.
- Нярай хүүхдэд 11 төрлийн зайлшгүй шаардлагатай амин хүчлийг агуулсан бүрэн уураг өгөх ёстой. Ялангуяа гистидин нь нярайд онцгой шаардлагатай амин хүчил юм.
- Нүүрс ус болон өөх тосны зөвлөмж хэмжээ нь тусгайлан тогтоогдоогүй. Эхийн сүү болон нэмэлт тэжээлгээр хооллодог хүүхдийн хоолны илчлэгийн харьцаа нь өөх тос 40-45% байдаг.
- Нийт илчлэгийг хангаж, цадах мэдрэмжийг өгөхийн тулд нүүрс усны эзлэх хувь 60%-иас бага, өөх тос 30%-иас дээш байх ёстой. Мөн нийт илчлэгийн 3%-ийг зайлшгүй өөх тосны хүчлээс авах ёстой.

3) Шингэн

- Нярай хүүхэд насанд хүрэгчдээс арьс болон амьсгалын замаар шингэн алдалт ихтэй, бөөрний үйл ажиллагаа бүрэн хөгжөөгүй тул шээс хадгалах чадвар сул байдаг. Тиймээс илүү их шингэн шаардлагатай.
- Халуун, халуурах, бөөлжих, суулгах үед шингэний тэнцвэр алдагдаж, усгүйжилт үүсэхээс сэргийлэх хэрэгтэй.
- Шингэн нь өдөрт биеийн жин 1 кг тутамд 120~150 мл байх шаардлагатай бөгөөд энгийн үед эхийн сүү эсвэл нэмэлт тэжээлээр хангаж болно.

4) Эрдэс

① Төмөр

- Эрүүл нярай хүүхэд нь умайд байхдаа эхээсээ төмрийг идэвхтэйгээр авч, төрөхдөө 4-5 сар хүртэлх хугацааны өсөлтөд хангалттай төмөртэй төрдөг.
- Төмөр нь амьтны гаралтай хүнс (сүүн тэжээлтэн, загас, шувуу, өндөгний шар) болон ногоон хүнсний ногоо, буурцагт ургамалд элбэг байдаг.
- Эхийн болон үнээний сүүнд төмрийн агууламж бага байдаг. Эхийн сүүний төмрийн шимэгдэлт ~50%, төмөр нэмсэн тэжээлийнх ~7%, хүүхдийн будаа ~4% шимэгддэг.
- 4-5 сартайгаас эхлэн төмөр агуулсан нэмэлт хоол өгч төмрийн дутагдлаас үүдэлтэй цус багадалтаас сэргийлнэ.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

- Нярай нь биеийн жин 1 кг тутамд 1 мг төмөр авбал гемоглобины түвшинг хэвийн хадгалж чадна.
- Солонгос нярай хүүхдийн төмрийн зөвлөмж:
  - Төрснөөс 4 сар хүртэл: 6 мг
  - 5~12 сар: 10 мг

② Фтор

- Манай улсад фторын албан ёсны зөвлөмж хэмжээ байхгүй ч шүдний эрүүл мэндэд чухал тул нярай, бага насанд онцгой ач холбогдолтой.
- Эхийн сүүний фторын агууламж нь эхийн хоол хүнснээс бараг хамаарахгүй, харин эхийн сүү болон нэмэлт тэжээлд фтор бага тул 4~6 сараас фтор нэмэлт өгөх нь зүйтэй.
- Нэмэлт тэжээл уудаг нярай хүүхдийн фторын хэрэгцээ нь тухайн бүс нутгийн ундны усны фторын агууламжаас шалтгаална.

5) Витамин

- Витамин нь биед бага хэмжээгээр байдаг ч бодисын солилцоо, биеийн хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй. Бие махбодид ихэнх витамин нийлэгждэггүй тул хоол хүнсээр дамжуулан авах шаардлагатай.
- Тосонд уусдаг витамин нь биед хуримтлагдаж, хэтрүүлэн авбал хордлого үүсгэж болно.
- Нарны гэрэлд хангалттай байж чадахгүй эхийн сүүгээр хооллодог хүүхдэд өдөрт 400 IU витамин D нэмэлт хэрэглэхийг зөвлөдөг. Харин худалдаанд байдаг нэмэлт тэжээл, хүүхдийн сүүн тэжээлүүдэд бүх витамин зохистой хэмжээгээр агуулагдсан байдаг.
- Төрсний дараа 0.5~1.0 мг витамин К-г булчинд тарих нь цус алдалттай холбоотой өвчнөөс үр дүнтэй сэргийлдэг. Үүний дараа гэдэсний бичил биетнүүд витамин К-г нийлэгжүүлдэг тул өөх тосны солилцооны эмгэгтэй тохиолдлоос бусад үед нэмэлт хэрэглэх шаардлагагүй.

<Хүснэгт 9> Нярай хүүхдийн витамин ба эрдэс бодисын нэмэлт хэрэгцээний хэмжээ

Хооллолтын төрөл	Төмөр	Витамин D	Фтор
Эхийн сүү	6 сараас хойш төмрөөр баяжуулсан хүүхдийн будаа эсвэл төмрийн нэмэлт өгөх шаардлагатай	Хүүхэд нарны гэрэлд бага хугацаанд байх тохиолдолд витамин D нэмэлт хэрэгтэй	Ундны усны фторын агууламжаас шалтгаалан нэмэлт хэрэгцээтэй байж болно
Нэмэлт тэжээл (нэмэлт тэжээл)	Нэмэлт тэжээлд төмөр агуулаагүй бол 4 сараас эхлэн нэмэлт өгөх шаардлагатай	Нэмэлт өгөх шаардлагагүй	Шууд найруулсан сүү уудаг хүүхэд болон ундны усны фторын агууламжаас хамааран нэмэлт хэрэгтэй байж болно

## 5 Хөхүүлэх

### 1) Эхийн сүүгээр хооллох

#### ① Эхийн сүүний онцлог

- Төрсний дараах 2–4 хоногт ялгардаг ангир уураг (анхны сүү) нь боловсорсон сүүнээс уураг болон эрдэс бодисын агууламж өндөр, нүүрс ус болон өөх тосны агууламж бага байдаг тул ходоодны багтаамж бага, шингээх чадвар сул нярайд хамгийн тохиромжтой хоол тэжээл юм.
- Анхны сүү нь нярайг зунгаага хурдан гадагшлуулах бөгөөд, түүнд агуулагдах өндөр тунтай дархлааны глобулин болон өсөлтийн дааврууд нь халдвараас сэргийлж, өсөлт хөгжилтийг дэмждэг.
- Анхны сүү нь төрснөөс 15 хоног–1 сарын дотор бүрэн боловсорсон сүү болж хувирна. Боловсорсон сүүнд хүүхдийн өсөлт болон тархины хөгжлийг дэмжих уураг, гол энергийн эх үүсвэр болох өөх тос, төмөр зэрэг шим тэжээлүүд агуулагддаг.
- Нярай хүүхдийн бөөр нь их хэмжээний шингэнийг боловсруулах чадвар сул тул эхийн сүү нь бөөрөнд ачаалал өгөхгүйгээр илүүдэл шингэнийг гадагшлуулна.
- Эхийн сүү эхэндэс ус болон эрдэс бодис ихтэй цэнхэрдүү өнгөтэй байдаг бөгөөд энэ нь хүүхдийн цангааг тайлж, түр зуурын өлсгөлөнг дарна. Хэдэн минутын дараа хүүхэд цадмагц өөх тос болон шим тэжээл ихтэй өтгөн сүү (дараах сүү) ялгарч эхэлдэг. Энэ нь хүүхдийн эрч хүчний эх үүсвэр болохоос гадна удаан хугацаанд цатгалан байлгадаг.
- Анхны болон дараах сүү нь хүүхдийн өсөлтөд хэрэгтэй шингэн болон шим тэжээл агуулдаг тул хоёуланг нь бүрэн хөхүүлж өгөх ёстой.

#### ② Эхийн бие махбодид үзүүлэх давуу тал

- Окситоцины ялгаралтыг өдөөж умай агшилтыг дэмждэг тул төрсний дараах цус алдалт буурна.
- Эх болон хүүхдийн биеийн ойр байдал нь хүүхдэд тайвшрал өгч, эхийн мэдрэлийг тогтворжуулдаг.
- Жирэмсэн үеийн жинг бууруулахад тусалдаг. Жирэмсэн үед нэмэгдсэн жин нь хөхүүлж байх үед энерги болон зарцуулагдаж, жин бууруулахад үр дүнтэй (гэхдээ сард 2 кг-аас илүү жин хасахыг хориглоно).
- Өндгөвч, умай болон хөхний хавдрын эрдлийг бууруулж, хөхүүлж байх хугацаа урт байх тусам хамгаалах нөлөө нэмэгдэнэ.
- Байнга тохиромжтой халуун бүхий сүүгээр хүүхдээ хооллох.
- Эхийн кальцийн шимэгдэлтийг сайжруулж, яс сийрэгжилтийн эрдлийг бууруулна.

- Зөвхөн эхийн сүүгээр хооллосон тохиолдолд 6 сар хүртэл өндгөн эс ялгарахгүй байх (98% жирэмслэлтээс хамгаалах) үр дүнтэй.
- Нэмэлт тэжээлийн зардлыг хэмнэж, хүүхэд эрүүл байх тул эмнэлгийн зардал багасна.

### ③ Хүүхдэд үзүүлэх давуу тал

- Хүүхдийн дархлааны тогтолцоог бэхжүүлж, эмнэлгийн зардлыг бууруулна.
- Нэмэлт тэжээл уудаг хүүхдүүдтэй харьцуулахад амьсгалын замын өвчин, чихний үрэвсэл, гэдэсний халдвар авах магадлал бага.
- Нэмэлт тэжээлд харшил үүсгэх уураг байдаг бол эхийн сүүнд байхгүй тул шингээлт сайн байдаг.
- Нэмэлт тэжээлийн уураг нь том молекултай, шингээхэд хэцүү байдаг бол эхийн сүүний уураг зөөлөн бөгөөд шингээлт хялбар.
- Эхийн сүүний өөх тос нь хүүхдийн тархины хөгжилд чухал ханаагүй тосны хүчлүүд агуулдаг бөгөөд омега-3 тосны хүчил нь тархи болон нүдний торлог бүрхэвчийн хөгжилд чухал.
- Эхийн сүүн дэх холестерол нь даавар үүсэлт болон мэдрэлийн эдийн хөгжилд чухал бөгөөд насанд хүрсэн хойно өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд тустай.
- Эхийн сүүнд агуулагдах лактоферрин нь төмрийн шимэгдэлтийг нэмэгдүүлж цус багадалт үүсэхээс сэргийлнэ.
- Эхийн сүүний В1 витамин болон холин нь ой санамжийг сайжруулахад тусалдаг.
- Эхийн сүүнд кали зохистой хэмжээгээр агуулагддаг тул бөөрөнд ачаалал өгөхгүй, кальци ба фосфорын харьцаа тэнцвэртэй учир кальцийн дутагдлаас үүдэлтэй булчингийн чангарал багасна.
- Эхийн сүүний усны агууламж 80% тул нэмэлтээр шингэн өгөх шаардлагагүй.
- Нэмэлт тэжээлтэй харьцуулахад тархины хөгжлийг дэмжих найрлага ихтэй тул оюун ухааны хөгжилд эерэг нөлөөтэй.
- Ангир уураг нь нярайн эхний өтгөн ялгаралтыг дэмжиж, шарлалт үүсэхээс сэргийлнэ.
- Эхийн сүү нь хүүхдийн шүд цоорохоос хамгаалж, шүдний эгнээ болон эрүү-эрүүний үеийн хөгжилд тусалдаг.
- Хөхүүлж байх нь эх, хүүхдийн хооронд итгэлцэл бий болгож, сэтгэл санааг тогтвортой болгодог.
- Судалгаагаар эхийн сүүгээр удаан хооллосон хүүхдүүдийн танин мэдэхүйн оноо дундажаар өндөр байдаг.<sup>1)2)</sup>

1) Pereyra–Elias R, Quigley MA, Carson C. To what extent does confounding explain the association between breastfeeding duration and cognitive development up to age 14? Findings from the UK Millennium Cohort Study. PLoS One. 2022 May 25;17(5):e0267326.

2) Breastfeeding Duration Is Associated with Domain–Specific Improvements in Cognitive Performance in 9–10–Year–Old Children. Front Public Health. 2021 Apr 26;9:657422

## 2) Эхийн сүүгээр хооллох арга

### ① Хүүхэд хооллохыг хүсэж буй дохио

- Нүдээ нээж эргэн тойрноо харж эхлэх үед
- Гараа амаа руугаа ойртуулж, хэлээ дугуйруулан хөдөлгөх үед
- Амандаа хүрэн аливаа зүйлийг сорох гэж оролдох үед
- Нударгаа амаа руугаа хийж, орчны өдөөлтөд мэдрэг хариу үзүүлэх үед
- Уйлах нь хамгийн сүүлд илрэх дохио тул хүүхдийг ойр байлгаж анхааралтай ажиглан, уйлахаас нь өмнө хооллох нь зүйтэй.

### ② Хөхүүлэх давтамж ба хугацаа

- Төрсний дараа 30 минут -1 цагийн дотор хөхүүлнэ.
- Хүүхдийн хэрэгцээний дохиогоор хүссэн үед нь хүссэн хугацаагаар хооллоно.
- Сүүний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хооллох давтамжийг хязгаарлахгүй, 1-3 цаг тутам эсвэл түүнээс ойрхон хооллож, шөнөдөө заавал хөхүүлнэ.
- 24 цагийн дотор 8-12 удаа хөхүүлнэ.
- Төрсний дараах 4 долоо хоног хүртэл нэг талдаа 10 минут, нийт 20 минут хөхүүлэхэд хангалттай бөгөөд, хүүхэд дасах тусам хугацаа багасна.
- Хүүхэд эхэлж сүү сорох үед ангир уураг гарч, 5-6 минутын дараа өөх тос ихтэй дараах сүү гардаг тул хүүхдэд хангалттай өгөхийн тулд олон дахин хөхүүлэх талаа солихгүй байх.
- Нярай үед унтах болон хооллох цаг нь ихэвчлэн багцлагдсан байдаг.

### ③ Хөхүүл үеийн эмийн аюулгүй байдал

- Боломжтой бол эм уухгүй байхыг зөвлөж байна.
- Зайлшгүй тохиолдолд эмчийн зөвлөгөө авч, тохирох эм болон тунг сонгох шаардлагатай.

### ④ Хөх саагчийн хэрэглээ

- Хөх саагчийн төрөл
  - Гар ажиллагаатай хөх саагч: хэрэглэхэд хялбар боловч шахах хүч сул тул хангалттай хэмжээний сүү хадгалах болон ялгаруулахад хүндрэлтэй.
  - Пахилгаан хөх саагч: хүчтэй сорох үйлдлээр сүүний ялгаралтыг түргэсгэж, хангалттай хэмжээгээр хурдан саах боломжтой.



[Зураг 18] Автомат болон гар ажиллагаатай хөх шахагч

• Хөх саагч хэрэглэх арга

- ариутгасан хөх саагч, хүүхдийн сүүний сав эсвэл эхийн сүү хадгалах уут бэлдэнэ.
- Сүүний хэмжээг нэмэгдүүлэхийн тулд ойр ойрхон саах нь хамгийн чухал бөгөөд 3 цаг тутамд нэг удаа саахыг зөвлөж байна.
- Саах хугацаа нь тал талдаа ээлжлэн 5 минут орчим, нийтдээ 20 минутаас хэтрэхгүй байх ёстой.
- Хэрэв сүүний хэмжээ хангалтгүй бол боломжтой бол бүр илүү ойр ойрхон сааж, хүүхэд хөхүүлсний дараа үлдсэн сүүг саах эсвэл нэг талдаа хүүхдээ хөхүүлж байхдаа нөгөө талаас нь саах нь үр дүнтэй.
- Хөх саагчийн юүлүүрийг хэрэглэсний дараа ус болон угаалгын бодисоор сайтар угааж, буцалж буй усанд ариутгана.

⑤ Эхийн сүү хадгалах ба гэсгээх арга

- Сүүг саасны дараа шууд хүүхдэд уулгах нь хамгийн зөв бөгөөд, шууд уулгах боломжгүй бол хүүхдийн сав эсвэл хадгалах уутанд нэг удаагийн хэмжээгээр хувааж хадгална.
- Сүүний хэмжээ бага үед хөргөөд хөргөгчинд хадгалж, нэг удаагийн хэмжээнд хүрмэгц хөлдөөх нь тохиромжтой.
- Шинэхэн саасан сүүг өрөөний температурт (25°C) хамгийн ихдээ 4 цаг хүртэл хадгалж болно. Шууд уулгахгүй бол хөргөгчинд эсвэл хөлдөөгчинд хийж хадгална.
- Хадгалсан сүүтэй саван дээр саасан огноо, хэмжээг тэмдэглэж, бусад хүнтэй холилдохоос сэргийлж, температурын өөрчлөлт хамгийн бага байдаг хөргөгчний дотоод хэсэгт хадгална.
- Хөргөгчинд хадгалсан сүүг хүүхдэд өгөхдөө 55°C орчим бүлээн усанд савыг хийж бүлээсгэнэ. Хүүхдэд өгөхөөс өмнө бугуйндаа хүргэж шалгаж, бүлээхэн бол уулгана.
- Бичил долгионы зуух ашиглан халаах нь шим тэжээлийг устгаж, жигд бус халаах эрделтэй тул хориглоно.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Халаасан сүүг 30 минутын дотор хүүхдэд өгч, үлдсэнийг нь шууд хаяна.
- Хөлдөөсөн сүүг хүүхдэд өгөхөд өмнөх өдөр нь хөргөгчинд шилжүүлж аажмаар гэсгээнэ.
- Гэсгээсэн сүүг бүрэн гэссэний дараа 24 цагийн турш хөргөгчинд хадгалж болох ба дахин хөлдөөж болохгүй.
- Гэсгээсэн сүү нь тос нь ялгарч дээшээ гарч ирдэг тул савыг эсгэсрч сайн холино. Усан дээр бүлээсгэхэд тос бүрэн уусч харагдахгүй болно.

⑥ Температурын дагуу эхийн сүү хадгалах

<Хүснэгт 10> Гүйцэд төрсөн нярайд зориулсан гэрийн нөхцөлд эхийн сүү хадгалах заавар

Ангилал	Хөлдөөгч (< -4°C)	Хөргөгч (0~4°C)	Тасалгааны температур (16~29°C)
Шинэхэн саасан сүү	Зохимжтой: 6 сар, 12 сар хүртэл хадгалж болно	Зохимжтой: 4 өдөр, маш ариун нөхцөлд 5-8 өдөр хадгалж болно	Зохимжтой: 4 цаг, маш ариун нөхцөлд 6-8 цаг хүртэл хадгалж болно
Гэсгээсэн сүү	Дахин хөлдөөх боломжгүй	24 цаг хадгална	Хадгалах боломжгүй

Эх сурвалж: Хөхөөр Хооллолтын Анагаах Ухааны Академи (Academy of Breastfeeding Medicine) эмнэлзүйн протокол, 2017 он

- Өрөөний температур
  - Шинэхэн саасан сүүг өрөөний температурт (10-29°C, 50-85°F) тодорхой хугацаанд аюулгүй хадгалж болно.
  - Саах аргын ариун байдал болон өрөөний температурын нөхцөлд ихээхэн ялгаа байдаг тул судалгаанууд өрөөний температурт хадгалах хугацааны зөвлөмжүүдийг өөр өөрөөр гаргасан байдаг.
  - Өрөөний температур өндөр байх тусам хадгалж буй сүүнд агуулагдах бактерийн тоо хурдан нэмэгдэхтэй холбоотой. Температур 27-32°C (29°C=85°F) үед 4 цаг хадгалах нь зохистой дээд хугацаа байж болно. Ариун байдлыг чанд сахиж саасан сүүг бага температуртай өрөөнд 6-8 цаг хадгалж болох ч энэ хугацаанд хэрэглэгдэхгүй бол аль болох хурдан хөргөгчинд хийх нь хамгийн тохиромжтой.
- Мөс бүхий сав
  - Жижиг хөргөгч саванд 15°C (59°F) орчим мөсөөр хөргөж хадгалсан эхийн сүүний аюулгүй байдлыг судалсан судалгаа бараг байдаггүй.
- Хөргөгч
  - Сүүний чанарыг хадгалах үзүүдэлтээр хөргөгчинд хадгалсан сүүний бактерийн эсрэг үйлчлэлийг шалгасан хэд хэдэн судалгаагаар 4°C (39.2°F) температурт хадгалсан сүүний аюулгүй байдлыг баталсан.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

- Хөргөгчинд хадгалсан сүүний бактерийн эсрэг үйлчлэл 48~72 цагийн дараа мэдэгдэхүйц буурдаг.
- Хөлдөөгч
  - Саасан сүүг  $-4^{\circ}\text{C} \sim -20^{\circ}\text{C}$  ( $24^{\circ}\text{F} \sim -4^{\circ}\text{F}$ ) температурт хөлдөөхөд дор хаяж 3 сар хүртэл аюулгүй байдаг нь тогтоогдсон.
  - $-20^{\circ}\text{C}$  ( $-4^{\circ}\text{F}$ ) температурт 6 долоо хоногоос дээш хугацаанд хадгалсан сүүг гэсгээхэд саах үеийнхтэй адил бактерийн төрөл зүйл болон тоо хадгалагдсан байдаг.
  - Хоол хүнсийг  $-18^{\circ}\text{C}$  ( $0^{\circ}\text{F}$ ) температурт хөлдөөх нь бактериар бохирдохоос урт хугацаанд хамгаалдаг боловч, хүнсний доторх ферментийн процесс үргэлжилдэг тул сүүний чанарт өөрчлөлт орж болзошгүй.
  - Шинэхэн сүүтэй харьцуулахад 90 хоногийн хөлдөөлтийн дараа сүүний өөх тос, уураг, илчлэгийн хэмжээ буурдаг.
  - Хөлдөөгдсөн сүүнд 3 сар хадгалахад чөлөөт өөхний хүчил ихэсдэг бөгөөд энэ нь липазын үйл ажиллагаа үргэлжилж байгаатай холбоотой.
  - Цөөн тооны судалгаагаар E витамин удаан хугацааны хөлдөөлтөд тогтвортой байдаг бол C витамин агууламж 1~5 сарын дараа мэдэгдэхүйц буурдаг.
  - Хөлдөөлтийн үед сүүний зарим биологийн идэвхт бодисууд буурдаг. Лактоферриний хэмжээ болон идэвх нь  $-20^{\circ}\text{C}$ -д 3 сар хадгалсан сүүнд мэдэгдэхүйц багасдаг. Гэсэн хэдий ч олон төрлийн цитокин, IgA болон анхны сүүний өсөлтийн хүчин зүйлүүд нь  $-20^{\circ}\text{C}$ -д дор хаяж 6 сар хүртэл тогтвортой байдаг.

### 3) Нэмэлт тэжээл

#### ① Нэмэлт тэжээл

- Эхийн сүүгээр хооллох боломжгүй үед нярайд эхийн сүүний найрлагад ойролцоо тэжээл өгөх зорилготойгоор үйлдвэрлэгдсэн бөгөөд эхийн сүүтэй адил дархлаа үүсгэгч агуулаагүй.
- Хүүхдийн сав, хөхний хөхөлт зэрэг хэрэгслийг усаар угаасны дараа төрсний дараах эхний 1 сар буцалсан усанд ариутгаж хэрэглэх ёстой. Учир нь амьдралын эхний 1 сар нь дархлаа сул үе бөгөөд халдварын эрсдэл өндөр байдаг.
- Хүүхдийн сүүг тус бүрд нь шинээр найруулж өгөх ёстой бөгөөд урьдчилж бэлдсэн болон үлдсэн сүүг хүүхдэд өгөхгүй.

<Хүснэгт 11> Зах зээл дээрх нэмэлт тэжээлийн төрөл

Төрөл	Тайлбар
Стандарт нэмэлт тэжээл	Эрүүл, хэвийн өсөлттэй нярайд зориулсан бүтээгдэхүүн бөгөөд гол түүхий эд нь тосгүй сүү. Үүнд ургамлын тос, нүүрс ус нэмсэн бөгөөд уургийн агууламжийг бууруулсан.
Тусгай зориулалтын нэмэлт тэжээл (мэргэжилтэнтэй зөвлөлдөнө)	Шар буурцагны нэмэлт тэжээл Галактоземитэй, лактоз үл тэвчихтэй, сүү болон сүүн бүтээгдэхүүнд харшилтай хүүхэд, веган ээжтэй хүүхэд, эсвэл гэр бүлийн удамшлын экземтэй хүүхэд хэрэглэнэ. • Дотоодын брэнд: 호프-알레기 (남양), soy-A (매일), 알소이 (Nestlé), 트루담 소이 (일동 후디스) • Гадаадын брэнд: Soya, Infasoy, Isomil, Prosobee, Wysoy
	Уургийг гидролиз хийсэн нэмэлт тэжээл Сүүний уургийг гидролиз хийж гаргасан пептид ашиглан үйлдвэрлэсэн тусгай зориулалтын сүү. Голчлон сүүний уурагт харшилтай хүүхэд болон шингээлт муутай хүүхэд хэрэглэнэ. • Бүрэн гидролиз / хэсэгчлэн гидролиз хийсэн нэмэлт тэжээл гэж ангилна. • Дотоодын брэнд: HA-조제유 (매일), HA-21 (매일) • Гадаадын брэнд: Pregestimil (MeadJohnson), Neutrogena (MeadJohnson), MA-1 (Morinaga), Almentum (Ross), PeptiJunior (Netricia), HNANA (Nestlé), Goodstart (Carnation)
	Лактозгүй эсвэл бага лактозтой нэмэлт тэжээл Хүнд хэлбэрийн суулгалтын үед гэдэсний салстат буй лактаз ферментийн идэвх алдагдсанаас хоёрдогч лактоз үл тэвчих байдал үүсэхэд хэрэглэнэ. Суулгалтын үед 1-2 долоо хоногийн богино хугацаанд хэрэглэхэд тохиромжтой. • Дотоодын брэнд: MF-1 (매일), 호프닥터 (남양), 트루담 닥터 (일동 후디스)
	Бусад тусгай зориулалтын нэмэлт тэжээл Тусгай өвчтэй нярай, удамшлын бодисын солилцооны эмгэгтэй хүүхэд (төрөлхийн бамбай булчирхайн дутагдал, фенилкетонури, гистидинури, галактоземи, гликоген хуримтлалын өвчин гэх мэт) болон дутуу төрсөн нярайд хэрэглэнэ.

② Нэмэлт тэжээл өгөхдөө анхаарах зүйл

- Нэмэлт тэжээл нь нярайн хэрэгцээнд тохирсон хэмжээгээр өгөх ёстой бөгөөд өсөлтийн муруй, биеийн жинд харьцуулсан энергийн хэрэгцээг үндэслэн хэрэглээний хэмжээг тодорхойлно. Үүнээс илүү хэрэглэвэл хэт их хооллож байгаа гэж сэжиглэж болно.
- Нэмэлт тэжээлийг хүйтэн, өрөөний температурт эсвэл биеийн температуртай өгнө. Бичил долгионы зууханд халавал жигд халагдахгүй тул хэл түлэгдэх эрсдэлтэй. Халаасны дараа сайтар сэгсэрч, хүүхдэд өгөхөөс өмнө температурыг шалгах шаардлагатай.
- Сүүтэй хамт будаа эсвэл хатуу хүнсний саванд хийж холихгүй.

- Нэмэлт тэжээл эсвэл хүнсэнд чихэр, зөгийн бал, сироп нэмэхгүй. Учир нь эдгээр нь бусад шим тэжээлгүйгээр зөвхөн илчлэг өгөх ба зарим зөгийн бал, сиропт бутулизмын нянгийн спор агуулагдаж, нярайд аюултай байж болно.
- Ерөнхийдөө нэмэлт ус өгөх шаардлагагүй бөгөөд хэт их ус өгөх нь усны хордлого үүсгэж болзошгүй.

### ③ Нэмэлт тэжээл бэлтгэх арга

- Сүүний стандарт агууламж
  - Стандарт агууламж нь 13~14% бөгөөд зааврыг дагаж мөрдөнө.
  - Нэмэлт тэжээл хийхэд хэрэглэдэг хэмжигч халбагаар тэгш дүүргэж авбал 2.614 ккал болно.
  - Ерөнхийдөө 5 халбага сүүг саванд хийж 100 мл хүртэл ус нэмбэл 67~70 ккал агуулсан стандарт агууламжтай болно.
  - Бүтээгдэхүүн бүрийн халбаганы хэмжээ болон агууламж өөр өөр байж болзошгүй тул зааврыг дагаж хийх нь хамгийн аюулгүй.
- Сүү найруулах арга
  - Сүү хийхийн өмнө сав болон хөхөлтийг сайтар угааж ариутгана, сүү хийхдээ гараа сайтар угаана.
  - Хэрэглэх ус нь хүнд металл, нянгийн бохирдолгүй цэвэр ус байх ёстой бөгөөд худалдаанд байгаа ус эсвэл цэвэршүүлсэн ус хэрэглэх боломжтой ч заавал буцалгаж хөргөж ашиглана.
  - Баталгаагүй булгийн ус, худгийн ус хэрэглэхийг хориглоно. Арвайн цай, ургамлын шингэн, модны шүүс зэрэг нь тохиромжгүй.
  - Заримдаа шөл, будаа шингэнээр найруулдаг ч, ингэснээр сүү хэт өтгөн болж сорох чадвар буурч, амт өөрчлөгдөх тул хэрэглэх шаардлагагүй.
- Хадгалалт
  - Ашиглахын өмнө хугацаа дуусах огноог шалгаж, савыг нээсний дараа өнгө, үнэр өөрчлөгдсөн эсэхийг шалгана.
  - Савыг нээсний дараа аль болох хурдан хэрэглэж, хадгалахдаа хуурай, агаар сайн солигддог газар тавина.
  - Нэг удаад хэрэглэх хэмжээгээр л сүү бэлтгэж, үлдсэн сүүг хаях нь аюулгүй, учир нь үлдсэн сүү амархан бохирдоно.
  - Нэг дор олон сав бэлтгэх бол сүүг хуурай хэлбэрээр саванд хийж, усыг тусад нь бэлдэж, хэрэглэх үед холих нь тохиромжтой.
- Хүүхдэд өгөх арга
  - Температур: Өгөхөөс өмнө заавал шалгаж, 40°C орчим байхад тохиромжтой.
  - Байрлал: Эхийн сүү өгөхтэй адил байрлалаар тэжээж, хөхөлтийг болгоомжтой

1. Нярайн эрүүл мэндийн аричлгаа

- хөхүүлэх ба сүүгээр дүүрэн байлгаж, агаарыг оруулахгүй байлгах нь чухал.
- Хугацаа: Хүүхдийн амралт, ходоодны багтаамжийг харгалзан 10–20 минут хооллох нь зөв. Хэт хурдан тэжээвэл гэнэт гэдэс дүүрэх, бөөлжих эрсдэлтэй, хэт удаан бол агаар хамт залгих эрсдэлтэй. Ихэвчлэн энэ асуудал нь хөхөлтийн нүхний хэмжээ буруу байсантай холбоотой тул тохируулна.
- Саванд сүүтэй унтах: Хүүхдийг савтай сүүтэй унтуулбал шүд цоорох, таргалалт зэрэг эрүүл мэндийн асуудал үүсч болзошгүй. Тиймээс хөхөлт ашиглах нь зөв. Хүүхэд 5–6 сартай болоход энэ зуршлыг багасгаж, 12–18 сартайд бүрэн болих нь зүйтэй.

④ Сүү найруулах хэрэгсэл сонгох

- Угж
  - Анх бэлтгэхдээ зөөлөн, уян хатан бөгөөд, сорохдоо бага зэрэг хүч шаардагдах хэмжээтэй нүхтэй угж сонгоно.
  - Хүүхдийн өсөлт, өдөр тутмын хэрэглээний хэмжээг харгалзан угжны хэлбэр, хэмжээ, материал зэргийг тохируулж солих хэрэгтэй. Хүүхэд дуртай угж хамгийн зөв сонголт болно.
  - Угж нь удаан хэрэглэвэл уян чанараа алдаж, гэмтдэг тул тогтмол солих хэрэгтэй. Ариутгал хийхэд уян чанараа хурдан алддаг тул цэвэр усаар ойр ойрхон угаах, тусгай угаагч хэрэглэх нь зүйтэй.

\* Tips \*

Шинээр төрсөн нярай	Хэт зөөлөн биш, буйланд өдөөлт өгч чадахуйц бага зэрэг хатуу угж сонгоно. Хүүхдийн хоолны хэмжээнээс хамааран нэг нүхтэй нярайд зориулсан угжийг 1 сар орчим хэрэглэх нь тохиромжтой.
1–3 сар	Хүүхэд өөрийн гар, хөлөө сорж эхэлдэг үе бөгөөд эхийн хэвлийд бүрэлдсэн сүүн шүд буйлнаас дотроо ургаж буй үе юм.
3–6 сар	Сүүн шүд буйлнаас цухуйж, ямар ч зүйлийг амандаа хийх үе тул илүү хатуу хөхөлт сонгоно.
6 сараас дээш	Шүд бүрэн ургаж эхэлж, ямар нэгийг зажилж, шүлс их гоожуулж, гараа амруу хийх үе. Энэ үед хүүхдийн сорох хүслийг хангахуйц хатуу угж хэрэглэх нь зүйтэй.

- Хүүхдийн сүүний сав
  - Хүүхдийн сав нь өнгөгүй, тунгалаг, гадаргуу нь тэгш байвал угаахад хялбар бөгөөд өндөр халуунд тэсвэртэй тул буцалгахад болон ариутгахад тохиромжтой. Сүүлийн үед хуванцар бүтээгдэхүүнээс эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бодисууд гарах талаар их яригдаж байгаа тул шилэн сав илүү түгээмэл хэрэглэх болсон.

<Хүснэгт 12> Хүүхдийн сав, хөхөлтийн төрөл ба давуу болон сул тал

 <p>Avent сав, хөхөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Савны таг болон хөхөлт нь нягт тул сав унасан ч гоожихгүй, савыг сэгсэрч доторхийг амархан хольж болно.</li> <li>• Силикон материалтай хөхөлт нь ээжийн хөхтэй төстэй хэлбэртэй, агаарыг багасгана.</li> <li>• Савны амсрыг өргөн хийсэн тул сүү болон бусад хүнс хийхэд асгарахгүй, угаахад хялбар.</li> <li>• Сав тунгалаг тул бохирдол болон үлдэгдэл амархан харагдана.</li> <li>• Цахилгаан ариутгагч, богино долгионы зуух, буцалгах ус, тусгай угаагч бодисоор ариутгаж болно.</li> </ul>
 <p>Шилэн сав, хөхөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хуванцар савтай харьцуулахад даавар төст бодисоос аюулгүй.</li> <li>• Угаахад хялбар бөгөөд толбо болон бохирдол амархан арилна.</li> <li>• Шилэн савны сүүг хүүхдэд өгөхдөө хүүхэд өөрөө барьж биш, ээж барьж уулгах нь зөв.</li> <li>• Буцалгах усанд удаан буцалгахыг зөвлөхгүй, ариутгах бол буцалж буй усанд 5~10 секунд дүрээд хатаана.</li> </ul>
 <p>PC сав, хөхөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Анх хэрэглэхийн өмнө ариутгаж, хэрэглэсний дараа шууд угаана.</li> <li>• Хөхөлтийн нүхийг дээш харуулж өгвөл сүү шүлтэй холилдож шингээлт сайжирна.</li> <li>• PC (Polycarbonate) савнаас BPA (Bisphenol A) гарах эрдэлтэй тул хэрэглээ буурсан ч хамгийн өргөн хэрэглэгддэг.</li> <li>• Үнэ хямд ч, өндөр температурт удаан буцалгах үед эрдэлтэй.</li> </ul>
 <p>PPSU сав, хөхөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• PPSU сав нь BPA агуулаагүй тул дааврын тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэхгүй.</li> <li>• Өндөр халуунд тэсвэртэй, буцалгахад аюулгүй, хэлбэр өөрчлөгдөхгүй.</li> <li>• Шилэн савнаас илүү бат бөх, хөнгөн, цохилтод тэсвэртэй.</li> <li>• Савны гол хэсэгт налуу хэлбэртэй тул хүүхэд хоёр гараараа барихад хялбар.</li> </ul>

4) Холимог хооллолт (Хөхний сүү + Нэмэлт тэжээл)

Хөхний сүү дутмаг эсвэл эх тодорхой хугацаанд сүү өгөх боломжгүй үед эхийн сүү болон нэмэлт тэжээлийг хамтад нь өгөхийг холимог хооллолт гэнэ.

① Холимог хооллолтын арга

- Эхлээд хөхний сүү өгөх: Хөхний сүү дутмаг бол эхлээд хөхүүлж, үлдэгдлийг нэмэлт тэжээлээр нөхнө. Ингэснээр сүүний ялгаралтыг өдөөдөг.

1. Нярайн эрүүл мэндийн арчилгаа

- Ажилтай эхийн арга: Өглөө, оройд хөхний сүү, өдрийн цагаар нэмэлт тэжээл өгнө. Энэ үед өдөр сүүгээ саах нь сүүний ялгаралтыг дэмждэг.

② Холимог хооллолтын үед анхаарах зүйл

- Ямар ч тэжээлийн аргаар хооллосон хүүхэд долоо хоногт 250 г-аас дээш жин нэмэх ёстой.
- Сүүний ялгаралт багасахгүй байхад анхаарна.
- Нярай үеийн сүү дутмаг тохиолдолд нэмэлт тэжээл хэтрүүлэн өгөхгүй, эхийн сүү өгөхөд тэвчээртэй байх.
- Савны хөхөлтийн нүхийг жижиг болгож сорох хүч шаарддаг болгоно.
- Нэмэлт тэжээл өгөх бол эхийн сүү өгсний дараа үлдэгдлийг өгнө.
- 3 сар хүртэл аль болох зөвхөн хөхний сүү өгч, дараа нь нэмэлт тэжээлгээр 1-2 удаа өгөх нь тохиромжтой.

5) Хөхний сүү болон нэмэлт тэжээлийн зохицуулалт

① Хүүхэд хангалттай идэж байгаа шинж

- Өдөрт 6-8 удаагийн шээсэн живх, 2-5 удаагийн баастай живх.
- Эхний 3-4 хоногт жингийн 5-7% буурдаг ч, 10 хоног-2 долоо хоногийн дотор жин хэвийн болж өснө.
- Шингэн дутагдлын шинж: арьс сулрах, уруул хуурайших, нүдний эргэн тойрон хуурайших, уйлах чимээ сулрах, халуурах, шээсэн хэмжээ багасч бараан болох.

<Хүснэгт 13> Хооллох давтамж ба хэмжээ

Сарын нас	Хооллох давтамж (өдөрт)	Ходоодны багтаамж (мл)	Нэг удаагийн хооллолтын хэмжээ (мл)	Өдрийн нийт хэмжээ (мл)	Энергийн хэрэгцээ
Төрснөөс ~1 долоо хоног	6~10 удаа	10~12	60~90	—	0180 ккал/кг), дутуу төрсөн нярайд илүү их хэрэгцээтэй6~11 сар: дунджаар 700 ккал/өдөр, 93 ккал/кг1~3 нас: дунджаар 1200 ккал/өдөр, 86 ккал/кг
1 долоо хоног~1 сар	6~8 удаа	90 (1 сар)	120~140	300~900	
1~3 сар	5~6 удаа	—	140~180	—	
4~5 сар	4~5 удаа	—	180~210	900	
6~8 сар	3~4 удаа	160 (6 сар)	210~240	800	
9~12 сар	2~3 удаа	300(12 сар)	210~240	700	
1~2 нас	1~2 удаа	600~700 (2 нас)	—	500~600	

Хүүхдийн одоогийн жин (кг) × (150-170) мл = Өдрийн нийт хооллолтын хэмжээ (мл)

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Өдрийн нийт хэмжээ (мл) ÷ 8 удаагийн хооллолт = Нэг удаагийн хооллолтын хэмжээ (мл)

Нэг удаагийн хооллолт Тайлбар	Зөвхөн эхийн сүү	100% эхийн сүүгээр хооллох
	Холимог хооллолт	Эхийн сүү > Нэмэлт тэжээл,
		эсвэл эхийн сүү болон нэмэлт тэжээл тэнцүү өгөх,
		эсвэл эхийн сүү < Нэмэлт тэжээл
Зөвхөн нэмэлт тэжээл	100% нэмэлт тэжээлгээр хооллох	

## ② Хүүхдийг хэврүүлэх

- Хүүхэд сүү уухдаа агаар залгидаг учир хооллосны дараа заавал хэврүүлэх хэрэгтэй.
- Хэврүүлэхгүй бол залгисан агаар шингээх үйл ажиллагааг саатуулж, гулгихад хүргэнэ. Хүүхэд хэвтэж байхдаа гулгивал бөөлжис хамар, амыг бөглөж амьсгал боогдох аюултай.
- Хооллосны дараа 20 минут орчим тэвэрч нурууг нь илж хийг гаргана.
- Хий гарахгүй бол хүүхдийг тэвэрч 20 минут орчим барьсны дараа баруун тийш хэвтүүлнэ.
- Баруун тийш хэвтүүлэх нь ходоодноос 12 нугалаа гэдэс рүү хоол дамжихыг хөнгөвчилж гулгихыг багасгана.
- Нэмэлт тэжээл уудаг хүүхэд гулгих магадлал өндөр тул савыг налуулж, хөхөлтийн нүхийг тагнай руу чиглүүлж, гүн хийж өгөх хэрэгтэй.
- Амархан гулгидаг хүүхдэд бага багаар ойр ойрхон өгч, хоолны дундуур болон дараа хэврүүлэх нь тохиромжтой.
- Хооллосны дараа толгойг өндөр байрлуулж унтуулах нь гулгихыг багасгана.



[Зураг 19] Баруун тийш харж хэвтэх үеийн ходоодны байдал



[Зураг 20] Хэхрүүлэх арга

#### 6) Хооллох хэрэгслийг ариутгах

- Буцалж буй усанд ариутгах:

Хүүхдийн угжны сав болон угжийг салгаж (угжны тагны цагирагыг ч бас салгана), шууд халуун усанд угаавал хатуурч болзошгүй тул бүлээн усаар сайтар угаана. Угжин дээрх үлдэгдлийг бүрэн арилгахын тулд гаднаас нь эхлэн угааж, дараа нь дотор талыг нь эргүүлж угаана. Шаардлагатай бол тусгай угаагч бодис хэрэглэж болно. Савыг ч мөн адил бүлээн усаар угааж, урт сойз ашиглан доторхыг цэвэрлэнэ. Угаагч бодисыг бүлээн усанд найруулж саванд хийж сэгсэрнэ. Доторхыг урт сойзоор эргүүлж угаагаад цэвэр усаар зайлж, дахин сойзоор угаана. Дараа нь савыг 100°C ба түүнээс дээш температуртай усанд дор хаяж 5 минут буцалгана. Ариутгасан хэрэгслийг хясаа эсвэл тусгай хатаагч дээр тавьж хатаана.

- Уураар ариутгах:

- Архийг байнга хэрэглэдэг эхээс хөхүүлж өссөн хүүхдүүдийн тархи болон мэдрэлийн тогтолцооны хөгжил удааширдаг болох нь судалгаагаар тогтоогдсон.
- Эхийн архины хэрэглээ нь сүүний ялгаралтыг бууруулж болзошгүй бөгөөд их хэмжээний архи хэрэглэх нь хүүхэд нойрмоглох зэрэг шинж тэмдгийг үүсгэж болно.
- Хөхүүлж буй эх өдөрт биеийн жингийн 1 кг тутамд 0.5 г-аас их архи хэрэглэхгүй байх ёстой. Жишээ нь 60 кг жинтэй эхэд 2 лааз шар айраг энэ хэмжээнд хүрнэ.
- Хөхүүлж байгаа бол аль болох архи хэрэглэхгүй байх нь зүйтэй. Стресс ихтэй ээжийн хувьд өдөрт нэг хундагаас бага хэмжээтэй архи ууж болно. Хэрэв архи хэрэглэсэн бол дор хаяж 2 цагийн дараа хөхүүлэх шаардлагатай.

### • Орчны бохирдуулагч бодисууд

- Хар тугалга, DDT (дихлор-дифенил-трихлорэтан), хлордан, PBBs (поли-бромжуулсан бифенилүүд), PCBs (полихлоржуулсан бифенилүүд) зэрэг орчны бохирдуулагч бодисууд хөхний сүүгээр дамжин хүүхдэд хүрч болно.
- Ихэнх орчны бохирдуулагч бодисууд өөх болон ясны элдэ хуримтлагдах боломжтой.
- Өөхөн эд нь сүү үйлдвэрлэхэд ашиглагдах эсвэл ясны калци шилжих үед өөх болон ясанд хуримтлагдсан бохирдуулагч бодисууд сүү рүү дамжиж болно. Жишээ нь PCBs-д өртсөн хүүхдүүдэд арьсны тууралт, хоол боловруулах тогтолцооны асуудал, мэдрэлийн тогтолцооны эмгэг илэрч болно.
- Хоолны нэмэлт бодис агуулсан боловруулсан болон бэлэн хоол зэрэг бүтээгдэхүүнийг аль болох хэрэглэхгүй байх нь зүйтэй

### • Хурц үнэртэй болон амглагч ихтэй хоол

- Тодорхой амглагч бүхий хоол идсэний дараа хүүхэд сүүг голох шинж тэмдэг үзүүлбэл тухайн хоолыг 72 цагийн турш идэхгүй байх бөгөөд хүүхдийн харну үйлдлийг харж

III. Эхийн хоол тэжээл ба дагал хөдөлгөөний менежмент

бага багаар дахин хөхөө өгч үзнэ.

- Сармис, сонгино зэрэг хурц үнэртэй хүнс нь хөхний сүүний үнэрийг өөрчилж болзошгүй. Хөхний сүүн дэх сармисны үнэр нь сүүний хэмжээнд нөлөөлөхгүй ч хүүхдийн хөхөх үйлдэлд нөлөөлж болно.

• **Чихрийн ордуулагч**

- Хөхүүл эх болон нярайд илчлэггүй чихрийн ордуулагчийн аюулгүй байдал бүрэн нотлогдоогүй байна.
- Аспартамын хувьд биеийн жингийн 1 кг тутамд 50 мг–аас хэтрүүлэхгүй байх бөгөөд чихрийн ордуулагч хэрэглэхээс аль болох зайлсхийх нь зөв.

• **Цагаан хоолтон ээжүүд**

- Уураг нь олон төрлийн амин хүчлээс бүрдэх тул ургамлын гаралтай уураг нь хүний биед шаардлагатай тодорхой амин хүчлүүдийг хангалтгүй дутагдал үүсгэж болзошгүй.
- Өндөг, сүү, бяслаг зэрэг амьтны гаралтай уураг хэрэглэж байгаа цагаан хоолтон ээжүүд кальци, цайр, В12 витаминг хангалттай хэмжээгээр авах боломжтой.
- Цагаан хоолтон хүмүүс, ялангуяа веган хоолтнууд нь В12 витамин дутагдалд илүү өртөмтгий байдаг. Учир нь В12 нь ургамлын гаралтай уурагт агуулагддаггүй тул шаардлагатай бол нэмэлтээр уух нь зүйтэй.

③ **Хөхүүлж буй эхийн эрүүл хооллолтын зөвлөмж**

- Ихэнх эмэгтэйчүүд хөхүүлэлт хийх үед өдөрт **200–500 ккал** илүү зарцуулдаг тул чухал шим тэжээлээр биеэ хангах нь зүйтэй.
- Жирэмсэн бус эмэгтэйчүүдтэй харьцуулахад илчлэгийн хэрэгцээ **15% орчим** нэмэгддэг. Хүүхэд төрсний дараа биеийн эд эсийг нөхөн сэргээхэд зайлшгүй шаардлагатай уураг ихтэй хоол идэх нь чухал.
- Өдөрт гурван удаагийн үндсэн хоолноос гадна 2-3 удаагийн хөнгөн зуушийг хэрэглэж илчлэг болон шим тэжээлийг нөхөх бөгөөд хэт их идэхээс сэргийлнэ.
- Хялбар бэлтгэж болох бөгөөд шим тэжээл нөхөхөд тустай тараг, жимсний шүүс, сэндвич, чанасан өндөг, жигнэсэн хулуу зэрэг зууш тохиромжтой.
- Солонгост уламжлалт төрсний дараах хоол гэвэл ихэвчлэн далайн байцааны шөл, цагаан будаа байдаг ч зөвхөн энэ хоолонд найдалгүй төрөл бүрийн хүнс хэрэглэхийг зөвлөж байна.
  - Өдөрт гурван удаагийн хоол болон 2–3 удаагийн зуушаар хангалттай илчлэг авна.
  - Өөх багатай мах, загас, дүпү, өндөг зэрэг чанартай уураг хэрэглэнэ. Ялангуяа тослог ихтэй загас нь ДНА, ЕРА зэрэг ханаагүй тосны хүчлээр баялаг тул хэрэглэхийг зөвлөж байна. Сүү, өндөг, шар буурцгийн бүтээгдэхүүн нь сайн уургийн эх үүсвэр боловч хүүхдийн харшлын шалтгаан болох эрсдэлтэй тул хүүхдийн харшлын байдлыг харгалзана.

- Төрсний дараа цусны алдагдлыг нөхөхийн тулд төмөр ихтэй хоол иднэ. Витамин С нь төмрийн шимэгдэлтийг дэмждэг тул хангалттай авах хэрэгтэй.
- Кальци нь Солонгос эмэгтэйчүүдэд дутмаг байдаг тул сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөрт 3 удаа уухыг зөвлөж байна.
- Өдөр бүр шинэхэн ногоо, жимс хэрэглэх хэрэгтэй. Усанд уусдаг витамин нь эхийн хоолноос шалтгаалан сүүний найрлагаар хурдан өөрчлөгддөг бол тосонд уусдаг витамин нь тогтвортой байдаг. Ногоон навчит ногоог өдөр бүр, хоол бүрт 2–3 төрлийн ногоо, өдөрт 2–3 удаа жимс хэрэглэх нь зөв. Ялангуяа төрсний дараа түгээмэл тохиолддог өтгөн хаталтыг бууруулахад их хэмжээний эслэг агуулсан хүнсний ногоо (шар манжин, янгуур) үр дүнтэй.
- Амархан цангах, ядарч сульдах, өтгөн хатах эрдэлтэй тул шингэн хангалттай уух хэрэгтэй. Хоолны үед шөл ууж, өдөр тутамд сүү, цай, ус, арвайтай цай, жимсний шүүс уухыг зөвлөж байна. Харин хийжүүлсэн болон кофеин ихтэй ундаанаас зайлсхийх нь зөв.
- Далайн байцааны шөл болон шөлөн хоолыг давс бага хэрэглэж, хоол хийхдээ давсыг аль болох сүүлд хийх нь зүйтэй. Хөхний сүүн дэх давсны хэмжээ нь эхийн хэрэглээнээс шууд их хамааралгүй ч бөөрний үйл ажиллагаанд ачаалал үүсгэж болзошгүй.
- Гэдэс гүйлгэх болон хоол боловсруулах асуудал үүсгэж болзошгүй хурц амтлагчтай хоолыг зайлсхийх.

<Хүснэгт 23> Хөхүүл эхийн хооллолтын зөвлөмж удирдамж

- Хооллолт нь хөхүүл эхэд шаардлагатай бүх шим тэжээлийг хангах ёстой.
- (Ердийн нөхцөлд витамин болон эрдэсийн нэмэлт хэрэглэхийг санал болгодоггүй.)
- Хангалттай хэмжээний шингэн уух. (Өтгөн хаталтыг багасгахад тустай.)
- Жин бууралт нь төрсний дараах эхний 1 сард 3~4 кг-аас их байх ёсгүй.
- Өдөрт авах илчлэгийн хэмжээ 1500 ккал-аас багагүй байх ёстой.
- Архи хэрэглэхээс зайлсхийх.
- Хурц амттай болон цочроох хоол хүнснээс зайлсхийх.

Эх сурвалж: Nutrition during lactation, Washington, DC: National Academy; 1991

- Жирэмсэн бус, хөхүүлэлтгүй насанд хүрсэн эмэгтэйтэй харьцуулахад хөхүүлж буй эх нь гол шим тэжээлийн бодисуудаас эрчим хүчийг 15%, уураг 56%, шингэн 33%, витамин А 77%, витамин D 100%, витамин Е 30%, кальци 57%, витамин С 35%, тиамин 36%, рибофлавин 42%, фолийн хүчил 38% илүү авахыг зөвлөдөг.
- Хөхүүл эхийн хувьд илчлэгийн илүүдлийг зайлсхийхдээ уураг, витамин, кальци зэрэг эрдэс бодисыг хангалттай авах шаардлагатай. Өдөр тутмын хооллолт нь жирэмсэн бус, хөхүүл биш эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү олон төрлийн хүнсний ногоо болон жимсийг хэрэглэх ёстой бөгөөд дараах байдлаар хэрэглэнэ.

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

- Хоол хүнсний зохицолын хүснэгтийг ашиглан хоолны цэсийг төлөвлөх нь тэнцвэртэй хооллолтыг хялбархан бий болгоход тусалдаг. Энэ хүснэгт нь өдөр тутам хэрэглэдэг хүнснийг шим тэжээлийн найрлагаар нь ойролцоо зүйлсээр нь ангилж, **6 төрлийн хүнсний** бүлэгт багтаасан хүснэгт юм.
- Төрсний дараах биеийн нөхөн сэргэлт болон шим тэжээлийн хувьд сэтгэл хангалуун байхаар эрүүл хооллолтыг хангах хүнсний хэмжээг болон төрлийг сонгох үндсэн бүтэцтэй танилцъя.

④ Хоолны цэсний бүрдүүлэлтийн үе шат

<Хүснэгт 24> 6 төрлийн хүнсний бүлэг (Солонгосчуудын шим тэжээлийн хэрэглээний стандарт, Солонгосын тэжээл судлал, 2010)

Хүнсний бүлэг	Гол шим тэжээлийн үүрэг	Тайлбар	Жишээ хүнс
Үр тариа	Нүүрс ус (биеийн үйл ажиллагаанд шаардлагатай эрч хүчийг өгнө)	Цагаан будаатай харьцуулахад илүү их эслэг, эрдэс бодис агуулсан бүхэл үр (бор будаа гэх мэт) хэрэглэхийг зөвлөж байна.	Будаа, цагаан будаа, гоймон, наран гоймон, цагаан будааны бялуу, талх
Мах, загас, өндөг, буурцагт ургамал	Уураг (будчин, цус үүсгэж, өвчнөөс сэргийлнэ)	Өдөр бүр өөх багатай мах, загас, дүпү, буурцагт ургамлын аль нэгийг хэрэглэхийг зөвлөж байна.	Мах, тахианы мах, загас, буурцаг, дүпү, өндөг
Хүнсний ногоо	Витамин, эрдэс бодис (эслэг ихтэй тул жин бууруулах, өтгөн хаталтыг багасгахад тустай; антиоксидант үйлчилгээтэй тул хөгшрөлтөөс сэргийлнэ, арьсны эрүүл мэндэд тустай)	Өдөр бүр хоёр төрлийн навчит ногоо болон нэг төрлийн далайн ургамал (далайн байцаа, миёк, ким) идэхийг зөвлөж байна.	Үр тарианы нахналсан ногоо, бууцай, кимчи, өргөст хэмхтэй кимчи, мөөг, далайн байцаа
Жимс	Витамин, эрдэс бодис (антиоксидант үйлчилгээтэй тул хөгшрөлтөөс сэргийлнэ, арьсны эрүүл мэндэд тустай; эслэг ихтэй тул өтгөн хаталтыг багасгана)	Жимсэнд элсэн чихэр их тул 1 өдөрт 1–2 удаа бага хэмжээгээр хэрэглэхийг зөвлөж байна.	Алим, мандарин, амтат гуа, усан үзэм, тарваг, жүржийн шүүс
Сүү, сүүн бүтээгдэхүүн	Эрдэс бодис, кальци (яс, шүднийг бэхжүүлднэ)	Өдөр бүр 1–2 удаа тос багатай сүү хэрэглэхийг зөвлөж байна.	Сүү, бяслаг, өтгөн тараг, шингэн тараг, зайрмаг
Өөх тос, чихэр	Эрч хүч өгч, биеийн температурыг тогтвортой байлгахад тусална. Хэтрүүлэн хэрэглэвэл жин нэмэгдүүлднэ.	Хоолонд өөх тос их хэмжээгээр агуулагддаг тул нэмэлтээр хэрэглэх шаардлагагүй. Ялангуяа чихрийн хэрэглээг багасгана. Ханаагүй тосны хүчтээр баялаг самар (самар, бүйлс гэх мэт) хэрэглэхийг зөвлөж байна.	Ургамлын тос, масло, майонез, кофены хольц, элсэн чихэр, зөгийн бал

### 3) Төрсний дараах таргалалтын менежмент

#### ① Төрсний дараах таргалалттай тэмцэх үндсэн зарчим

- Тасралтгүй, зохистой хооллолт болон дасгал хөдөлгөөнийг онцгойлон чухалчилна.
- Эрүүл хооллолтын зуршлыг хэвшүүлснээр зүрхний өвчин, чихрийн шижин, даралт ихсэх, хорт хавдар зэрэг бусад өвчний эрсдлийг бууруулна.
- Жирэмслэхээс өмнө эрүүл, тохиромжтой жинг хадгалж, жирэмсний үед зохистой жин нэмэгдэхийг зорих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл жирэмсний үед илүүдэл өөх тос хуримтлагдахаас сэргийлэх **төрсний өмнөх менежмент** чухал бөгөөд төрсний дараа өөрийн жинг эргүүлэн олох зорилгоор зохистой хооллолт хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Төрсний дараах жингийн менежмент нь зөвхөн таргалалтад бус, харин даралт ихсэх, чихрийн шижин зэрэг төрсний дараах эмэгтэйчүүдийн урт хугацааны эрүүл мэндэд чухал нөлөөтэй тул хооллолт болон амьдралын хэв маягийг анхаарах шаардлагатай.
- Ихэнх эхчүүд жирэмсэн байхдаа 4-5 кг жин хасдаг. Хоолны дэглэм, дасгал хөдөлгөөнөөр долоо хоногт 0.2-0.3 кг жин хасахыг зөвлөж байна. Жирэмсний өмнөх жинд буцаж ирэхэд зургаан сар гаруй хугацаа шаардагдана.
  - Илчлэгийн хэрэглээг хянах
    - Хөхүүлэл эхний 6 сард сард 0.5–1.2 кг жин автоматаар буурна.
    - Жингээ хянахыг хүсвэл илчлэгийн хэрэглээг зохистой хэмжээнд багасган сар бүр 2 кг орчин турахыг зорих хэрэгтэй. Өдөрт 1500 ккал-аас бага илчлэг хэрэглэх нь сүүний үйлдвэрлэлийг бууруулах эрсдэлтэй тул зөвлөдөггүй.
    - Жингээ бууруулахдаа илчлэгийн хэмжээг багасгах боловч уураг, витамин, эрдэс бодисыг хангалттай авах ёстой.
    - Жирэмсний үеэр нэмэгдсэн жингээ бууруулах төлөвлөгөөг хэдэн сарын туршид хэрэгжүүлж, тогтмол хянах хэрэгтэй.
  - Хөхүүлэлтийг дэмжих
    - Өдөр бүр 500–650 ккал илчлэг сүү үйлдвэрлэхэд хэрэглэгддэг тул хуримтлагдсан өөх тосыг шатаахад тустай.
  - Амьдралын хэв маягийг өөрчлөх
    - Төрсний дараах хөдөлгөөний дутагдал нь эрсдэлт хүчин зүйл болдог.
    - Уламжлалт төрсний дараах дэглэмээс ялгаатай нь орчин үед шаардлагатай тэжээллэг хоолыг зөвхөн хэрэгцээний хэмжээгээр хэрэглэж, тохиромжтой хөдөлгөөнийг зөвлөж байна.
    - Төрсний дараах хүндрэлгүй тохиолдолд төрөлт болон кесар хагалгаанаас 1 долоо хоногийн дараагаас хөнгөн дасгал хөдөлгөөн эхлэхийг зөвлөдөг.
  - Жимс, хүнсний ногоо, бүхэл үртэй бүтээгдэхүүн хэрэглэхэд анхаарах
    - Эслэгээр баялаг жимс, хүнсний ногоо, бүхэл үртэй хоол хүнс нь илүү удаан цагталан байлгаж, чухал тэжээлийг өгнө.
    - Тослог багатай сүү, тараг, бяслаг зэрэг сүүн бүтээгдэхүүнийг багтаана.
    - Тахианы цээж мах, загас, буурцагт ургамал, өөх багатай мах нь цайр, төмөр, B2 витамин, уургийн сайн эх үүсвэр юм.

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

<Хүснэгт 25> Жинг бууруулах зориулалттай 1500 ккал-ын хоолны төлөвлөгөө танилцуулга

Хүнсний бүлэг	Өглөөний хоол	Зууш	Өдрийн хоол	Зууш	Оройн хоол
Үр тариа бүлэг (600 ккал)	Соргоны будаа 140 г (2/3 аяга)		Бүхэл үрийн будаа 140 г (2/3 аяга)		Цагаан будаа 140 г (2/3 аяга)
Мах, загас, өндөг, буурцаг (300 ккал)	Жижиг хатаасан загас жигнэсэн – 1 ширхэг		Дүпү жигнэсэн (120 г, 3 зүсэм)		Өндөг, луувантай жигнэмэг (өндөг 1 ширхэг)
Хүнсний ногоо бүлэг (140 ккал)	Байцааны навчтай шөл, бууцайны салат, далайн байцааны салат, кимчи		Луувантай шөл, салат (ногоон навчит), мөөг хуурсан, усанд дарсан кимчи		Далайн байцааны шөл, бибимбап орц (буурцаг нахиалсан, бууцай, навчит салат гэх мэт), багахан чинжүүтэй соус
Өөх тосны бүлэг (180 ккал)	Бага зэрэг кунжутын тос		Чидун жимс, бага зэрэг кунжутын тос		Чидун жимс, бага зэрэг кунжутын тос
Сүү, сүүн бүтээгдэхүүн бүлэг (160 ккал)		Тосгүй сүү 1 аяга, улаан лооль 1 ширхэг		Тосгүй сүү 1 аяга	
Жимсний бүлэг (100 ккал)		Алим 1/2 ширхэг		Тоор (дунд хэмжээтэй) 1 ширхэг	
Нийт илчлэг (ккал)	Ойролцоогоор 410	Ойролцоогоор 130	Ойролцоогоор 390	Ойролцоогоор 130	Ойролцоогоор 410

Эх сурвалж: Сүүл Их Сургуулийн Эмнэлэг, Гэр бүлийн анагаах ухааны тасаг

4) Төрсний дараах эрүүл мэндийг дэмжихийн тулд хоолны дэглэм баримтал

① Хулуу, хулууны шүүс

- Хаван бууруулахад хамгийн ихээр хэрэглэгддэг хүнс бол хулуу бөгөөд шээс хөөх болон бодисын солилцоог идэвхжүүлэх үйлчилгээтэй.
- Төрсний дараах хаван нь арьсанд хуримтлагдсан шингэнээс үүдэлтэй тул энэ шингэнийг гадагшлуулах зорилготой.

- Хулууны шүүсийг төрсний дараа дор хаяж нэг сар өнгөрсөн ч хаван хэвээр байвал хэрэглэж болно.
- Харин төрсний даруйд хулууны шүүс уввал төрсний дараах хэвлийн даралт буурч, бөөрний үйл ажиллагаа эрчимжсэн үед хэт их шээс хөөх нөлөө нь бөөрөнд ачаалал өгч, их хэмжээгээр хөлөрснөөр ядаргаа үүсгэж болзошгүй.

② Загас (Цурхай, Сарлаг толгойт)

- Хоол боловсруулах эрхтнийг бэхжүүлж, хоолны дуршил болон төрсний дараах хаванг бууруулахад тустай гэж үздэг ч хулуунаас илүү хүчтэй шээс хөөх нөлөөтэй тул төрсний дараах эхний үед болгоомжтой хэрэглэх ёстой.
- Өөр хоол хүнстэй харьцуулахад өөх тос болон илчлэг өндөр тул жингийн асуудалд нөлөөлж болзошгүй.
- Харин төрсний дараах тэжээлийн дутагдалтай эмэгтэйчүүдэд уураг болон кальциар баялаг цурхай, сарлаг толгойт загас нь махнаас илүү амархан шингэдэг тул нэмэлт тэжээл болгон хэрэглэхийг зөвлөдөг.

③ Үхрийн сүүлтэй шөл, үхрийн туурайтай шөл, гахайн туурай

- Хөхний сүүг сайн гарахад тусална гэж уламжлалт тэжээллэг хоолонд тооцогддог. Өндөр уурагтай бөгөөд витамин B1, B2, коллаген, эслэг, шингэн, кальци зэрэг ихээр агуулагддаг тул сүү ялгаруулалтад тустай гэж үздэг.
- Сүү нь сайн гарч буй эхчүүдийн хувьд өндөр илчлэгтэй тул төрсний дараах таргалалтыг үүсгэж болзошгүй.

④ Хар ямаа, ямааны шөл

- Ямааны махыг эмэгтэйчүүд төрсний дараа биеийн хүчийг нөхөх зорилгоор иддэг байсан.
- “Чадалгүй байна”, “Ядарч байна” гэж хэлдэг эхчүүдэд өгдөг тэжээллэг хоол боловч илчлэг өндөртэй тул жингээ анхаарч буй эхчүүд болгоомжлох хэрэгтэй.

⑤ Ёнбунтан (Загас, тахианы шөл)

- Цурхай болон хар тахиа -г үндсэн орц болгон ашиглаж, (жиншэн), самар, цагаан гаа, жужуб, цагаан будаа, мөөг, сармис, перец зэргийг нэмэлтээр хийж жирэмсэн болон нөхөн сэргээх үеийн өвчтөн, сул биетэй хүүхдэд сайн гэж үздэг.
- Уураг ихтэй хоол боловч илчлэгийг зөв түвшинд барьж тохиромжтой хэмжээгээр хэрэглэх нь зүйтэй.

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

⑥ Загасны хоол (Яст загас)

- Загас нь амин чухал амин хүчлээр баялаг, чанартай уураг, витамин В, А, төмөр, кальцы ихээр агуулдаг.
- Сармис, цагаан гаа, сонгино, перец зэргийг нэмж шөл болгож чанах эсвэл шарж иддэг.

5) Эрүүл төрсний дараах хоол хүнс бэлтгэх

Төрсний дараа зөвлөдөг хоол хүнс нь онцгой хоол биш, харин зохистой илчлэгтэй, тэнцвэртэй, эрүүл хооллолт бөгөөд олон төрлийн хүнсийг хэрэглэх нь үндсэн зарчим юм. Хөхүүлж буй эхчүүдийн дунд уламжлалт байдлаар далайн байцааны шөл, цагаан будаа зэргийг өдөрт 4-5 удаа идэх тохиолдол их байдаг нь нүүрс усны илүүдэл хэрэглээ болон уураг, витамин, эрдэс бодисын дутагдалд хүргэдэг. Боловруулсан болон түргэн хоолноос илүүтэй шинэхэн, улирлын хүнс хэрэглэхийг зөвлөж, витамин А, фолийн хүчил, төмрөөр баялаг ногоон навчит хүнсийг өдөр бүр хэрэглэх ёстой.

<Хүснэгт 26> Улирлын шинэхэн хүнс

Анги лал	Улирлын хүнсний ногоо	Улирлын жимс	Улирлын загас, далайн бүтээгдэхүүн
1-р сар	Лууван, далив, лягнуун үндэс	Мандарин, нимбэг	Далайн хясаа , хавч, далайн лут, самчи загас, треска загас, сардин, далайн өргөст хэмх, минтай, камбала
2-р сар	Бууцай, далив, гобэ , даллэ , чамчви	Алим, мандарин, нимбэг	Хоног загас , самчи, треска, (ккокмак хясаа), (хонхит хясаа), (далайн хясаа), (далайн байцаа), (ногоон замаг), (цэнхэр замаг)
3-р сар	(далра), усны яншуй, (нэнъи), шарилж, 씀바귀 고들빼기 (봄동), 원추리	Алим	Самчи, (важирак), 대합, 꼬막 (ккокмак), 파래 (ногоон замаг), 물미역 (далайн байцаа), 붓
4-р сар	Гобэ (고사리), 더덕 (더덕), 두릅 (두릅), 쪽갓 (쪽갓), 취 (취), шарилж, хулсны нахиас, 쪽파 머위 껌질콩	Алим, гүзээлзгэнэ	고등어 (скумбрия), 바지락, 대합, 꽃게 (цэцгэн хавч), 파래, 키조개 주꾸미 (наймаалж)
5-р сар	Гобэ, 도라지 , бууцайны сонгино, байцаа, далив, байцаа, саримс, төмсний нахиас, 마늘쫑 вандуй, усны яншуй, 더덕	Гүзээлзгэнэ, интоор	양미리 , наймаалж, 참치 (туна), 멸치 (анчоус), скумбрия, цэцгэн хавч, 민어


Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Ангилал	Улирлын хүнсний ногоо	Улирлын жимс	Улирлын загас, далайн бүтээгдэхүүн
6-р сар	(근대), 도라지, аягын ногоо, далив, өргөст хэмх, вандуй, ногоон чинжүү, хулуу, байцаа, сонгино, улаан лооль, бүхэл саримс, 열무	Чавга	Анчоус, сам хорхой, 민어, хоног загас, наймаалж, 병어, 춘치, 전갱이
7-р сар	Гэжилж (갯잎), 근대, мөөг, байцаа, бууцай, 열무, өргөст хэмх, ногоон чинжүү, хаш, хулуу, төмс, бууцайны сонгино	Чавга, тоор, тарвас, амтаг гуа	민어, хоног загас, 농어 (농어), далайн хэрэм (성게)
8-р сар	Гэжилж, улаан вандуй, 근대, мөөг, улаан чинжүү, бууцай, өргөст хэмх, ногоон чинжүү, хулуу, төмс, хаш, эрдэнэ шиш, 열무	Тоор, тарвас, амтаг гуа, усан үзэм, улаан лооль, мелон	Сам хорхой, наймаалж, далайн медуз, 꼬막, далайн хэрэм, карп
9-р сар	Хаш, чихэрт төмс, таро үндэс, лууван, шитаки мөөг, улаан чинжүү, мөөг	Усан үзэм, анар, лийр, алим, самар	Скумбрия, яргай загас, цэцгэн хавч, 대합, далайн медуз
10-р сар	Таро үндэс, нарсны мөөг, лууван, мөөг, саримс, 고들빼기	Алим, лийр, хөх інтоор, самар, жужуб	Загас (미꾸라지), туна, скумбрия, 콩치, яргай, самчи, сардина, цэцгэн хавч, том сам хорхой, 홍합
11-р сар	Лууван, байцаа, лянгуун үндэс, далив, сонгино, хөгшин хулуу, брокколи	Алим, хөх інтоор, южа, омиджа, моһа, мандарин, киви	Сардина, самчи, треска, яргай, туна, наймаалж, 다량어, далайн хясаа, том сам хорхой, 대합
12-р сар	Лууван, байцаа, ям, лууван, цагаан гаа, лянгуун үндэс	Хөх інтоор, мандарин	Хоног загас, наймаалж, 주꾸미, далайн хясаа, хавч, 꼬막, 파래, 미역 (далайн байцаа), 김 (хуурай далайн байцаа)

<Хүснэгт 27> Барэг боловсруулалт шаарддаггүй эрүүл зууш

Ангилал	Төрөл
50 ккал эрүүл зууш	Банана (дунд) 1/2 ш, мандарин 1 ш, лийр 1/4 ш, алим 1/3 ш, жүрж 1/2 ш, чавга 1 ш, киви 1 ш, гүзээлзгэнэ 10 ш, амтаг гуа 1/2 ш, интоор улаан лооль 20 ш, том улаан лооль 1 ш, усан үзэм 19 ширхэг, амтаг хөх інтоор 1 ш, лууван (дунд) 1 ш, жимсний шүүс 1/2 аяга, шар буурцгийн сүү 1/2 аяга, хушга 4 хагас, газрын самар 10 ш, бүйлс 7-8 ш
100 ккал эрүүл зууш	Жигнэсэн төмс (дунд) 1 ш, амтаг төмс (дунд) 1/2 ш, самар 5-6 ш, банана (дунд) 1 ш, усан үзэм (дунд) 1 багц, бэрсүүт жүрж 1 ш, жижиг амтаг гуа 1 ш, жимсний шүүс 1 аяга, сүү 1 аяга, тараг 1 ш, бяслаг (нимгэн зүсмэл) 1 зүсэм, үзэм 3 цайны халбага

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент



[Зураг 37] Төрсний дараах эхийн нэг өдөрт амархан бэлдэх эрүүл зуушны жишээ

Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн хооллолтын дадал хэвшлийн зөвлөмж (Эрүүл мэнд, Нийгмийн халамжийн яамнаас, 2003 он)

Ангилал	Дэлгэрэнгүй тайлбар
Сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөрт 3 удаа ба түүнээс дээш хэрэглэе	<ul style="list-style-type: none"> <li>• Кальциар баялаг хүнс нь сүү, сүүн бүтээгдэхүүн, ясатай илдэг загас болон ногоон навчит хүнс юм.</li> <li>• Сүү, сүүн бүтээгдэхүүнд агуулагдах кальци нь: <ul style="list-style-type: none"> <li>- Ихэс, умай болон ургийн хэвийн өсөлт хөгжилд</li> <li>- Хөхний сүү үйлдвэрлэхэд</li> <li>- Ээж болон хүүхдийн эрүүл яс, шүдэнд</li> <li>- Булчин болон мэдрэлийн эдийн хөгжилд хэрэгтэй.</li> </ul> </li> <li>• Нэг аяга сүүнд ойролцоогоор 2001,100 мг орчим бөгөөд, Солонгос эмэгтэйчүүдийн өдөр тутмын хоолноос авах кальцийн хэмжээ ойролцоогоор 500 мг байдаг тул өдөрт 3 аяга сүү ууснаар зөвлөмж хэмжээг хангаж чадна.</li> </ul>
Мах, загас, хүнсний ногоо, жимсийг өдөр бүр хэрэглэе	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсэн болон хөхүүл үед шим тэжээлийн хэрэгцээ нэмэгддэг тул төрөл бүрийн хүнс хэрэглэх шаардлагатай.</li> <li>• Хүнсний ногоо, жимсэнд витамин, эрдэс бодис болон бие махбодид хэрэгтэй олон бодисууд агуулагдана. Өөр өөр төрлийн хүнсний ногоо, жимс нь эхийн эрүүл мэндийг хадгалж, ургийн эрүүл өсөлт хөгжилд туслах олон төрлийн шим тэжээл агуулдаг тул төрөл бүрээр нь тэнцвэртэй хэрэглэх ёстой.</li> <li>• Ногоо, жимснээс гадна мах, загас, өндөг, бууриг зэрэг уураг ихтэй хүнсийг өдөр бүр хэрэглэж, эрчим хүч болон биеийн үндсэн бүтцийн уураг хангалттай авч эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаална.</li> <li>• Жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд төмрийн дутагдлын цус багадаг амархан үүсдэг тул цус багадагтаас сэргийлэхийн тулд өөхгүй мах, өндөг гэх мэт төмөр ихтэй хүнс хэрэглэхийг зөвлөе.</li> </ul>

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

Ангилал	Дэлгэрэнгүй тайлбар
Давтай хоолноос зайлсхийж, давсыг багасгая	<ul style="list-style-type: none"> <li>• Солонгос насанд хүрэгчид өдөрт дунджаар 13~18 гр давс хэрэглэдэг боловч одоогийн хооллолтын зорилтот хэмжээ нь давсыг өдөрт 10 гр (натри 4,000 мг)–аас бага хэрэглэх явдал юм. Иймээс давс, шар буурцгийн сүмс, бусад даршилсан бүтээгдэхүүний хэрэглээг багасгах хэрэгтэй.</li> <li>• Даршилсан ногоо, давсалсан загасны бүтээгдэхүүн, бэлэн хүнсийг аль болох бага хэрэглэ.</li> <li>• Хоол бэлтгэхдээ болон идэхдээ давс, шар буурцгийн сүмсийг бага хэрэглэ.</li> </ul>
Архи огтхон ч бүү хэрэглэ	<ul style="list-style-type: none"> <li>• Архинд бусад шим тэжээл бараг агуулагддаггүй бөгөөд их хэмжээний калориор хангадаг тул хоолыг архиар орлуулбал зайлшгүй хэрэгтэй шим тэжээлийн дутагдалд орж, хоол тэжээлийн тэнцвэр алдагдана.</li> </ul>
Аюулгүй хүнс сонгож, ариун цэврийг чанд сахи	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсэн болон хөхүүл үед ариун цэврийн шаардлага хангасан хүнс хэрэглэх нь ээж, хүүхдийн аль алинд нь маш чухал. Ялангуяа хөгжиж буй ураг болон нярайн эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулж болзошгүй тул онцгой анхаарах шаардлагатай.</li> <li>• Ариун цэврийн шаардлага хангасан хүнс хэрэглэх нь бактери, вирус, шимэгч хорхой, химийн бодис зэрэг өвчин үүсгэгчээс сэргийлнэ. Хадгалах хугацааг шалгаж, аюулгүйгээр боловсруулсан хүнсийг сонгож, хоол хийх болон хадгалах явцад ариун цэврийг чанд баримтлах хэрэгтэй.</li> <li>• Химийн нэмэлттэй боловсруулсан болон бэлэн хоолыг аль болох бага хэрэглэ.</li> <li>• Хөдөө аж ахуйн химийн бодис, хүнд металл, бусад байгаль орчны бохирдуулагчийн эрсдэлээс сэргийлж, эрсдэл багатай дотоодын хүнсний бүтээгдэхүүнийг идэвхтэй хэрэглэхийг зөвлөж байна.</li> </ul>
Жирэмсэн эмэгтэйчүүд жингээ тохиромжтой нэмэхийн тулд зөв хоолло	<ul style="list-style-type: none"> <li>• Хангалттай шим тэжээлтэй хоол хүнсээр жингээ зохистой нэмэх нь жирэмсэн үеийн эх болон ургийн эрүүл мэндэд маш чухал. Эрүүл жирэмсэн эмэгтэй жирэмсэн үедээ ойролцоогоор 10–14 кг жин нэмдэг бөгөөд жирэмсэн болохын өмнөх жин бага байх тусам жирэмсэн үед илүү их жин нэмэгдэх хандлагатай.</li> <li>• Өдөрт гурван удаа хооллож, завсар хоол идэхдээ хоолоо таатай ид.</li> <li>• Өдөр тутмын үйл ажиллагаа болон хөнгөн дасгал хөдөлгөөнийг тогтмол хий.</li> </ul>
Хөхүүл эмэгтэйчүүд сүүг нэмэгдүүлэхийн тулд зөв хоолло	<ul style="list-style-type: none"> <li>• Хөхөөр хооллох нь хүүхдэд сайн төдийгүй эхийн бие галбирыг сэргээж, жирэмсний үеэр нэмэгдсэн жингээ буцаахад тусалдаг.</li> <li>• Хөхүүл үед ээжийн хэрэглэж буй олон төрлийн шим тэжээл нь ээжийн эрүүл мэндийг дэмжиж, хөхний сүүний найрлагыг хүүхдийн зөв өсөлт хөгжилд илүү тохиромжтой болгоход хэрэглэгддэг.</li> <li>• Хөхүүл эмэгтэй зөв зохистой хүнс хэрэглэхээс гадна хангалттай ус уух нь чухал. Учир нь сүү үүсгэхэд ус хэрэгтэй бөгөөд ус бага уувал шингэн дутагдал үүсэх эрсдэлтэй тул хангалттай хэмжээний ус ууж байх хэрэгтэй.</li> </ul>

2 Төрсний дараах дасгал хөдөлгөөний менежмент

1) Төрсний дараах дасгал хөдөлгөөн ба биений идэвхтэй байдал

- Төрсний дараа тохиромжтой дасгал хийх нь эхийн сэтгэл санааг сайжруулж, төрсний дараах сэтгэл гутралаас урьдчилан сэргийлэхээс гадна төрсний улмаас ядран сульдсан биений эрч хүчтэй болгож, жингээ тохируулах болон биений нөхөн сэргээлтэд тусалдаг. Дасгал хөдөлгөөнийг амьсгаа бага зэрэг давхцаж, хөнгөн хөлс гарах хэмжээнд хийх бөгөөд биений идэвхтэй үйл ажиллагаа гэдэг нь дасгал шиг амьсгаа давхцах эсвэл хөлс гарах шаардлагагүй хөдөлгөөнүүдийг хэлнэ.
- Хөлс болон шээсээр илүүдэл шингэнийг гадагшуулснаар шингэний хуримтлал үүсэхээс сэргийлж, хаван багасгахад тусална. Мөн цусны бүлэн үүсэхээс урьдчилан сэргийлэхэд тустай.

Төрсний дараах дасгалын үр нөлөө

- ① Төрөх үед сунасан хэвлийн ханын болон аарцагны булчинг агшиж нөхөн сэргээж, биений тэсвэр тэвчээрийг нэмэгдүүлнэ.
- ② Цусны эргэлтийг сайжруулна.
- ③ Шээс гадагшуулах болон умайн агшилтыг дэмжинэ.
- ④ Төрсний дараах хурцадмал байдлыг тайлж, ядаргаа тайлахад үр дүнтэй.
- ⑤ Хөхний сүү ялгаралтыг нэмэгдүүлж, өтгөн хаталтаас сэргийлэхэд тусална.

Эх сурвалж: Төрсний дараах сувиллын үйлчилгээний гарын авлага, Эрүүл мэнд, Нийгмийн халамжийн яам & Хүүхэд асрах бодлогын судалгааны хүрээлэн (2024)

- Жирэмслэлтийн улмаас бие махбодь болон сэтгэл зүйн өөрчлөлтүүд төрсний дараа 4-6 долоо хоног орчим үргэлжилдэг тул энэ хугацаанд дасгалаас илүүтэйгээр биений хөдөлгөөнийг аажмаар, хийх нь зүйтэй.
- 4-6 долоо хоногийн дараа эхлүүлэх хүч шаардсан дасгал эхлэх нь зөв.
- Анагаахын хувьд хүндрэлгүй эхчүүд өдөр бүр эртнээс биений идэвхтэй хөдөлгөөн хийх нь биений эрүүл мэндэд ашиг тустай. Харин төрсний дараа үе мөчид ачаалал өгнө гэсэн шалтгаанаар хэт хөдөлгөөнөө хязгаарлаж, бараг хөдөлгөөнгүй байх нь төрсний дараах таргалалтын шалтгаан болдог.
- Жирэмсний үед ч тогтмол биений хөдөлгөөн хийж байсан эхчүүд төрсний дараа ойролцоогоор 4-6 долоо хоногийн дараагаас дасгал хөдөлгөөн эхлүүлэх нь тохиромжтой. Зохистой дасгал хөдөлгөөнийг тогтмол хийснээр илчлэгийн зарцуулалт нэмэгдэж, жингээ барихад тустай.
- Дасгалын дарааллыг бэлтгэл дасгал, сунгалтын дасгал, аэробикийн дасгал, хөнгөн булчингийн хүчний дасгал, төгсгөлийн дасгал гэсэн дарааллаар хийх нь зөв бөгөөд тогтмол дасгал хийх нь эхийн биенийг хурдан нөхөн сэргээхэд тусална.

- Дасгал нь сонирхолтой, таатай байх ёстой. Удаан хугацаанд тогтвортой өөрийн сонирхол болон биед таарсан дасгал хөдөлгөөн хийх л үр дүнтэй.

## 2) Дасгалын удирдамж ба зөвлөмжүүд

### ① Төрсний дараах дасгалын удирдамж

- Долоо хоногт 3–4 удаа дасгал хийнэ.
- Дасгал хийхдээ таатай мэдрэмж төрүүлж, таатай байдлыг мэдрүүлэх нь чухал.
- Төрөлттэй холбоотой өвдөлт, цус алдалт хэт их биш байх ёстой.
- Ус сайн ууна.
- Дасгалын дараа амрах.
- Төрсний дараах жингийн өөрчлөлт хэвийн байх ёстой.
- Дасгал хийх явцад шээс гоожих эсвэл аарцагны даралт мэдрэгдвэл эмчид хандана.
- Дасгал хийхдээ тухтай спорт хөхний даруулга өмсөнө.

Эх сурвалж: Fit to deliver, Hartley & Marks, Karea Nordahl, 2005.

### ② Төрсний дараах дасгалын зөвлөмжүүд

- Хөхүүл эхчүүд дасгал хийхийн өмнө хүүхдээ хөхүүлж эсвэл урьдчилан хөхний сүүгээ сааж бэлтгэнэ. Хүчтэй ачаалалтай дасгал хийсний дараа бол дасгал дууссанаас хойш ойролцоогоор 1 цагийн дараа хүүхдээ хөхүүлнэ. Мөн хөхний сүү ялгаралтыг дэмжихийн тулд өдөр бүр ойролцоогоор 500 ккал нэмэлт илчлэгтэй хоол иднэ.
- Дасгал хийх үед өөрт тохиромжтой дотуур биед эвтэйхэн дотуур хувцас өмснө.
- Дасгалын үеэр шингэн хангалттай ууна.
- Төрсний дараа аарцгийн болон хэвлийн булчин чангалах дасгалыг эхлүүлж болно. Гэхдээ төрсний улмаас өвдөлт, зовиургүй байвал дасгал аажим хийнэ. Ядарч хэт ачаалал авахгүйн тулд богино зайд удаан алхах нь тохиромжтой.
- Хэрэв кесар хагалгаагаар төрсөн бол хэвлийн дасгалыг мэс заслын шарх бүрэн эдгэрсний дараа эхлүүлнэ.
- Төрсний дараа 2–6 долоо хоногийн үед эмчийн зөвшөөрлөөр идэвхтэй аэробикийн болон хүчний дасгал хийж болно. Кесар хагалгаагаар төрсөн бол ойролцоогоор 8 -12 долоо хоногийн дараа дасгал хөдөлгөөн хийж эхэлнэ
- Төрөх замаар төрсний дараа 1–3 сарын дараа идэвхтэй дасгал хийж болно. Гэхдээ төрсний дараах эхний 6 долоо хоногт хэт хүчтэй дасгал хийхээс зайлсхийх хэрэгтэй.
- Хэрэв Кегелийн дасгалыг тогтмол хийсэн ч шээс задгайрах шинж тэмдэг үргэлжилсээр байвал эмчийн нарийн оношлогоо, үнэлгээ хийлгэх шаардлагатай.

Эх сурвалж: Hammer and Hintermann. 1998

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

3) Төрсний дараа дасгал хөдөлгөөн эхлэх хугацаа

Ангилал	Үйл ажиллагаа	Байгалийн төрөлтийн дараа	Кесар хагалгааны дараа
Бэлтгэл дасгал	Хөнгөн зугаалга, алхалт	Алхах боломжтой үед	Алхах боломжтой үед
Сунгалтын дасгал	Йога	Төрсний дараа 2 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)	Төрсний дараа 6 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)
Булчин чангалах дасгал	Кегелийн дасгал	Төрсний дараах эхний өдрөөс	Төрсний дараах эхний өдрөөс
	Хэвлийн булчин чангалах дасгал	Төрсний дараа 2 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)	Төрсний дараа 6 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)
	Хөнгөн хүчний дасгал	Төрсний дараа 2 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)	Төрсний дараа 6 долоо хоногт (эмчтэй зөвлөлдсөний дараа)
Үндсэн дасгал (Аэробик)	Хөнгөн гүйх	Төрсний дараа 3-4 долоо хоногт	Төрсний дараа 10-12 долоо хоногт
	Дугуй унах	Эмчтэй зөвлөлдсөний дараа	Эмчтэй зөвлөлдсөний дараа
	Бага ачаалалтай аэробикийн дасгал	Төрсний дараа 6 долоо хоногт	Төрсний дараа 8-12 долоо хоногт
	Шатаар алхах	Төрсний дараа 6 долоо хоногт	Төрсний дараа 8-12 долоо хоногт
	5 км гүйлт	Төрсний дараа 6-8 долоо хоногт	Төрсний дараа 12-16 долоо хоногт
	10 км гүйлт	Төрсний дараа 12-16 долоо хоногт	Төрсний дараа 12-16 долоо хоногт
Дуусгах дасгал	Хөнгөн зугаалга, алхалт	Алхах боломжтой үед	Алхах боломжтой үед

4) Дасгал хийхэд хориглох заалт

Эмчийн заавраар дасгал хийх хориотой үед туйлын эсрэг заалттай.

Харьцангуй хориглох заалт : дасгал хийхээс авах ашиг тус нь эрдэлээс бага байж болох тул мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөөний дагуу дасгал хийх эсэхийг шийдвэрлэх ёстой.

<Хүснэгт 29> Жирэмсний үед болон төрсний дараа дасгал хийхэд туйлын /харьцангуй эсрэг заалт

Туйлын хориглох заалт	Харьцангуй хориглох заалт
Ургийн ус урьдаж гарах (Эрт умайн хальсны урагдал)	Урьд нь зулбалт эсвэл дутуу төрөлтийн асуумжтай
Жирэмсний хордлого (Презклампси, Эклампси)	Хөнгөн-дунд зэргийн зүрх, уушгины эмгэг
Ихэр жирэмслэлт дутуу төрөлт	Хяналт хийхэд бэрх цусны эргэлтийн өвчин (өндөр даралт гэх мэт)
Ихэс захаар байрлах (Placenta previa)	ихэр жирэмслэлт
Жирэмсний 2, 3-р триместрт доош цус гарах	Хэт таргалалт
Хүнд хэлбэрийн зүрх, уушгины өвчин	Архаг тамхи таталт
–	Жирэмсний эхэн үед дасгал хөдөлгөөний туршлагагүй байх

Эх сурвалж: Солонгосын Эх барих, Эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэг. "Акушер судлал" VI хэвлэл.

## 5) Дасгал хийхдээ анхаарах зүйлс

### ① Дасгал хийхээс өмнө анхаарах зүйлс

- Өдрийн биеийн байдлаа шалгах.  
Халуурах, ханиад, суулгалт, ядаргаа, үе мөчний өвдөлт, гэмтэлтэй үед дасгал хийхээс аль болох зайлсхийх, хийх тохиолдолд хөнгөн дасгал хийж, сунгалтын дасгал хийхгүй байх.
- Хоол идсэний дараа 1–2 цагийн турш дасгал хийхээс зайлсхийх.  
Хоолны дараа ходоод, гэдэсний шингээлтийн үйл ажиллагаа идэвхждэг тул хөнгөн дасгалыг хоолны дараа 1 цагийн дараа, хүчтэй дасгалыг 2 цагийн дараа эхлэх нь зүйтэй.
- Өөр эвтэйхэн таарамжтай хувцас өмсөх.  
Дасгалын хувцас нь хөнгөн даавуун материалтай байх бөгөөд гэмтлээс сэргийлэхийн тулд намхан өсгийтэй хөнгөн спорт гутал өмсөх хэрэгтэй.

### ② Дасгал хийх үеийн анхаарах зүйлс

- Богино хугацааны, хөнгөн дасгалаар эхлэх.  
Дасгалын анхлан суралцагчид хэтрүүлэн ачаалалтай дасгал хийх нь буруу бөгөөд богино хугацааны, хөнгөн дасгалаас эхлэх нь зөв.
- Эрүүл мэндийн байдал, биеийн тамирын түвшиндээ тохирсон дасгал хийх.  
Өөрийн эрүүл мэндийн байдалд тохируулан зохистой хэмжээ, түвшний дасгал сонгох хэрэгтэй.
- 7 хоногт 3 удаа тогтмол дасгал хийх нь илүү үр дүнтэй.

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

③ Тааламжтай дасгал хийх

Өөрт таалагддаг дасгалыг сонгох нь тогтмол дасгал хийх хамгийн сайн арга юм.

• Хангалттай ус уух

Дасгалын үеэр цангахгүй байхаар ус уух нь дасгалыг тогтвортой хийхэд тустай бөгөөд дасгалын дараах ядаргааг хурдан арилгана.

• Сэргээх дасгал

5-10 минутын хөнгөн алхалт, сунгалтын дасгал нь дасгалын дараах булчин өвдөлт болон ядаргааг багасгана.

• Хангалттай нойр

Дасгалын дараа хангалттай унтахгүй бол булчингийн сэргэлт удааширч болзошгүй тул дасгалын ачаалал өндөр өдрүүдэд хангалттай нойр авах хэрэгтэй.

6) Хөхүүл эхийн дасгал

• Хэрэв дасгал хийж буй эх хангалттай хоол хүнс хэрэглэж чадахгүй бол биеийн жин буурч, улмаар хөхний сүүний ялгарал багасч болзошгүй.

• ГТөрсний дараах таргалалтын шалтгаанууд, Солонгосын Таргалалт Судлалын Нийгэмлэг, 2004-ийн судалгаагаар дасгал хийдэг хөхүүд эхчүүд нь дасгал хийдэггүй эхчүүдээс өдөрт 400–800ккал илүү зарцуулж, 300–700ккал илүү хоол хүнс хэрэглэдэг байна.

• Хөнгөн болон дунд зэргийн дасгал нь хөхний сүүний найрлагад өөрчлөлт оруулахгүй ч, харин хүчтэй дасгал хөдөлгөөн нь сүүний сүүн хүчлийн агууламжийг нэмэгдүүлнэ. Гэвч хөхүүл эхэд зөвлөдөг дасгалын түвшин (хамгийн их хүчилтөрөгчийн хэрэглээний 50-70%) нь хөнгөн хүчний дасгал тул сүүн хүчлийн агууламж нэмэгдэхгүй.

• Дасгал хийдэг болон хийдэггүй эхчүүдийн хооронд сүүний ялгаралд ялгаа байхгүй гэсэн ч судалгаа бас байдаг.

• Нялх хүүхдийн өсөлтийн хувьд, дасгал хийдэг эхийн болон дасгал хийдэггүй эхийн сүүг уусан хүүхдүүдийн өсөлтөд ялгаа ажиглагдаагүй байна.


• Дасгал нь эхийн биеийн жинг зохистой түвшинд хадгалах, зүрх судас болон сэтгэл зүйн эрүүл мэндийг сайжруулахад тустай бөгөөд зөв хооллолттой хослуулбал хүүхдийн өсөлт, хөхний булчирхайн хөгжил, сүүний ялгарал, найрлага, хүүхдийн сүүний хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

7) Жирэмсэлтээс үүдэлтэй өөрчлөл ба дасгал

① Хэвлийн шулуун булчингийн зайтай болох (Diastasis Recti)

• **Хэвлийн шулуун булчингийн зайтай болох нь** хүйсний дээд, доод хэсэгт байрлах урт булчин хоёр тал руугаа холдож, хэвлийн ханын холбоос сулрахыг хэлнэ. Хэвлийн шулуун булчингийн зөрүү 2см-ээс их бол эмчийн үзлэг шаардлагатай.

- Ихэвчлэн төрсний дараа тохиолддог бөгөөд ихэнх эмэгтэйд төрсний дараа ажиглагддаг бөгөөд цаг хугацааны явцад аяндаа аажмаар хэвийн болно. Гэсэн хэдий ч ахимаг настай эхчүүд, ихэр жирэмслэлт, том ураг төрүүлсэн мөн жирэмсэн үед жин огцом нэмэгдсэн тохиолдолд хэвлийн булчингийн зайтай болох ба удаан эдгэрч болзошгүй.
- **Хэвлийн шулуун булчингийн зайтай болохыг багасгах дасгалын жишээ:**
  - Ташаа өргөх дасгал (Pelvic Tilts):  
Нуруугаараа хэвтэж өвдгөө нугалан хэвтээд өгзөг болон нурууны ар хэсгийг шаланд наах хөдөлгөөнийг давтана.
  - Өвдөг өргөх дасгал (Knee Raises):  
Нуруугаараа хэвтэж нэг нэгээр нь өвдгөө цээж рүүгээ өргөнө.
  - Планк хувилбар дасгал:  
Хэвлийн доош харсан байрлалаас тохой болон хэлийн хурууны үзүүрээр тулж, биеэ шулуун байрлуулж хэвлийн булчиндаа хүч өгөх.



- Хэвлийн амьсгалын дасгал  
Газар дээр хэвтэж гэдсээ дүүргэн амьсгал авч, гаргахдаа хэвлийн булчингаа чангалах хөдөлгөөнийг давтан хийнэ.
- Гүүр дасгал (Bridge)  
Шал дээр хэвтэж өвдгөө нугалан, өгзгөө өргөх хөдөлгөөнийг давтан хийнэ.
- Кегелийн дасгал  
Умайн доод хэсгийн булчинг агшааж, сулруулах дасгал нь хэвлийн өмнөд хананы булчингийн тонусыг ч давхар чангалах үүрэгтэй.


② Аарцаг ёролын булчингийн үйл ажиллагааны алдагдал ба дасгал

- **Аарцаг ёролын булчин гэдэг нь:** давсаг, үтрээ, шээсний сүв, умай, шулуун гэдэс зэрэг эрхтнүүдийг доороос нь дэмжих ба эдгээр эрхтнүүдийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад туслана.

Аарцаг ёролын булчингийн үндсэн үүрэг нь:

- Бага аарцгийн хөндийн эрхтнүүд болон тэдгээрийн үйл ажилгааг дэмжих,
- Давсаг болон шулуун гэдэсний хумигч булчинг хянах,
- Хэвлийн дотор даралт нэмэгдэхэд тэсвэрлэх үүрэгтэй.

Эдгээр булчингийн уян хатан чанар алдагдвал давсаг болон шээсний сүвний дэмжлэг сулран шээс задгайрах (шээс барьж чадахгүй байх) шинж тэмдэг илэрч, цаашлаад бэлгийн харьцаанд ч сөргөөр нөлөөлнө .



- **Аарцаг ёролын булчингийн дасгал (Кегелийн дасгал)-ын зорилго**

Кегелийн дасгалыг жирэмсний дунд үеэс эхлэн төрсний дараа хүртэл тогтмол хийх нь тохиромжтой.

Ялангуяа байгалийн төрөлтийг хийсэн эмэгтэйчүүдэд аарцаг ёролын булчин холбоос сулардаг тул Кегелийн дасгал хийх нь илүү үр дүнтэй.

Энэ дасгалаар аарцаг ёролын булчингийн цусны эргэлт сайжирч, эсийн дахин төлжилт болон нөхөн сэргэлтэд тустай. Тогтмол хийснээр булчингийн уян хатан чанар сэргэж, шээс задгайралаас урьдчилан сэргийлэнэ.

Төрсний дараа энэ дасгалыг аль болох эрт эхлүүлж, өдөр бүр, өдөрт хэд хэдэн удаа тогтмол хийхийг зөвлөж байна..

- **Кегелийн дасгал хийх арга**

- Аарцаг ёролын булчинг гэдэс рүү дээш татаж байгаа мэт мэдрэмжээр доод хэвлийн булчингаа чангалах.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

- Энэ байдлыг 3 секунд барьж, дараа нь хүчийг суллан 3 секунд тайвшруулна.
- Тайвшруулах үед үтрээг зөөлөн онгойлгож байгаа мэтээр маш зөөлөн дүлнэ.
- Дасгалд дасмагц 10 секунд хүртэл барина.
- Нэг удаад 10-20 удаа давтана.
- Өдөрт олон удаа, аль болох их хийх нь сайн бөгөөд, дор хаяж өдөрт 3 удаа тогтмол хийнэ.



Эх сурвалж: Америкийн Эмэгтэйчүүдийн эмч нарын коллеж (ACOG)

③ Варикоз буюу хураагуур судсын өргөслийн үед дасгал хийх

8) Бэлтгэл дасгал

- Үндсэн дасгал хийхээс өмнө заавал бэлтгэл дасгалыг хийж өгөх ёстой. Бэлтгэл дасгал нь бие махбодыг физиологийн болон сэтгэлзүйн хувьд дасгал хийхэд бэлэн болгож, дасгалын үр нөлөөг нэмэгдүүлнэ. Маш удаан алхах зэрэг хөнгөн хөдөлгөөнийг 5-10 минут орчим бага ачаалалтайгаар хийнэ.
- Бэлтгэл дасгалаар биеийн температур нэмэгдэх нь физиологийн хэвийн байдал юм. Цусны эргэлт болон булчингийн температур зохистой түвшинд хүрч, уян хатан чанар нь сайжирч, зүрхний цохилт болон амьсгалын давтамж нэмэгдэж, дасгал хийж буй

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

булчинд цусны эргэлтийг нэмэгдүүлснээр үндсэн дасгалыг сайн хийх биеийн нөхцөлийг бүрдүүлнэ.

- Бэлтгэл дасгалын сэтгэлзүйн өөрчлөлт нь “Би чадна. Би дасгал хөдөлгөөнөөрөө сайн үр дүнд хүрнэ” гэх мэт эерэг бодол төрүүлэхснээр илүү үр дүнтэй.

9) Сунгалтын дасгал

① Сунгалтын дасгалын үр нөлөө

- Бэлтгэл дасгалын дараа сунгалт хийх нь шөрмөс, холбоос, булчинд очих цусны эргэлт болон хүчилтөрөгчийн хангамжийг сайжруулна.
- Сунгалтын дасгал хийхдээ огцом хөдөлгөөн хийхгүй, булчинг сулруулж, нэг байрлалыг 10 орчим секунд барьж өгнө.
- Бэлтгэл дасгал болон сунгалтын дасгал нь үндсэн дасгалын үед гарах боломжтой гэмтлээс урьдчилан сэргийлнэ.

② 10 минутын сунгалтын дасгал

№	Дасгалын нэр	Гүйцэтгэх арга
1	Мөрөө чихэнд наах	① Хөлөө мөрний хэмжээтэй алцайлган, гараа гуяныхаа хоёр талд сул унжуулан зогсоно. ② Чихээ мөрөндөө хүргэх мэтээр толгойгоо доош бөхийлгөнө. ③ 5 секунд байрлалаа хадгалсны дараа эсрэг талдаа давтана.
2	Эрүүгээ цээжинд хүргэх	① Хөлөө мөрний хэмжээтэй алцайлган зогсоно. ② Амьсгалаа гаргаж, толгойгоо урагш бөхийлгөж эрүүгээ цээжинд хүргэнэ. ③ 5 секунд байрлалаа хадгалсны дараа толгойгоо арагш гэдийлгэн ижил аргаар гүйцэтгэнэ.
3	Толгойгоо баруун, зүүн тийш эргүүлэх	① Хөлөө мөрний хэмжээтэй алцайлган зогсоно. ② Амьсгалаа гаргаж толгойгоо 90° өнцгөөр эргүүлнэ. ③ 5 секунд байрлалаа хадгалсны дараа эсрэг талдаа давтана.
4	Мөр эргүүлэх	① Хөлөө мөрний хэмжээтэй алцайлган зогсоно. ② Мөрөө 360°-аар аажмаар эргүүлнэ. ③ Эсрэг чиглэлд 5 удаа давтана.
5	Гараа ардаа сүлжиж цээжээ тэнийлгэх	① Гараа өгзөгнийхөө ард сүлжиж барина. ② Амьсгалаа гаргаж гараа доош татаж мөр, цээжээ тэнийлгэнэ.
6	Гараа толгой дээрээ сүлжиж цээжээ тэнийлгэх	① Гараа толгой дээрээ сүлжиж өргөнө. ② Амьсгалаа гаргаж гараа дээш сунгаж мөр, цээжээ тэнийлгэнэ.
7	Бүсэлхий сунгах	① Хөлөө мөрний хэмжээтэй алцайлган зогсоно. ② Биеэ урагш бөхийлгөж гараа аажмаар шалан дээр хүргэнэ. ③ Доод байрлалаа 5 секунд хадгална.

Эх болон нярайн эрүүл мэндийн асаргааны мэргэжилтэн бэлтгэх сургалтын гарын авлага

№	Дасгалын нэр	Гүйцэтгэх арга
8	Шилбэ сунгах	① Нэг хөлөө урдаа тавьж өвдгийг 40° орчим нугална. ② Нуруугаа шулуун байлгаж биеэ доош буулгана. ③ Хойд хөлийн өсгийг шаланд наана. ④ Шилбэ сунгаж байгааг мэдрэх хүртэл сунгалтаа хийнэ. ⑤ Нөгөө хөлөө мөн адил гүйцэтгэнэ.

### 10) Төрсний дараах дасгал

Хугацаа	Дасгалын байрлал	Аргачлал
Төрсний дараа 2 дахь өдрөөс		– Нуруугаараа шулуун хэвтэж, хоёр гараа биеийн хажуу дагуу байрлуулж, хөлөө өвдгөөр нугалан байрлуулна
		– Хамраар амьсгаа авч, амаар гаргахдаа Кегел дасгал хийж буй мэт шээсний сүв орчмын булчинг чангалж, эрүүгээ татаж, толгойгоо өргөнө. – Энэ үед далны яс хэт өргөгдөхөөс зайлсхийх.
	ТИР: Биеийн дээд хэсгийг бүрэн өргөх хэвлийн булчингийн дасгал нь нурууны өвдөлт үүсгэж болзошгүй тул хэвлийн дасгал хийх үед амьсгаагаа түгжихгүй байх (хэвлийн даралт үүсгэхгүй). Анхаарах зүйлс: Халуурсан эсвэл биед зовиур илэрсэн, сунгалт хийхэд өвдөлт мэдрэгдэх, эсвэл нуруу өвдөж байвал дасгалыг зогсооно.	
Төрсний дараа 3 дахь өдрөөс		– Нуруугаараа шулуун хэвтэж, хоёр гараа биеийн хажуу дагуу байрлуулж, хөлөө аарцгийн өргөнөөр салгах.
		– Амьсгаа авахдаа хоёр гараа хоёр тийш сунгаж, амьсгаа гаргахдаа хүйсээ нуруу руу татаж, хоёр гараа урд тал руугаа өргөнө. – Энэ үед мөрөө дотогш бөхийлгөхгүйгээр далны ясыг шал руу зөөлөн дарна.
	ТИР: Мөрний дээш доош хөдөлгөөнөөр хоёр гараа ташаа хүртэл буулгаад толгой дээгүүр өргөх дасгалыг хамтад нь хийвэл илүү үр дүнтэй. Анхаарах зүйлс: Нуруу хэт өргөгдөх эсвэл хавирга салах тохиолдолд хөдөлгөөний хүрээг хязгаарлаж, аажмаар нэмэгдүүлнэ.	

III. Эхийн хоол тэжээл ба дасгал хөдөлгөөний менежмент

Хугацаа	Дасгалын байрлал	Аргачлал
		<ul style="list-style-type: none"> <li>- Нуруугаараа хэвтэж, өвдөгөө нугалж, хөлөө аарцгийн өргөнөөр салгах.</li> <li>- Мөрөө шалан дээр байрлуулж, нуруу доор 4 хуруу орчим зай гаргах.</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>- Хамраар амьсгаа авч, амаар гаргахдаа өгзгөө өргөнө.</li> </ul>
		
	<p>Анхаарах зүйлс</p> <ol style="list-style-type: none"> <li>① Нуруунд хэт их хүч өгөхөөс зайлсхийж, мөр-тааз-өвдөг диагональ шулуун байдлыг хадгалан өгзгийг өргөнө.</li> <li>② Хэрэв гуяны арын булчинд хэт их ачаалал мэдрэгдэж байвал дасгал эхлэх байрлалд өгзөг ба хөлийн зайг ойртуулна.</li> </ol>	
<p>Төрсний дараа 4-6 дахь өдрөөс</p>		<ul style="list-style-type: none"> <li>- 반듯이 누워 두 다리를 골반 너비로 뻗어준다.</li> <li>- "Хамраар амьсгаа авч, амаар гаргахдаа өгзгөө өргөнө."</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>- Дөрвөн хөлийг ташааны өргөнөөр тэнийлгэн дээш харж хэвтэнэ.</li> <li>- Хамраар амьсгаа авч, амаар гаргахдаа эрүүгээ татан толгойгоо өргөж, хэвлийн булчингийн хүчээр хоёр хөлийг зэрэгцүүлэн босоогоор нь өргөн</li> </ul>
	<p>Анхаарах зүйлс</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Толгойг өргөхдөө мөр шилжихгүй байхыг анхаарч далны ясыг шаланд дарж өгнө.</li> <li>2. Хөлийг өргөхдөө аарцаг нь их бие рүү хэт өнхөрөхгүй байхаар төвийг сахисан байрлалыг хадгална.</li> </ol> <p>Хүлээгдэж буй үр дүн: Хэвлийн шулуун булчин болон мөрний булчинг сайжруулж, шилбэ, гуя зэрэг доод мөчдийн булчинг идэвхжүүлнэ.</p>	

Эх сурвалж: Төрсний дараах сувиллын үйлчилгээний гарын авлага, Эрүүд мэнд, нийгмийн хамгааллын яам & Хүүхдийн бодлогын судалгааны хүрээлэн (2024)

## 11) Аэробик дасгал

### ① Агаарын дасгалын ач холбогдол


- Хэрвээ жирэмсэн үедээ тогтмол дасгал хийгээгүй бол төрсний дараа хамгийн энгийн, хялбар дасгалаас эхлэн аажмаар илүү эрчимтэй дасгалд шилжих нь зүйтэй.
- Жирэмсэн үедээ тогтмол дасгал хийж байсан бол төрсний дараа өмнө нь хийж байсан дасгалаа дахин эхлэх нь зөв.
- Төрсний дараах агаарын дасгалыг эхлээд өдөр бүр 5-10 минут хийж эхлээд, долоо хоногт 5 өдөр 30 минут хүртэл аажмаар нэмэгдүүлнэ.
- Агаарын дасгалд хурдан алхалт, усанд сэлэлт, бүжиг, өрөөний суурин дугуй унах зэрэг дасгал тохиромжтой. (Blackburn, 1995)

### ② Агаарын дасгалын төрөл

- **Алхалт**
  - Алхалт нь төрсний дараа биеийн хэлбэрээ эргүүлэн олоход хамгийн зохимжтой дасгал. Эхлээд зөөлөн алхаж аажмаар хурдаа нэмж алхалтын хурдын нэмвэл зохимжтой.
  - Хүзүү, гарын булчинг сул тавьж гар өөрөө хөдөлж байхаар алхах, гишгэхдээ эхлээд өсгийгөөрөө дараа нь хөлийн улыг бүхэлд нь, эцэст нь хөлийн хуруугаа газарт хүргэнэ.
- **Дугуй унах**
  - Цаг агаараас үл хамааран, өрөөнд хийх хамгийн тохиромжтой дасгал бол суурин дугуй унах юм. Доод мөчдийн булчинд ачаалал өгч, өөх шатаах хөлийн галбир засах дасгал болдог.
  - Энергийн зарцуулалтаараа хурдан алхалттай адил боловч бие махбодод ирэх ачаалал харьцангуй бага тул таргалалт, үе мөчний үрэвсэл, хөлний булчин султай, нурууны мурилттай, яс сийрэгжилттэй хүмүүст илүү тохиромжтой.
  - Нуруугаа эгцэлж, тэгш байрлуулж, педаль бүрийг зөв хөдөлгөөнөөр жигд гишгэнэ.
  - Эхний 5 минут удаан гишгэж, дараа нь 5 минутанд хурдан, ингэж ээлжлэн 30 минут ба түүнээс дээш хугацаанд үргэлжлүүлбэл үр дүнтэй.
- **Усанд сэлэлт**
  - Усанд сэлэлт нь бие махбодод бага ачаалал өгдөг, огцом чиглэл өөрчлөлт шаардахгүй, тэнцвэрийн өндөр мэдрэмж шаарддаггүй тул цохилт бага дасгал юм.
  - Бие махбодод бага ачаалал өгбисийн тэсвэр болон зүрх, уушгинд тохирсон ачаалал өгснөөр цусны эргэлт сайжруулж, булчингийн хүчийг нэмэгдүүлдэг.

12) Дасгалын дараах тайвшруулах дасгалын арга, ач холбогдол

- Дасгалын дараа үйл ажиллагаагаа аажмаар багасгаж, дасгалаа дуусгах тайвшруулах хугацааг заавал авна.
- Зүрхний цохилтыг хэвийн (60-100 цохилт/минут) хэмжээнд буулгах хүртэл тайвшруулах дасгал хийдэг.
- Тайвшруулах дасгал нь бие халаалттай төстэй бөгөөд аажим алхах зэрэг хөнгөн хөдөлгөөн хийхийг хэлнэ.



